



НЭР ТӨР, ШУДАРГА ЁСЫГ ХҮН БҮРТ

АГУУЛГА

Монгол Улсын Ерөнхийлөгч Намбарын Энхбаярын чуулганд оролцогчдод хандаж хэлсэн үг	3
НҮБ-ын суурин зохицуулагч, НҮБХХ-ийн суурин төлөөлөгч Дебора Коминигийн хэлсэн үг.	7
Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Солонгын хэлсэн үг.	11
“Хохирогчийн эрхийн баталгаа” сэдвээр зохион байгуулсан үндэсний чуулганаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт, үр дүн Илтгэгч: Г.Баясгалан - ХЗДХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга	14
“Төрийн байгууллагын үйл ажиллагаанд ил тод байдлыг хангах нь хүнд суртал, авлигатай тэмцэх нэн тэргүүний арга хэмжээ мөн” Илтгэгч: Ч.Сангарагчаа - Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар	20
“Захиргааны байгууллагууд дахь хүний эрх ба хүнд суртал” “Хүний эрх ба иргэний бүртгэл” Илтгэгч: Л.Мөнхбаатар ИБМУТ-ийн дарга	25
“Хүний эрх ба төрийн албан хаагчийн гомдол, маргаан шийдвэрлэлтийн өнөөгийн байдал, анхаарах зарим асуудал” Илтгэгч: Ж.Норовсамбуу - Төрийн албаны зөвлөлийн дарга	30
“Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хүнд суртлыг бий болгож буй зарим асуудал” Илтгэгч: М.Ариунбаяр - АМГТХЭГ-ын орлогч дарга	38
“Гаалийн байгууллагын ил тод байдал ба хүний эрх” Илтгэгч: Д.Оюунчимэг - Гаалийн ерөнхий газрын дэд дарга	43
“Нээлттэй газрын харилцаа” Илтгэгч: Ц.Сандуй - Нийслэлийн газрын албаны дарга	47

“Өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүнд суртал” Илтгэгч: Б.Ганбаатар - МӨХ-ны удирдах зөвлөлийн гишүүн, “Элч” хууль зүйн товчооны захирал	54
“Төрийн захиргааны байгууллага дахь хүнд суртал” судалгааны дүн Илтгэгч: Д.Солонго - МУИС-ийн ХЗС-ийн төр, захиргааны эрх зүйн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн ухааны доктор, профессор	63
Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар, Хүний Эрхийн Үндэсний Комисс, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр хамтран зохион байгуулсан “Хүний эрх ба хүнд суртал” үндэсний чуулганаас гаргасан зөвлөмж	75
Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдсаны 60 жилийн ойн хүрээнд Хүүхдийн хорих ангид зохион байгуулсан “Миний гэмшил, ухаарал” сэдэвт зохион бичлэгийн уралдаанд түрүүлсэн бичлэгээс	82
Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдсаны 60 жилийн ойн хүрээнд хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудын дунд зохион байгуулсан “Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал-Хүний эрхийн баталгаа болох нь” сэдэвт зохион бичлэгийн уралдаанд түрүүлсэн бичлэгээс	86

“ХҮНИЙ ЭРХ БА ХҮНД СУРТАЛ” СЭДЭВТ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНД МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯРЫН ХЭЛСЭН ҮГ

Үндэсний чуулганы хүндэт зочид, төлөөлөгчид өө,
Ноёд, хатагтай нар аа,

“Хүний эрх ба хүнд суртал” сэдвийн дор зохион байгуулж байгаа энэхүү Үндэсний чуулганд хүрэлцэн ирсэн Та бүхэнд чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Энэ чуулганыг хамтран зохион байгуулж байгаа Хүний эрхийн үндэсний комисс, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн удирдлага, ажилтнуудад талархал илэрхийлье.

Хүнийг үндэс угсаагаар нь ялгаварлан гадуурхах, эрүүдэн шүүх, тамлан зовоох, бүлэглэн устгах, төрөл бүрийн туршилтанд ашиглах зэрэг хүний эрхийг түүхэнд хамгийн хүнд хэлбэрээр зөрчиж, аймшигт ул мөр үлдээсэн Дэлхийн 2 дугаар дайны дараахан байгуулагдсан НҮБ-аас анх тэргүүнд батлан гаргасан онцгой ач холбогдол бүхий олон улсын эрх зүйн баримт бичиг бол Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал юм. Энэ Тунхаглалд хүн төрөлхтөн өөр хоорондоо хүнлэг харьцах, хандахын үндсэн шалгуур, шаардлагуудыг тусгаж, хүний эрхийг дээдлэн хүндэтгэх, чөлөөтэй эдлүүлэх үзэл санааг дэлхий дахинаа дэлгэрүүлэн, нийтээр хүлээн зөвшөөрүүлэх талаар түүхэн чухал алхам хийсэн юм.

Тэр үеэс хойш 60 жил өнгөрсөн боловч Хүний эрхийн түгээмэл тунхаглалын ач холбогдол улам бүр нэмэгдсээр байна. Хүний эрхийн олон улсын өдөрт зориулан зохион байгуулж байгаа энэхүү чуулган тус баримт бичгийг батлан гарсны түүхэн ойн жил болж байгаагаараа онцлог юм.

Хүнд суртлаас ангижрахыг хүний эрхийг харгалзахгүйгээр, хүний эрхийг хангахыг хүнд суртлыг багасгахтай холбохгүйгээр авч үзэх боломжгүй юм. Хүнд суртал оршин байгаа цагт хүн эрхээ ёсоор нь эдэлж, хэрэгжүүлж чадахгүй нь ойлгомжтой.

Бид энэ удаа хүн эрхээ эдлэх зам дээр нь “бул чулуу” болон тээглэж, хөндөлдөн зовоодог “хүнд суртал” гэдэг үзэгдлийн оршин байгаа шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, түүнийг төрийн албаны бүх шатнаас арилган цэвэршүүлэх ямар арга зам байгаа талаар шүүн хэлэлцэхээр чуулж байна.

Гэхдээ “хүнд суртал” гэдэг үгийн хувьд төрийн албаны зайлшгүй шатлал, захирах захирагдах ёсны зохистой тогтолцоог илэрхийлсэн гадаад үгний буюу bureaucracy-ийн

шууд орчуулга хэмээн зарим хүмүүсийн ойлгодог тэр утгаар нь авч үзээгүй юм. Харин тэр зайлшгүйгээс илүүдсэн, зохистойгоос хэтэрсэн, олон нийтэд төвөг чирэгдэл учруулдаг зүй бус тогтолцоо, үйл ажиллагаагаар илэрдэг сөрөг үзэгдэл гэж олон нийтийн ойлгодог болсон агуулгаар нь авч үзэж байгаа юм. Энэхүү чуулганд зориулж явуулсан судалгааны санал асуулгад оролцсон хүмүүсийн дийлэнх хувь нь хүмүүсийн сэтгэлийг хамгийн их зовоодог нийгмийн сөрөг үзэгдлүүдийн нэг нь “хүнд суртал” мөн гэсэн сэтгэгдэлтэй байдгаа илэрхийлсэн нь олон нийтийн дунд “хүнд суртал”-ын талаарх хэвшсэн ойлголтыг давхар баталж байна.

1992 онд баталсан ардчилсан Үндсэн хуульд манай иргэдийн эдлэх эрхийг олон улсын эрх зүйн хэм хэмжээнийхээс дутуугүйгээр тусгасныг гадаад, дотоодын эрдэмтэд, судлаачид хүлээн зөвшөөрдөг юм. Мөн Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн хүний эрхийг чиглэл, чиглэлд баталгаажуулсан хууль тогтоомжууд чамлахааргүй олныг боловсруулан баталсан билээ. Энэ талаас нь буюу тоон үзүүлтээс харвал хүний эрхийг баталгаажуулан хангах ажил манай улсад гайгүй түвшинд байгаа гэж хэлж болно. Гэвч өнөөдөр бидэнд тоо нь биш чанар нь чухал юм. Харамсалтай нь тэр олон хууль тогтоомж амьдралд бодит байдлаараа хэрэгжиж байгаа эсэх талаар судалваас судалгааны дүн, олон нийтийн үнэлэмж аль аль нь тааруу үзүүлэлттэй байна.

Хүн хууль ёсны эрхээ хэрэгжүүлэхэд саад болдог хүнд суртал гол нь төрийн албаны үйлчилгээтэй холбогдож яригдах ёстой. Иргэд өөрийнхөө эрхийг хангуулах гэж, ажил үйлсээ бүтээлгэх гэж, аливаа хэрэгцээт үйлчилгээ авах гэж төрийн байгууллагыг өгч буй татвараараа санхүүжүүлэн ажиллуулдаг. Гэтэл төрийн байгууллага, албан тушаалтан тэр үйлчилгээний зохих шаардлагыг хангахгүй байх нь эргээд хүний эрхийг боогдуулан бусдыг чирэгдүүлэх, улмаар тэднийг бухимдуулан уурлуулах, итгэл алдан цөхрөөх байдалд хүргэж, үүний үр дагавар янз бүрийн хэлбэрээр хүмүүсийн ахуй амьдралд нөлөөлж байна.

Ажлаа бүтээх гэсэн иргэд үүд хаалга болгоныг сахихад хүрч, цаг заваа бардаг, тэр хаалгануудаар цааш нэвтрэн орсон ч шийдвэртэй хариу сонсдоггүй зэрэг нь тухайн хүн зүй ёсны эрхээ эдлэхдээ ямар хүнд хэцүү нөхцөлд ордогийг бэлхнээ харуулж байна. Цаг хугацааг хэр зэрэг үр ашигтай ашигласны хэрээр хүний ашиг орлого, алив үйл хэргийнх нь амжилт хэмжигддэг болсон өнөө үед ийнхүү чирэгдүүлэн саатуулах нь наад зах нь зах зээлийн өрсөлдөөнд тэгш боломжтой оролцох хүний эрхийг шууд хязгаарлаж байгаа юм. Түүнээс үүсэх хохирлыг урьдчилан тооцохын аргагүй. Байшин барих байсан бол тааламжтай улирал нь дуусна, материал, ажлын хөлсний төлөвлөлтөд нь өөрчлөлт орж, зардал нэмэгдэнэ, тэр ч байтугай энгийн замаар бүтэж амьдралд нь нэмэр болох байсан

ажил хэрэг бүтэхгүй болж ч болно. Надад ирж байгаа өргөдөл, гомдлуудаас харахад энэ мэт тохиолдлуудыг эрж хайхын хэрэггүй амьдралд элбэг тохиолддог байна.

Хүмүүсийн ярьж шүүмжилж байгаа, судалж тэмдэглэсэн зэргээс харахад хууль тогтоомжийн хэрэгжилтэд бага ач холбогдол өгдөг, ажлын удирдлагын менежмент цалгар назгай, албан хаагчийн хариуцлага, ёс зүй сул зэрэг албан хаагчдаас шалтгаалах олон хүчин зүйлүүд байна. Нэгтгэн үзвэл бүх шатны аливаа үйл ажиллагаа нь хатуу дэг журам, үйлчилгээний стандарт хангасан чанд горимтой байх учиртай төрийн албанд дур зоргын хандлага газар авсан байна. Гэтэл төрийн албаны ажлыг зоргоороо биш, журмаар явуулах учиртай.

Төрийн албан хаагчдаас шалтгаалах хүнд суртал нь төрийн албан хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлыг хавчуулж, шан харамж буюу авлига авдаг арчаагүй, ёс зүйгүй байдалтай холбоотой байна. Бас мэдлэг туршлага байвч ажилдаа хайнга, ард иргэдэд хойрго хандан сул цалин авч, хоног хороож зуршсан үлгэн салган ажилтнуудаас ч болж байна. Эрх мэдлийг зөвхөн амин хувьдаа ашиг хонжоо гаргахад хэрэглэж сурсан, бусдын төлөө ургаа хад шиг, өөрийнхөө төлөө уургын морь шиг болсон ёс суртахууны доройтолд автсан хүмүүс ч байна. Бас намчирхал, танил талын шугамаар төрийн албанд үүдээр нь биш тооноор нь орж ирсний харгайгаар ямар ажил үүрэгтэйгээ ойлгодоггүй, ойлголоо ч албан үүргээ биелүүлэх чадвар үнэхээр мөхсөөсөө болоод төрийн албан дотор толгой нь эргэж, эргүү хурга шиг төөрөлдөн будилж яваа нэгэн ч байдаг бололтой. Төрийн албанаас хүнд суртлыг зайлуулахын тулд эхний ээлжинд төрийн бүх шатны албанд хэн ажиллаж, иргэдэд хэрхэн үйлчилж байна вэ, хэн нь шаардлага хангаж, хэн нь хангахгүй байгааг тогтоож дур зоргыг таслан зогсоож, дүрэм журманд оруулах шаардлагатай байна.

Хүнд суртал нь эрх зүйн зохицуулалт, албаны тогтолцоо, ажлын зохион байгуулалтаас ихээхэн шалтгаалдаг нь тодорхой. Төрийн үйл ажиллагаа илүүдэл олон шат дамжлагатай, хэрээс хэтэрсэн олон тооны дүрэм журмаар зохицуулагдсан, хяналт хариуцлагын зохистой тогтолцоогүй байх, ажлын байрны чиг үүрэг, зориулалт нь тодорхойгүй, төрийн албад хоорондын уялдаа холбоо сул байх зэрэг ердийн албан хаагчаас үл шалтгаалан хүнд суртлыг төрүүлдэг, хүчин зүйлүүд ч бас байгааг судалгаа харуулж байна. Энэ нь үндсэндээ, эрх зүйн зохицуулалт, төрийн албаны тогтолцоо, ажлын зохион байгуулалттай холбоотой асуудлууд юм. Иргэд тавьсан асуудлаа шийдвэрлүүлэхдээ иймэрхүү тогтолцооны шинжтэй “хүнд суртал”-тай учирч, түүнийг тойрох аргагүй тул авлигын замыг сонгох, танил талаараа зуучлуулах, гуйх, аргадах, уурлаж тэмцэх зэрэг байж болох бүхий л арга замыг эрэлхийлэхэд хүрдэг байна.

Төрийн албаны тогтолцоо, ажил үйлчилгээ нь юуны түрүүн олон нийтэд ойлгомжтой, хүртээлтэй байх ёстой. Төрийн албаны тогтолцооноос хүнд суртлыг үүсгэж байгаа эдгээр дутагдал, зөрчлүүдийг арилгах нь өнөөгийн байдлаар нэн тулгамдсан асуудал болоод байна. Миний санаачлагаар төрийн албанд нээлттэй хаалганы өдрийг санаачлан нэвтрүүлснээр төрийн яам, агенлагууд иргэдэд шууд, чирэгдэлгүй үйлчлэх эхлэл тавигдаж, энэ үйл ажиллагаа харьцангуй тогтмолжиж байгаа нь сайн хэрэг. Гэхдээ бусад үед нь ийм байж чадаж байгаа, эсэх нь зохицуулалт, тогтолцоо, зохион байгуулалтын хувьд нээлттэй болж чадсан, эсэхээс шууд шалтгаална. Нээлттэй хаалганы өдрийг санаачлахдаа би төрийн албанд хүнд сурталгүй болох тэр зохистой тогтолцоо бүрдүүлэхийг зорьсон юм. Зарим өдөр сүрхий сайн үйлчлээд, бусад үед нь бахь байдгаараа байж хэрхэвч болохгүй.

Хүндэт ноёд, хатагтай нар аа,

Төрийн албыг шударга, шуурхай ажиллуулж, нийгмийн шударга ёсонд бүрнээ нийцсэн үйлчилгээ үзүүлдэг болгох нь бид бүхний нэгдмэл зорилго юм. Төрийн албаны хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг би энэ онд санаачлан батлуулахдаа төрийн албан хаагчдыг улс төрийн зүй бус нөлөөллөөс зааглахын тулд намын харьяалалгүй болгох, төрийн албан хаагчдын мэргэшсэн тогвортой ажиллагааны баталгааг сайжруулах, төрийн албаны төв байгууллагын эрх хэмжээг нэмэгдүүлэх зэрэг шинэтгэлийн шинжтэй цогц арга хэмжээ авсан. Одоо энэ хуулийг мөн чанарынх нь дагуу хэрэгжүүлж ажиллах нь чухал байна. Хууль тогтоомжийн шинэтгэлийг, үйл ажиллагааныхтай нягт уялдуулан төрийн албанд “хүнд суртал” орогнох бүх шалтгаан, нөхцөлийг арилгахад цаг хугацаа алдах нь хүний эрх, хөгжлийн эрх ашгийн аль алинд нь ихээхэн хохиролтой тусна. Хүний эрхийг хангахын тулд авсан арга хэмжээний үр дүн болгон хөгжил болж хувирдаг нь ардчилсан нийгмийн жам билээ. Хүнд суртлаар хүний эрхийг боогдуулдаггүй, төр, иргэний итгэлцэлд суурилсан шударга, хүнлэг нийгмийг хамтдаа цогцлоохыг та бүхэнд хандан уриалж байна.

“Хүнд суртал ба хүний эрх” үндэсний чуулганы ажиллагаанд амжилт хүсье.

Хүний эрхийг дээдэлж, хөгжил дэвшилд хүрэх зам маань дардан болох болтугай.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**“ХҮНИЙ ЭРХ БА ХҮНД СУРТАЛ” ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНД
МОНГОЛ УЛС ДАХЬ НҮБ-ЫН СУУРИН ЗОХИЦУУЛАГЧ
ХАТАГТАЙ ДЕБОРА КОМИНИГИЙН ХЭЛСЭН ҮГ**

Хүндэт ноён Ерөнхийлөгч Намбарын Энхбаяр
Чуулганы Хүндэт төлөөлөгчид өө,

Монгол улс дахь НҮБ-ын суурин төлөөлөгчийн газрын нэрийн өмнөөс Хүний эрхийн үндэсний 4 дүгээр чуулганд оролцогчид Та бүхний амар амгаланг эрье. Энэ жилийн чуулган ХЭТТ батлагдсаны 60 жилийн ойтой давхцаж байна.

Энэхүү үйл явдлыг дэлхий даяар НҮБ-ын гишүүн орнуудад өргөн хүрээнд тэмдэглэж байгаа бөгөөд “Нэр төр, шударга ёсыг хүн бүрт” гэсэн уриан дор зохион явагдаж буй ойн арга хэмжээний агуулга санаа, өнөөдрийн хүний эрхийн чуулганы сэдэв мөн адил уг уриан дор нэгдэж байна.

Юун түрүүнд, хүний эрхийн үндэсний чуулган нь Монгол улсад хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих, ардчилсан засаглалыг бэхжүүлэх зорилготой Мянганы хөгжлийн 9 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэж байгаа гэдэгтэй Та бүхнийг санал нэг байгаа гэдэгт итгэлтэй байна.

2005 онд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Ази Номхон Далайн Хүний Эрхийн Үндэсний Байгууллагуудын 10 дахь удаагийн чуулганаар Монгол улсад хүний эрхийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэх зорилтыг дэвшүүлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газраас жил бүр Хүний эрхийн үндэсний чуулган зохион байгуулах ажлыг анхлан санаачилсан билээ. Тэр үеэс хойш Хүний эрхийн үндэсний чуулган нь тухайн жил бүр хүний эрхийн анхаарал татахуйц асуудлуудаар зөвлөлдөх улмаар бодлогын түвшинд өөрчлөлтийг бий болгох боломжийг бүрдүүлэх, түүнчлэн 2004 оны 10 сард УИХ-аас баталсан Хүний Эрхийг Хангах Үндэсний Хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах нэгэн чухал хэрэгсэл болж ирлээ.

Хүний эрхийн үндэсний чуулганаас гарах үр дүн нь хэлэлцэж байгаа сэдвийнхээ хүрээнд хүний эрх, эрх чөлөөг сайжруулан бэхжүүлэхэд чиглэгдсэн бодлогын зөвлөмжүүдийг хэлэлцэн батлахад оршино. Өнөөдөр Та бүхэнд чуулганы төлөөлөгчийн хувьд өнгөрсөн жилийн чуулганаас дэвшүүлсэн зөвлөмжийн биелэлтийг хэлэлцэж, энэ удаагийн чуулганы сэдвийн хүрээнд санал бодлоо хуваалцан ирэх онд хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулах чухал боломж олгогдож байна. Та бүхний идэвхитэй оролцоо нь

Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулна гэдгийг цохон тэмдэглэмээр байна.

НҮБ нь энэхүү чухал үндэсний санаачлагыг эхнээс нь дэмжин түншилж ирсэндээ бахархалтай байгаа бөгөөд Мянганы Хөгжлийн Зорилтуудын хэрэгжилтийг хангах, Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг бэхжүүлэхэд дээрх олныг оролцуулсан үйл ажиллагаанууд нэн чухал юм. Олон нийтийн оролцоо, зөвлөгөөн болон түншлэлийг нэмэгдүүлснээр хүн бүрийн нэр төрийг хүндэтгэх, шударга ёсыг хангах нөхцлийг бүрдүүлнэ.

Хүндэт нөхөд өө,

Энэ жилийн үндэсний чуулганаар хүний эрхийг хангахад тулгараад буй бэрхшээл зарим нэг зохисгүй, шударга бус байдал нь хүний эрх, эрх чөлөөнд хэрхэн нөлөөлж байгааг хэлэлцэхээр тодорхойлон тогтсон билээ.

Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх нь өнөөгийн Засгийн Газрын тэргүүлэх чиглэл учир өнөөдрийн чуулганы сэдэв нь цаг үеэ олсон авлигатай тэмцэх бодлогыг боловсруулахад олон нийтийн оролцоог хангахад чиглэсэн байна. Тиймээс өнөөдрийн хуралдаанаар хүний эрх ба авлигын харилцан хамаарлыг онцлох шаардлагтай билээ.

Хүний эрхийг хамгаалах тогтолцооны дутагдалтай байдал нь авлигыг бий болгох нөхцлийг бүрдүүлж байгааг анхаарах хэрэгтэй байна. Ийнхүү хүний эрхийг хамгаалж, хөхиүлэн дэмжих идэвхитэй үйл ажиллагаа нь авлигаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй стратеги юм.

Олон улсын хамтын нийгэмлэг хүний эрх болон авлигын эсрэг хөдөлгөөн хоёрын аль алинтай нийтлэг олон зарчмуудыг боловсруулсан бөгөөд үүний талаар өнөөдрийн илтгэгч та нарт илүү нарийвчлан танилцуулах болно. Эдгээр нийтлэг зарчмуудын дотор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, иргэний болон улс төрийн эрх, мэдээлэл олж авах эрх гэх мэт эрхүүд багтдаг ба ганц дээрх эрхүүдээр хязгаарлагдахгүй. Хүний эрхийн байгууллагууд нь иргэн бүр мэдээлэл чөлөөтэй, саадгүй олж авах эрхийг хангахад чухал үүрэг гүйцэтгэж болох юм.

Иймд эдийн засгийн боломж хомс, мэдлэг дутмаг нийгмийн эмзэг бүлгийнхний мэдээлэл олж авах эрхийг хангах нь нэн чухал байна. Түүнчлэн төрийн албаны сонгон шалгаруулалт, ашиг сонирхлын зөрчил, бодлого боловсруулах явц, төсвийн зарцуулалт,

худалдан авалт, сонгуулийн санхүүжилтийн талаар мэдээлэл авах эрх нь хангагдсанаар авлига бий болох нөхцөл хумигдана.

Хуулийн хүрээнд шийдвэрлэгдэх үндэслэлгүй, зүйлчлэгдээгүйн улмаас зарим шударга бус үйл ажиллагаа нь хууль сахиулах механизмаар шийдвэрлэгдэхгүй байсаар байна. Гэсэн хэдий ч эдгээр байдлыг хүний эрхийн хүрээнд авч үзсэнээр шийдвэрлэх боломж бий болох юм.

Ядууралд нэрвэгдсэн хүмүүсийн ихэнх нь эмэгтэйчүүд байдаг. Үүнийг албан болон албан бус хөдөлмөрийн зах зээлд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс бага цалин авдаг байдлаар нь тайлбарлаж болох бөгөөд сурч боловсрох, газар эзэмших, зээл авах болон хүйсийн ялгаварлалаас үүсэн гарах бусад эд хөрөнгө хүртэх бололцоо нь хомс байдаг. Мөн эмэгтэйчүүд нь хүүхэд, хөгшчүүдийг харж асрах хариуцлагыг өөр дээрээ авах хандлагатай байдаг нь зардлаа нөхөх болон ажил олоход нь илүү их хүндрэл учруулдаг.

Эмэгтэйчүүдийн төлөөллийн хэмжээ нь нийгмийн хамгийн ядуу хэсэгт их, харин шийдвэр гаргах түвшинд бага байгаа нь тэдгээрийг эрчүүдээс илүү авлига, янз бүрийн дарамт шахалтад өртөхөд нөлөөлж байна.

Авлига нь ядуурлын эсрэг төрийн бодлогод хэрэглэж болох олон нийтийн хөрөнгийг өөр зүйлд шилжүүлдэг ба уг бодлогоос ихээхэн хамааралтай байдаг эмэгтэйчүүд болон бусад хүмүүсийн амьдралд хэтэрхий хүндээр тусч байна.

Нэмж хэлэхэд, нийгэмд гүйцэтгэж буй үүргийнхээ хувьд эмэгтэйчүүд ихэвчлэн асран халамжлагч байдаг тул нийгмийн халамжийн үйлчилгээнээс шалтгаалах хамаарал нь албан тушаалтны авлигын хохирогч болоход нөлөөлж байна. Жишээлбэл жирэмсэн эмэгтэйчүүд тодорхой эмнэлэгийн үйлчилгээ авах шаардлагатай байдаг, гэтэл энэ нь эрүүл мэндийн салбар дахь авлигад өртөж болзошгүй болдог.

Авлига нь хүүхдүүдэд ч хүндээр нөлөөлж болох ба хүүхдүүдийн томчуудын нэгэн адил эдлэх ёстой амьд явах эрх, сурч боловсрох эрх, эрүүл байх зэрэг эрхүүдийг зөрчиж болзошгүй байна. Авлигад автсан үйл ажиллагааны улмаас хүүхдийн бусад эрх, тэр тусмаа үрчлэлийн явцад хүүхдийн хамгаалуулах эрх, хүний наймаа болон бэлгийн мөлжлөгөөс хамгаалуулах эрх, хүүхдийн хөдөлмөрөөс хамгаалуулах эрх зэрэг эрхүүд нь хөндөгдөж байна..

Авлигын үйлдлийг хүний эрхийн зөрчилтэй холбосноор бидэнд зохих арга хэмжээ

авах бололцоог нээж өгч байна. Нэн ялангуяа хүний эрхийн хэрэгжилтийг хянадаг үндэсний, бүсийн болон олон улсын арга хэрэгслүүдийг ашиглан шийдвэрлэж болох юм.

Авлигын хэргийг хүний эрхийн арга хэрэгслээр дамжуулан шийдвэрлэснээр уг хэрэгт илүү их ач холбогдол өгөх бөгөөд энэ нь тухайн улсад урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, авлигад автсан албан хаагчдыг эрх мэдлээ урвуулан ашиглах явдлыг зогсоох хүчин зүйл болно.

Нэгдсэн Үндэстний Байгууллага нь хоёр өөр төрлийн хүний эрхийн хэрэгсэл бий болгосон. Тэдгээрийн журамд үндэслэсэн хэрэгсэл нь Тогтмол Тойм болон Хүний Эрхийн Зөвлөлийн Тусгай Илтгэгчүүд юм. Гэрээн дээр үндэслэсэн хэрэгслүүд нь гэрээний хэрэгжилтийг хянах олон улсын хүний эрхийн гэрээний дагуу байгуулагдсан хороодоос бүрдэх бөгөөд тэдгээрт Хүний Эрхийн Хороо, Эдийн засаг, Нийгэм ба Соёлын Эрхийн Хороо, Эмэгтэйчүүдийг Ялгаварлан Гадуурхах Бүх Хэлбэрийг Устгах Хороо болон Хүүхдийн Эрхийн Хороо багтдаг. Тиймээс эдгээр арга хэрэгслүүд нь мэдлэг дээшлүүлэхээс гадна авлигад идэгдсэн үйл ажиллагааг зогсоох болон авлигын хэргүүдэд хариуцлага тооцох явдлыг хөхиүлэн дэмжих болно.

Хүндэт оролцогчид оо,

Авлигыг хүний эрхийн зөрчил гэдгийг харуулснаар олон нийтийн хандлагыг өөрчилж, ингэснээр авлига нь олон нийтийн болон хувь хүний ашиг сонирхолд хэр их хор хохирол учруулдаг талаар иргэдийн мэдлэг дээшлэх болно. Ихэнх хүмүүс авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, үндэсний хөтөлбөрийг дэмждэггүй. Гэтэл авлига, хүний эрх хоёрын хоорондох уялдаа холбоог тодорхойлсноор албан хаагч, их хурлын гишүүд, шүүгчид, прокурорууд, хуульчид, аж ахуй эрхлэгчид, хэвлэл мэдээллийн төлөөлөгчид болон олон нийтийг авлигын эсрэг илүү хүчтэй тэмцэхийг ухуулан сурталчилах нь Монгол Улсад шударга ёс, нэр төрийг хөхиүлэн дэмжихэд нэн чухал ач холбогдолтой юм.

12 сарын 10-нд болох ХЭТТ-ын 60 жилийн ойг дэлхий дахинаа тэмдэглэн өнгөрүүлэх кампанит ажил өндөрлөх дөхөж байна. Иймээс энэ боломжийг ашиглан хүний эрхийн өдрийг Та бүхэнд дурсах зүйлтэй, олон үйл явдлаар дүүрэн тэмдэглэхийг хүсэн ерөөе.

Чуулганы үйл ажиллагаанд амжилт хүсье.

Баярлалаа.

“ХҮНИЙ ЭРХ БА ХҮНД СУРТАЛ” СЭДЭВТ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНД ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА Д.СОЛОНГЫН ХЭЛСЭН ҮГ

Эрхэм Ерөнхийлөгч өө!

Чуулганы хүндэт зочид, төлөөлөгчид өө!

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Ерөнхийлөгчийн Тамгын Газар, ХЭҮК, НҮБХХ-ийн газартай хамтран зохион байгуулж буй “Хүний эрх ба Хүнд суртал” үндэсний чуулганд хүрэлцэн ирсэн Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Төрийн тэргүүний ивээл дор зохион байгуулагдаж байгаа энэ чуулганаар манай улсын төрийн байгууллагууд дахь хүнд суртлын өнөөгийн түвшин, шалтгаан нөхцөлийг тодорхой судалгааны үндсэн дээр тал бүрээс нь шүүн хэлэлцэх гэж байна.

Монгол хэлнээ “хүнд суртал” гэж орчуулагдсан “Bugeauscasu” хэмээх үг эртний Ромын Эзэнт гүрний үеэс улбаалан зуун зуунаар дамжин хувьсаж илүү гүн гүнзгий утга санааг агуулах болж хүн төрөлхтний өөрийгөө удирдан залах аргыг боловсронгуй болгоход хувь нэмрээ оруулж ирсэн байна. Оросын яруу найрагч Владимир Маяковскийн “Хэт хуралдагсад” хэмээх шүлэгт өдөр бүр шалих шалихгүй зүйл дээр биеэ хуваан хуралдаж иргэдтэй уулзах цаг завгүй болсон түшмэдийн тухай өгүүлдгийг Та бүхэн санаж байгаа байх. Энэ нь хүнд суртал он удаан жилийн туршид оршин тогтсоор байгаагийн илрэл юм. Энэ үзэгдэлтэй түүхийн бүхий л үед хүн төрөлхтөн өдөр тутмын ажил, амьдралдаа нүүр тулж түүнтэй тэмцэх арга замаа ч нарийсгасаар ирсэн байна.

Хүнд суртал бол монголын нийгэмд хаа сайгүй байгаа бодит үзэгдэл бөгөөд төрийн үйлчилгээг цалгардуулж, бухимдал, чирэгдэл үүсгэж хүний эрхийг зөрчиж, улмаар хээл хахууль, авлигад хүргэж олон сөрөг үр дагаврыг бий болгож нийгмийн үндсийг ганхуулсан үзэгдэл болоод байна.

Хаана хариуцлага, сахилга сул байна тэнд хүнд суртал, авлига газар авч байдаг нь энгийн ухагдахуун юм. Үүний цаана хүний эрх ямагт хөндөгдөж байдаг учраас хүнд сурталтай тэмцэхэд хүний эрхийн байгууллага анхаарлаа хандуулж байна.

Макс Веберийн тодорхойлсон “түшмэл ёсыг” хууль ёс, технологиос салгаж, хариуцлагагүй, сахилгагүй, чадваргүй байдлаар орлуулснаар хүнд суртал гэсэн гаж үзэгдэл үүсч байна. Үүний гол шалтгаан нь хууль ёсыг яв цав хэрэгжүүлээгүйтэй шууд холбоотой. Хууль ёс хэрэгжихгүй орон зайд зөвхөн дур зорго үйлчлэх нь ойлгомжтой юм. Нөгөө талаас хууль тогтоомжийн уян, боловсронгуй бус байдал ч нөлөөлж байгааг

үгүйсгэхгүй. Тийм учраас социологич Мишель Крозье аливаа байгууллага дахь эрх зүйн хувьд тодорхой бус байдал нь эрх зүйн хийдлийг бий болгож, улмаар албан хаагчид нь тэр орон зайгаар өөрсдийн хувийн ашиг сонирхлыг хэрэгжүүлж, өөрийн үзэмжээр үйлдэл хийх эрх чөлөөг бий болгодог гэж хэлсэн байдаг. Тэгэхээр хүнд суртал бол нийгмийн үзэгдэл гэхээсээ илүү “түшмэл ёс”-ны гажсан орон зайгаар тэжээгдэж байдаг “төрийн өвчин” гэж хэлж болохоор байна. Макс Веберийн үзлээр хүнд суртлыг бууруулахын тулд байгууллагын ажилтнуудын дунд ажил үүргийг мэргэшсэн чадвараар нь хуваарилах хэрэгтэй. Салбар бүр өөрсдийн хийх ёстой ажлын чиг үүргээ мэдсэн байх шаардлагатай бөгөөд хамгийн дээд боломжит хөдөлмөрийн хуваарилалт нь байгууллагын бүх цэгт мэргэшсэн ажилтны ашиглах, нөхцөл байдлыг бий болгодог байна. Тийм учраас эдгээр ажилтнууд өөрсдийнхөө чиг үүргийг үр нөлөөтэй гүйцэтгэж хариуцлагаа бүрэн хүлээж чаддаг.

Өнөөдрийн үндэсний чуулганыг угтан төрийн захиргааны болон хууль хяналтын байгууллагууд дахь хүнд суртал сэдвүүдээр хийсэн судлаачдын багийн судалгааны дүнгээс үзэхэд хүнд суртал нь төрийн албан хаагчийн идэвхи санаачлагагүй, чадваргүй байдал, түүнчлэн хувийн ашиг сонирхол, ил тод бус байдлаас үүдэн бий болж байна гэж үзжээ. Мөн эрх зүйн зохицуулалтын дутагдал, зохион байгуулалтын асуудлууд нь хүнд суртлын шалтгаан болсоор байна гэсэн байна.

Хүнд суртлыг бууруулах нэг гол арга зам бол төвлөрлийг сааруулж, хүнд суртлын уул уурхай болж буй үй олон зөвшөөрлийн тогтолцоог халах явдал юм. Зарим лиценз, тусгай зөвшөөрөл олгох, бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой төрийн зарим чиг үүргийг чадварлаг төрийн бус байгууллагуудад шилжүүлснээр хүнд суртлын цар хүрээг багасгах боломжтой. Чадварлаг төрийн бус байгууллага төрийн ачааллаас хуваалцаж шуурхай, үр дүнтэй үйл ажиллагааг хэрэгжүүлж болдгийн тодорхой нэг жишээ бол Нотариатын байгууллага юм.

Төрийн байгууллагын ил тод байдал нь хүнд суртлыг бууруулах нэг арга зам мөн. Төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаа нь ил тод байж төрийн байгууллагын мэдээлэл иргэдэд ямар ч үед нээлттэй байх ёстой. Байгууллагын шуурхай, ил тод байдал, иргэдийн идэвхитэй оролцоо, хариуцлагын тогтолцоо болон төвлөрлийн сааруулалт төрийг хариуцлагатай болгон шинэчлэхийг нөхцөлдүүлдэг.

Иргэдийн хууль, эрх зүйн боловсрол, мэдлэгийг дээшлүүлснээр иргэн бүр өөрийн эрхийг хамгаалах чадвартай болж хүнд суртлын эсрэг тэмцэх, төрийн байгууллагуудад ачаалал үүсгэж, дарамт бий болгох явдлыг бууруулах боломж нээгдэнэ.

Өнөөдөр бид төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, нээлттэй, хүртээмжтэй, ил тод, хууль ёсны дагуу, хүнийг дээдэлж, эрх, эрх чөлөөг нь хүндэтгэж хүргэх оновчтой арга замыг тодорхойлж чадна гэдэгт итгэлтэй байна.

Хүний эрхийн үндэсний чуулганыг өөрийн ивээл дор зохион байгуулах, хүнд суртлыг даван туулах арга замыг хэлэлцэх боломж олгосон Монгол Улсын Ерөнхийлөгч Танд талархал илэрхийлье.

Анхаарсан явдалд баярлалаа.



Г.БАЯСГАЛАН

Хууль зүй, дотоод хэргийн яамны
Төрийн нарийн бичгийн дарга

**“ХОХИРОГЧИЙН ЭРХИЙН БАТАЛГАА” СЭДВЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН
ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

Монгол Улсын Ерөнхийлөгч өө

Хүндэт зочид, төлөөлөгчид өө

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтган мэндчилье.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Хохирогчийн эрхийн баталгаа” сэдвээр 2007 онд зохион байгуулсан Хүний эрхийн үндэсний чуулганаас 15 байгууллагад хандсан 64 заалт бүхий зөвлөмжийг гаргасан билээ. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын талаар товч илтгээ.

Хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр хэлэлцэн баталлаа. Дээрх хууль батлагдсанаар Төрийн албаны зөвлөл нь албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлыг арилгуулахаар төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болсон.

“Гэмт хэргийн улмаас учирсан эдийн болон эдийн бус хохирлыг бодитой тооцох үнэлгээний нэгдсэн аргачлал, үнэлгээ хийх журам боловсруулж мөрдүүлэх” заалтын хүрээнд, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газар санаачлан боловсруулж, 2008 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн юм.

Энэ хуулиар хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг санаатай үйлдэгдсэн, зарим төрлийн хүнд, онц хүнд гэмт хэргийн хохирогчид нь хохирлынхоо зохих хэсгийг тухайн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсний дараа төрөөр нөхөн төлүүлэхтэй холбогдсон эрх зүйн харилцааг зохицуулах юм.

Хуулийн төсөл батлагдсаны дараа гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмыг Засгийн газар батлан мөрдүүлэх бөгөөд уг журмаар гэмт хэргийн улмаас учирсан эдийн болон эдийн бус хохирлыг бодитой тооцох үнэлгээний нэгдсэн аргачлал, үнэлгээ хийх асуудлыг зохицуулах боломжтой болно.

ХЗХ-ны хадгаламж эзэмшигчдэд учирсан хохирлыг барагдуулах зорилгоор Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж батлуулсан бөгөөд энэ хуулиар хадгаламж зээлийн хоршооны үүсгэн байгуулагчдын буруутай үйл ажиллагааны улмаас хадгаламж эзэмшигчдэд учирсан хохирлын 50 хувийг төрөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулахаар зохицуулсан юм. Уг хуулийн дагуу Засгийн газраас “Хохирол барагдуулах журам”-ыг батлан мөрдүүлж, холбогдох хөрөнгийг улсын төсвөөс гарган санхүүжүүлээ.

“Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял эдэлсэн хүмүүст эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөхийн зэрэгцээгээр хилсээр хоригдсон хоног тутамд ногдох сэтгэл санааны төлбөрийн хэмжээг тогтоож мөрдүүлэх асуудлыг судалж, санал боловсруулах ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2008 оны 114 дүгээр тушаалаар байгуулсан бөгөөд энэ чиглэлээр тодорхой судалгааны ажлууд хийгдэж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүх, прокурорын хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг Засгийн газрын нөөц сангаас гаргах, энэ талаар шүүхийн шийдвэрт тусгаж байхаар Улсын дээд шүүхийн тайлбар гарсны дагуу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирсон иргэдийн хохирлыг төлөх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар тухай бүр хэлэлцэн шийдвэрлэж байна.

Тухайлбал, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүх, прокурорын хууль зөрчсөн ажиллагааны улмаас хохирсон 20 гаруй иргэд, байгууллагын 500 гаруй сая төгрөгийн хохирлыг Засгийн газрын нөөц сангаас гаргаж барагдуулах арга хэмжээ авлаа.

Мөн төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирлыг барагдуулах зориулалтаар 3,4 тэрбум төгрөгийг 2009 оны улсын төсөвт тусгалаа. Ингэснээр урьд жилүүдэд хуримтлагдсан иргэний нэхэмжлэлтэй төрөөс барагдуулах хохирлын асуудлыг нэг мөр шийдвэрлэж байгаа нь зарчмын ач холбогдолтой юм. Нэг ёсондоо төр иргэнд өргүй, учруулсан хохирлоо бүрэн барагдуулна гэсэн үг.

Цагдаагийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хохирогчийн эрхийг хамгаалах, хөндөгдсөн эрхийг нь сэргээх талаар хийж байгаа ажлыг тэдгээр байгууллагын ажлын үр дүнг үнэлэх шалгуурт оруулж дүгнэхээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2008.2.19-ний өдрийн 47 дугаар тушаал гаргалаа.

Хохирогчдын хохирол нөхөн төлөгдөх бодитой эх үүсвэрийн нэг болох ялтны хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор зарим хорих ангийн дэглэмийг өөрчлөн зохион байгуулж, “Хорих ангиудын нутаг дэвсгэрийн байршил, ял эдлүүлэх харьяалал, үйлдвэрлэлийн чиглэлийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2007 оны 188 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна.

Мөн хорих ял эдэлж байгаа ялтны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хөдөлмөрийн хөлснөөс хохирогчийн хохирлыг аль болох түргэн шуурхай нөхөн төлөгдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2008-2012 онд “Ялтны гэм хорын хохирол барагдуулалтыг нэмэгдүүлж, төлбөр барагдуулалтанд хяналт тавин ажиллах хөтөлбөр”-ийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2008 оны А/102 тоот тушаалаар баталжээ.

Төлбөртэй ялтнуудын талаар мэдээллийн сан бүрдүүлж, тэдгээрээс гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлөх явдалд хяналт тавин ажилласнаар өнгөрсөн хугацаанд 583 ялтанд холбогдох 541.3 сая төгрөгийн хохирлыг бодитой барагдуулж, хохирогч нарт олгох ажиллагааг шуурхай зохион байгууллаа.

Эрүүгийн хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтийг 2007 оны 10 дугаар сарын биелэлттэй харьцуулахад мөнгөн дүн 157.9 саяар өссөн үзүүлэлттэй, энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тодорхой ахиц гарсан байна.

Хадгаламж зээлийн хоршоодын хохирогчдын хохирлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шуурхай барагдуулах үүрэг бүхий “Хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах алба”-ыг байгуулан ажиллаж байгаа бөгөөд 22 хадгаламж зээлийн хоршооны 6583 хохирогчид эргэн төлөгдөх нөхцөлөөр хохирлын 50 хувь болох 33.0 тэрбум төгрөгийг олгоод байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдийн хөрөнгийг битүүмжлэх, хамгаалах, нуугдмал эд хөрөнгө, мөнгийг илрүүлэх ажлын үр дүнг алба хаагч, нэгжийн ажлыг дүгнэх үндсэн үзүүлэлт болгон сар бүр дүгнэж хохирол нөхөн төлүүлэх ажиллагаанд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах хэлтэс, тасгийн дарга нар байнга хяналт тавин ажиллаж байна.

Тухайлбал, гэмт хэргийн улмаас 15265 иргэн хохирсны 30.0 хувь эмэгтэйчүүд, 5.4 хувь нь насанд хүрээгүй хүмүүс, 27.4 хувь тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс, 11.2 хувь нь хохирогчийн буруугаас гэмт халдлагад өртсөн ба төр, албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 43.7 тэрбум төгрөгийн хохирол учирсны 4.2 тэрбум буюу 9.7 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлж, хэрэг бүртгэлтийн шатанд 46.0 сая, мөрдөн байцаалтын шатанд 718.3 сая, нийт 764.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

Зөвлөмжид тусгагдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, уг ажилд төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг оролцуулахтай холбоотой заалтыг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газрын 15 дугаар албан даалгаврын дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бүх нийтийн үйл хэрэг болгох, хүүхэд залуучуудад төрийн хуулийг хүндэтгэн, сахин биелүүлэх сэтгэлгээг төлөвшүүлэх, архидан согтуурахыг жигшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг хэвлэл мэдээллийн болон холбогдох төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран сард нэгээс доошгүй удаа зохион байгуулж хэвшүүлэхээр ажиллаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Засгийн газар “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2007 оны 225 дугаар тогтоолоор батлан, төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжүүлж байна. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан, гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах байрны үйл ажиллагааны зардалд дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газраас жил бүр 8 сая хүртэл төгрөгийн санхүүжилт олгон ажиллаж байна.

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүний эрхийн талаархи холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенцийг тайлбарласан телевизийн танин мэдэхүйн цуврал нэвтрүүлгийг тогтмол бэлтгэн явуулж байна.

Согтууруулах ундаа үйлдвэрлэдэг, худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, архи, спиртийн хууль бус үйлдвэрлэл, худалдааг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр мэргэжлийн хяналтын алба, татвар, үйлдвэр үйлчилгээний албадуудтай хамтарч улсын хэмжээнд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж ажиллалаа.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд спирт, архины үйлдвэр, баар, караоке, ресторан, зоогийн газар, кафе зэрэг нийт 27352 аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаж, 11466 зөрчил илрүүлж, 8196 аж ахуйн нэгж байгууллагыг 24 сая 454 мянган төгрөгөөр торгож, 745 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр болон бүрмөсөн зогсоохоор мэргэжлийн хяналтын албанд санал хүргүүлжээ. Стандартын шаардлага хангаагүй, шинжилгээний бичиггүй 110657 шил архи, 4818 литр спирт хураан авч, нийт 21819 литр согтууруулах ундааг устгаж, 19960 литр согтууруулах ундааг холбогдох мэргэжлийн байгууллагад нь шилжүүлсэн байна.

Энэ оны 1 дүгээр улиралд 128 саун, массажийн газрыг шалгаж, нийт 171 зөрчил илрүүлсний 65 хувийг нь газар дээр нь арилгуулж, ажлын байрны дүгнэлт, үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлгүй, орон сууцны доод давхар, хонгил зэрэг хориглосон газарт байрласан, тогтоосон улсын стандартыг зөрчсөн, зөвшөөрөлгүйгээр архи, согтууруулах ундаагаар үйлчилсэн 30 сауны үйл ажиллагааг зогсоосон байна.

Шалгалтаар саун массажийн үйл ажиллагаа явуулах нэрээр бусдыг биеэ үнэлэхийг зохион байгуулж байсан 19 саун массажийн газрыг илрүүлж, үйлдлийг нь баримтжуулан, 18 хүнд холбогдуулан 15 эрүүгийн хэрэг үүсгэж, хуульд заасан үндэслэл журмын дагуу байцаан шийтгэх ажиллагаа явуулж байна.

“Нийслэлийн хөдөлгөөнт эргүүлийн газар” байгуулж нийслэлийн 6 дүүргийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг судалсны үндсэн дээр Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийг 4 бүс, 50 хэсэгт хувааж 24 цагаар хяналт тавьж байна.

Хилийн чанадад байгаа иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр

Одоогийн байдлаар албан бус тоогоор 130,000 гаруй Монгол Улсын иргэн дэлхийн 30 гаруй улсад байгаа бөгөөд тоогоор авч үзвэл БНСУ-д хамгийн их буюу 35000, АНУ-д 22000, БНЧУ-д 12000 гаруй иргэд ажиллаж, амьдарч, сурч байна. Эдгээр иргэдээс 90000 гаруй нь хууль ёсоор, 40000 нь хууль бусаар байгаа гэсэн мэдээтэй байна.

Эдгээр иргэдийнхээ хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хохирохоос урьдчилан сэргийлэх шаардлага зүй ёсоор урган гарч байгаа бөгөөд Гадаад харилцааны яамнаас 26 оронд суугаа Элчин сайдын яам, байнгын төлөөлөгчийн газар, 8 ерөнхий консулын газар, консулын төлөөлөгч, 38 оронд суугаа 62 Өргөмжит консулаараа дамжуулан иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Манай улс иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр 20 улстай эрх зүйн

туслалцааны гэрээ байгуулсан байна. Түүнчлэн иргэдийнхээ гадаадад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх үүднээс 16 улстай харилцан визгүй зорчих хэлэлцээр байгуулан мөрдөж байна. Хилийн чанадад байгаа иргэдтэй холбоотой өргөдөл гомдлыг ЭСЯ, ЕКГ-уудаараа болон төвдөө хүлээн авч аль болох богино хугацаанд шийдвэрлэж байгаа бөгөөд 2007 онд эрх нь зөрчигдсөн 7886 иргэний өргөдлийг хүлээн авч шийдвэрлэсэн. Иргэдийн өргөдөл гомдлыг 2008 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн тусгай вэб хаягаар дамжуулан хүлээн авч, шийдвэрлэж эхэлсэн бөгөөд энэхүү арга хэмжээ нь цаг хугацаа хэмнэх, чирэгдлийг багасгах зэрэг давуу талтай болсон.

Мөн ОХУ, БНХАУ, БНСУ зэрэг улсуудтай Консулын зөвлөлдөх уулзалтыг тогтмол хийж байгаа нь тухайн орнуудад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах болон иргэд зорчих нөхцөлийг хөнгөвчлөх болон бусад ээдрээтэй асуудлуудыг шийдвэрлэхэд томоохон хэмжээний дэмжлэг болж байгаа юм.

Хилийн чанадад эрх ашиг нь хөндөгдсөн, төлбөрийн чадваргүй иргэдэд санхүүгийн тусламж үзүүлэх тогтолцоо бүрдүүлэх зорилгоор жилийн 500 сая төгрөгийн төсөв бүхий “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан”-г байгуулан дүрмийг Засгийн газраар батлуулав.

Энэ сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд зааснаар улсын төсвийн хөрөнгө, байгууллага, иргэдээс өгсөн буцалтгүй тусламж, хандив, гадаад улс, олон улсын байгууллагаас Засгийн газрын шугамаар олгосон зээлээс бүрдэх юм.

“Хохирогчийн эрхийн баталгаа” сэдвээр зохион байгуулсан үндэсний чуулганаас гаргасан зөвлөмжид нэр дурдагдаж үүрэг хүлээсэн байгууллагууд бүгд дэлгэрэнгүй тайлангаа ирүүлж, танилцуулснаас тоймлон Та бүхэнд мэдээллээ. Хохирогчийн эрхийг хангах хамгаалах чиглэлээр идэвхтэй ажилласан бүх байгууллагад талархал илэрхийлье.

Үндэсний чуулганы зөвлөмжийн дагуу зохион байгуулах арга хэмжээ нь зөвхөн нэг жилийн дотор хийгдээд өнгөрөх ажил биш, хохирогчийн эрхийг хамгаалах иж бүрэн тогтолцоо бүрдүүлэх шаардлагатайг харгалзан хариуцсан байгууллагууд хийж амжаагүйгээ гүйцээж биелүүлэх, хийж байгаагаа тогтмолжуулан хэвшүүлэх нь зүйтэй юм. Засгийн газраас энэ талаар шаардлагатай арга хэмжээг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.



Ч.САНГАРАГЧАА

Авлигатай тэмцэх газрын дарга,
тэргүүн комиссар

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ ХҮНД СУРТАЛ, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ НЭН ТЭРГҮҮНИЙ АРГА ХЭМЖЭЭ МӨН

Өнөөдрийн хүнд суртал бол маргаашийн авлигын үндэс!
Эрхэм хүндэт хатагтай, ноёд оо,

Юуны өмнө энэхүү чуулганыг зохион байгуулж санал бодлоо солилцох боломжийг олгож буй Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисст болон хамтран ажиллаж байгаа Ерөнхийлөгчийн Тамгын газар, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн хамт олонд талархал илэрхийлье.

Авлига бол нийгмийн шударга ёсыг алдагдуулж, хүний эрх, эрх чөлөөг алхам тутамдаа зөрчиж байдаг гэмт үзэгдэл бөгөөд авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь бүхэлдээ хүний эрх, эрх чөлөөг хангах, нийгмийн шударга ёсыг бэхжүүлэхэд чиглэгддэг.

Төрийн албан хаагчдын хүнд суртал, хариуцлагагүй байдал нь авлига үүсгэх үндсэн шалтгаануудын нэг болж байна. Хүнд суртал, иргэдийг чирэгдүүлсэн хүчин зүйлс их байхын хэрээр авлига үүсэх орчин нөхцөлийг төдий хэмжээгээр бүрдүүлж байдаг.

Өнөөдөр иргэд, төрөөс үзүүлж буй үйлчилгээг түргэн шуурхай, үр ашигтай хүнд суртал чирэгдэлгүй байхыг хүсэж байна. Харин тэрхүү үйлчилгээ нь түргэн шуурхай, хүнд суртал, чирэгдэлгүй байж чадаж байна уу?

Өнгөрсөн хугацаанд хийгдсэн судалгаануудын¹ дүнгээс үзэхэд төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хүнд суртал, чирэгдэл амь бөхтэйгээр оршсоор байна.

¹ Авлигатай тэмцэх газар, “Глоб Интернэшнл” ТББ, Нээлттэй нийгэм форумас хамтран хийсэн “Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдал” мониторингийн тайлан. 2008 он, МХАҮТ-ын Эдийн засаг, бизнесийн шинжилгээ, үнэлгээний төвөөс эрхлэн хийсэн “Хүнд суртлын индекс-2007” судалгаа.

Тэр дундаа төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх болон үйлчилгээний байгууллагын мэргэжлийн албан тушаалтнууд хүнд суртал гарган иргэдийг хамгийн ихээр чирэгдүүлж байна.

Худалдаа аж үйлдвэрийн танхимаас хийсэн судалгаагаар иргэд төрийн байгууллагуудын олон шат дамжлага, хүнд суртал бизнест ихээхэн хүндрэл бэрхшээл учруулдаг хэмээн 28.1 хувь нь үзжээ.

Төрийн байгууллагуудын зүгээс шаарддаг хэрэгтэй, хэрэггүй олон төрлийн бичиг баримт бүрдүүлэлт ихээхэн бэрхшээлтэй гэж 14.6 хувь нь үзэж байхад мэргэжлийн хяналтын байгууллагуудын олон төрлийн хяналт шалгалт бэрхшээлтэй хэмээн 17.3 хувь үзжээ.

Манай төрийн байгууллагуудын үйл ажиллагаа олон шат дамжлагатай, шаардлагагүй бичиг баримт, лавлагаа, тодорхойлолт их авдаг, даргын болон бусад олон зөвшөөрөл нэхдэг, асуудал тавихаар хаана хандах, хэнтэй уулзах, хэзээ шийдвэрлэх нь тодорхойгүй, ажлын зохион байгуулалт, уялдаа холбоо муу, цаг баримталдаггүй, шуурхай биш хөшүүн хойрго, хуульд заасан хугацааг барьдаггүй зэргээр иргэдийг чирэгдүүлж хүнд суртал гаргах явдал түгээмэл ажиглагдаж байна.

Энэ бүхнээс үзэхэд хүнд суртлын шалтгаан нь 2 үндсэн эх сурвалжтай байна.

- 1.Хүнээс буюу төрийн албан хаагчдаас хамаарсан
- 2.Хууль тогтоомж, дүрэм, журмаас хамаарсан.

Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, ажлын арга барил, эрх зүйн мэдлэг, ёс зүйн төлөвшил, хууль тогтоомжийг хэрэгжүүлж буй байдал, тэдгээрт тавьж буй хяналт, хариуцлагын тогтолцоо сул байгаа нь хүнд суртлыг үүсгэх шалтгаан болж байгаа гэдэгтэй Та бүхэн санал нийлэх биз ээ.

Алдаа дутагдал гаргасан төрийн албан хаагчийн өмнөөс “хуулийн хийдэл” гэдэг шалтгаанаар хууль нь өөрөө хариуцлага хүлээхээр болоод өнгөрдөг байдал газар авчээ. Энэ буруу хандлага, гаж сэтгэлгээг даруй өөрчлөх хэрэгтэй!

Албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй алдаа дутагдал гаргасан төрийн албан тушаалтанд тэрхүү хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй, хүлээсэн үүргээ биелүүлээгүйн төлөө хариуцлага тооцдог болох ёстой. Үгүй бол хүнд суртал буурахгүй, арилахгүй. Харин хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал байгаа бол хариуцлагаас тусад нь авч үзэх нь зүйтэй.

Мөн төрийн захиргааны байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон олон тооны дүрэм, журам ил тод биш, эмх цэгцгүй, системчлэгдэж чадаагүй байгаа нь үйлчлүүлэгч иргэдэд төдийгүй төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд ч чөдөр тушаа болж байна.

Эдгээр дүрэм, журмыг цэгцэлж системчлэх, чанаржуулан цөөлөх, бүртгэлийн ажиллагааг боловсронгуй болгож ил тод болгох талаар арга хэмжээ авч байгаа ч далайцтай үр дүнд хүрэхгүй байна.

Анхаарал татсан бас нэг асуудал бол төрийн байгууллагууд төлбөр, хураамжийг хууль зүйн үндэслэлгүй, дураараа тогтоох болсон явдал юм.

Өнөөдөр 93 хуульд төлбөр, хураамж тогтоох эрхийг албан тушаалтнуудад олгосон байна. Түүнээс гадна хуулиас гадуур төлбөр, хураамжийг бий болгох, үйлчилгээндээ хэрэглэж буй маягт, гэрчилгээ, үнэмлэх, бичиг баримтын үнийг төлүүлэх, үйлчилгээг задалж тус бүрт нь төлбөр тогтоох, ажлын бус цагаар үйлчлүүлбэл төлбөр авах гэх мэт олон хэлбэрээр төрийн байгууллага үйлчилгээ үзүүлэхдээ хууль бусаар элдэв төлбөр, хураамж иргэдээс авч байна.

Иймд төлбөр хураамж тогтоох явдлыг нэг мөр болгон тусгайлсан хууль батлах шаардлагатай байна.

Авлигатай тэмцэх газраас төрийн зарим байгууллагуудаас гаргасан дүрэм журмын хууль зүйн үндэслэлийг хянах явцад хууль бус төлбөр, хураамж тогтоосон, хүнд суртал, чирэгдлийг үүсгэсэн дүрэм, журмыг хүчингүй болгох талаар зохих шаардлагыг тухай бүрт нь тавин ажиллаж байна. Тухайлбал: Эрүүл мэндийн яам, Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Иргэний нисэхийн ерөнхий газар зэрэгт шаардлага өгсөн.

Төвлөрөл хүчтэй байгаа нь хүнд суртлын бас нэгэн гол шалтгаан болж байна. Монгол Улсын үндэсний хөгжлийн үзэл баримтлалд² төвлөрлийг сааруулах, орон нутагт эрх мэдлийг шилжүүлэх тухай бодлогыг тодорхойлсон. Гэтэл амьдрал дээр эсрэгээрээ эрх мэдлийн төвлөрөл явагдаж байна.

Өөрсдийн хийж хүч хүрэхгүй их чиг үүргийг хүлээж, түүнийг хэрэгжүүлэх орон тоо, бүтэц бүрэлдэхүүн байхгүй байгаагаа яамдын удирдлага удаа дараагийн уулзалт

² Улсын Их Хурлын 1996 оны 26 дугаар тогтоол

ярилцлагын үеэр хэлэх болж. Энэ нь төвлөрөл явагдаж байгаагийн илрэл юм. Эрх мэдлийг яамд, агентлагуудад, тэр дундаа сайд, дарга нарт төвлөрүүлсэн нь ажлын ачааллыг эрс нэмэгдүүлж, хүлээсэн чиг үүргээ хангалттай сайн биелүүлэх боломжийг үгүй болгож байна.

Нөгөөтэйгүүр төрийн байгууллагуудын ил тод нээлттэй байдлыг хангах, иргэдийн оролцоо, хяналтыг бий болгох талаар үр дүнтэй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь туйлын чухлаар тавигдаж байна.

Зөвхөн дээрээс нь биш, дэргэдээс нь хянавал үр дүнтэй байх нь мэдээж хэрэг. Бид дээрээс хараад энд хүнд суртал байна гэж хэлэхэд хэцүү. Тиймээс энд иргэний оролцоо хэрэгтэй. Төрийг түмэн нүдний хяналтанд оруулах замаар авлига, хүнд суртлын эсрэг тэмцэж байгаа дэлхийн олон улс орнуудын үр дүнтэй туршлагыг анхааран үзэх цаг нь болжээ.

Авлигатай тэмцэх газар нь төрийн байгууллагын ил тод байдлыг хангах талаар тодорхой ажлуудыг санаачлан хийж ирсэн цаашид ч хийх болно. Энэ асуудал бол бидний анхаарлын төвд ямагт байх болно.

Энэ чиглэлээр төрийн байгууллагуудын өөрсдийн идэвх санаачилга, иргэдийн идэвхтэй оролцоо чухал шаардлагатай байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлиг гарсны дагуу төрийн байгууллагууд нээлттэй хаалганы өдрийг тогтмол зохион байгуулж иргэдэд мэдээлэл хүргэж хэвшиж байгаа нь ач холбогдолтой арга хэмжээ билээ.

Манай төрийн байгууллагуудын албан тушаалтнууд үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал ярихаар зөвхөн тухайн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах байдлаар ойлгодог хандлага түгээмэл харагддаг.

Чухамдаа төрийн байгууллага, албан хаагч:

- хуулиар хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж, шударга ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих боломжийг бүрдүүлэх хэмжээнд үйл ажиллагааны ил тод байдлыг;
- төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа ажил, үйлчилгээ зохистой, үр дүнтэй байдалд болон хуваарилагдсан хөрөнгө зориулалтын дагуу, зохих хэмжээгээр зарцуулагдаж байгаад хяналт тавьж чадахуйц хэмжээнд төсөв, санхүүгийн ил тод байдлыг;

- алдаа дутагдал, зөрчил доголдол дарагдаж үлдэхгүй байх хэмжээнд хариуцлага, гомдол мэдээллийн ил тод байдлыг хангах шаардлагатай.

Түүнчлэн, мэдээллийн технологийг ашиглан авлига, хүнд суртлын түвшинг амжилттай бууруулж чадсан Солонгос, Сингапур, Япон зэрэг зарим орны туршлагыг хуулбарлан төрийн байгууллагуудын цахим хуудсаар зөвхөн мэдээлэл хүргэхээс гадна зарим төрлийн үйлчилгээг үзүүлэх нөхцөл, боломжийг судлан, ажил хэрэг болгох нь шинэ зууны бодит хэрэгцээ боллоо.

Төрийн байгууллагын хүнд суртлын талаарх гомдол мэдээллийн багагүй хувийг албан хаагчдын ёс зүй, харилцааны соёлтой холбоотой асуудал эзэлж байна. Энэ байдалд дүн шинжилгээ хийж тодорхой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эцэст нь тэмдэглэхэд төрийн албан хаагчийн хууль бус үйл ажиллагаанд хариуцлага хүлээлгэх явдал хангалтгүй байгаа нь төрийн үйлчилгээг чанаргүй, үр дүнгүй, шударга бус байдалд хүргэж байна.

Маргаашийн авлигын үр хөврөл болох өнөөдрийн хүнд суртал, хариуцлагагүй байдлыг таслан зогсоож чадсанаар төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг шуурхай, шударга болгож Үндсэн хуулиар олгогдсон хүний эрхийг хангах болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.



Л.МӨНХБААТАР

Иргэний бүртгэл, мэдээллийн улсын
төвийн дарга

ХҮНИЙ ЭРХ БА ИРГЭНИЙ БҮРТГЭЛ

Эрхэм Монгол Улсын Ерөнхийлөгч өө!

Чуулганд оролцогч зочид, төлөөлөгчид өө!

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг чуулган энэ удаа манай нийгмийн өмнө, тэр дундаа иргэд, үйлчлүүлэгчдийн өмнө тулгарч байдаг “Хүнд суртал”-ын асуудалд анхаарлаа хандуулж байна.

Чуулганы сэдвийн хүрээнд илтгэлээ дараах 2 үндсэн асуудалд анхаарал хандуулан бэлтгэлээ.

1.Иргэний бүртгэлээр хүний эрхийг баталгаажуулах асуудал

2.Иргэний бүртгэлийн байгууллага дахь хүнд суртал, чирэгдлийг арилгах, хүний эрхийг хангах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үр дүнгийн талаар танилцуулъя.

Иргэний бүртгэлээр хүний эрхийг баталгаажуулах талаар

“Иргэний бүртгэл” нь Иргэний бүртгэлийн тухай хуульд зааснаар иргэний эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбогдсон харилцааны үндсэн эх сурвалж болдгоороо иргэний эрхийг хангах төрийн үйл ажиллагааны салшгүй чухал хэсэг болдог.

Иргэд бүртгэлээ цаг тухайд нь үнэн зөвөөр бүртгүүлснээр иргэнийхээ эрхийг эдлэх, үүрэг хүлээх нөхцөл бүрддэг. Төр иргэдээ бүртгэснээр нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогоо тодорхойлох, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх зэрэг асуудлыг бодитой, үндэслэлтэй шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой. Товчхондоо хэлэхэд бүртгүүлсэн иргэн л эрхээ бүрэн эдэлнэ гэсэн үг.

Иргэний бүртгэлийн үйл ажиллагааг шинэ шатанд гаргах, иргэний эрхийг хангах талаар тус төв төр засгийн дэмжлэгтэйгээр олон ажлыг эхлүүлээд байна. Тухайлбал,

- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд иргэний бүртгэл, мэдээллийн бүх шатны байгууллагын мэдээллийг шуурхай солилцох зорилгоор Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв болон 21 аймаг, нийслэл, дүүргийн нэгжийг “Онлайн” сүлжээнд холболоо. Ингэснээр иргэний бүртгэл, мэдээллийн үйл ажиллагаа нэг шат ахиж, үзүүлдэг үйлчилгээ нь ч урьдынхаасаа илүү түргэн шуурхай болох нөхцөл бүрдэж байна.

Мөн “Иргэний бүртгэл, паспорт-хяналтын нэгдсэн сүлжээ” төслөөр олон улсын 3 боомтыг холбосон бөгөөд одоо байнгын ажиллагаатай хилийн шалган нэвтрүүлэх 20 боомтыг нэгдсэн сүлжээнд холбох ажил хийгдэж дуусаж байна. Ингэснээр Монгол Улсын хилээр орж, гарч байгаа иргэд болон тээврийн хэрэгслийг бүртгэх, хянах боломжтой болох юм. Цаашид гадаад улсад суугаа МУ-ын ЭСЯ, дипломат төлөөлөгчийн газрыг мөн энэ сүлжээнд холбохоор төлөвлөж байна.

Ийнхүү холбосноор Монгол Улсын иргэний эрхийг хамгаалах, гадаад улсад ажиллаж амьдарч байгаа иргэдийн бүртгэлийг бодитой гаргах, гадаад улсад суугаа ЭСЯ, консулын газруудтай нягт уялдаатай хамтран ажилласны үндсэн дээр гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэдийн бүртгэл, мэдээллийн асуудлыг цэгцлэх бололцоо бүрдэж, тэдгээр иргэдийн эрх ашгийг хамгаалах боломжтой болох юм.

- Засгийн газраас “Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн архивын цахим сан”, “Иргэний ухаалаг үнэмлэх” төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Иргэний баримтын цахим сан төсөл нь Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн архивт хадгалагдаж байгаа 12 сая бүртгэлийн үндсэн баримтыг 2.6 сая иргэний баримт болгон хувийн хэрэгжүүлж цэгцлэх, үндсэн баримтуудыг шалгах, иргэний бүртгэлийн баримт бүрийг нэгтгэж цахим сан үүсгэх юм.

- Эдгээр төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, бүртгэлийн системийг сайжруулах, иргэний эрхийг хангахад ихээхэн түлхэц болох юм.

Иргэний ухаалаг үнэмлэх нь иргэний суурь бүртгэлийн мэдээлэл буюу /нэрийн, биеийн өгөгдөл, хурууны хээний, төрөлтийн, гэрлэлтийн, үрчлэлтийн, иргэний үнэмлэхийн, хаягийн гэх мэт/- мэдээллийг агуулснаараа иргэний бүртгэлийн үйл ажиллагаанд ихээхэн дэвшлийг авчирч, бүртгэлийн үнэн бодит байдлыг хангах нөхцөл болох юм.

Эдгээр төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр иргэний бүртгэлийн үйл ажиллагаа, үйлчилгээ боловсронгуй болж иргэдийнхээ эрхийг бүртгэлээр баталгаажуулах, эрхийг нь хангахад дэвшил гарна гэж үзэж байна.

Иргэний бүртгэлийн байгууллагын үйлчилгээг хүнд суртал чирэгдэлгүй болгох, иргэний эрхийг хангах талаар

Иргэний бүртгэлийн байгууллага бол төрийн үйлчилгээний байгууллага.

Төрийн байгууллагын үйлчилгээ иргэдэд тасралтгүй, хүнд сурталгүй хүрч байх ёстой.

“Хүнд сурталтай байгууллага” гэдэг нэр бий болох бас нэг шалтгаан нь байгууллагын дотоод зохион байгуулалт муу, ажилчдын зан харьцаатай холбоотой байдаг.

Бид хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ, үйлчилгээний сэтгэл ханамжийн талаар үйлчилгээний ажилтан тус бүр дээр судалгаа хийлгэсэн. Энэхүү судалгаагаар манай үйлчилгээнд тодорхой дутагдлууд байгаа нь харагдсан.

Үүнээс үүдэн харилцааны соёл, үйлчилгээний дэг журмыг зохицуулах тодорхой баримт бичиг шаардлагатай юм байна гэж бид үзээд үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчилгээг түргэн шуурхай, иргэдэд хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэх зорилгоор төрийн байгууллагуудаас анх удаа “Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвөөс иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх үйлчилгээнд тавих шаардлага” /Байгууллагын стандарт – CS11-0035:2008/-ыг Монгол Улсын “Үндэсний стандартчилал”-ын “MNS 1-152006, MNS 1-2:2006” шүүлтийн дагуу батлан мөрдөж эхлээд байна.

Энэхүү стандарт нь тус төвийн үйлчилгээ, түүний үзүүлэлт, үйлчилгээний ажилтны ажлын байрны дэг журам, хувцаслалт, соёл, үйл ажиллагаандаа баримтлах зарчим, үйлчлүүлэгчтэй харилцах харилцаа, хяналт, урамшуулал, хариуцлага тооцох зэргийг цогцоор тусгаж баталгаажуулсан норматив юм. Өөрөөр хэлбэл, үйлчлүүлэгч манайхаар ирж үйлчлүүлээд гарах хүртэлх хугацаанд сэтгэл ханамжийг бий болгоход чиглэсэн арга хэмжээ юм. Ийнхүү үйлчилгээ стандартчилагдсанаар ажилтны дур зоргоор ханддаг, харьцдаг асуудал багасч байна.

Мөн тухайн байгууллагын үйлчилгээний ачаалал ихтэй байдал нь иргэдийн дунд “хүнд сурталтай байгууллага” гэсэн ойлголтыг төрүүлдэг нэг шалтгаан юм.

Тухайлбал: Манай төвийн нэг ажилтан өдөрт 150-200 иргэний материал хүлээн авч, 200-300 иргэнд архивын лавлагаа олгож байна. Энэ нь нэг ажилтан 2-3 минутад 1 иргэнийг хүлээж авч байна гэсэн үг.

Үүнийг хэрхэн шийдвэрлэх вэ? гэсэн асуудал гарч ирж байна.

Улс орны хүн амын тоо жилээс жилд нэмэгдэж байдаг тул үйлчилгээний ачаалал үүнийг дагаад мөн нэмэгдэж байна.

Үйлчилгээний ачааллыг багасгахын тулд үйлчилгээний ажилтны орон тоо, ажлын байрны багтаамжийг юуны өмнө нэмэгдүүлэх шаардлагатай нь ойлгомжтой.

Гэвч одоогийн нөхцөл байдал, орон тоондоо тохируулан үйлчилгээний ачааллыг бууруулах, хүнд суртал, чирэгдлийг арилгах талаар тус төвөөс хэд хэдэн арга хэмжээ аваад байгаагаа танилцуулъя.

Эхний ээлжинд бид ажилчдынхаа өдрийн цайны цагийн хуваарьт ээлжийн зохицуулалт хийсэн. Өөрөөр хэлбэл цайны цаг боллоо гээд хаалгаа бариад алга болохгүй. Ажилчид цайндаа ээлжилж орно. Бид өдөрт 09-18 цаг хүртэл иргэдэд тасралтгүй үйлчилж байна.

Үйлчилгээний ачааллыг бууруулах арга хэмжээний нэг нь сар бүрийн 2 дахь 7 хоногийн Бямба гарагт тус төвөөс тогтмол зохион байгуулж байгаа “Нээлттэй хаалганы өдөр” юм. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан уг арга хэмжээг манай байгууллага тогтмол хийж хэвшсэн учраас иргэд тэр дундаа ажлын 5 өдөр бүтэн ажилтай байдаг төрийн албаны болон бусад байгууллагын ажилтнууд уг өдөр олон тоогоор үйлчлүүлж иргэний бүртгэлийн үйлчилгээг авч байна.

Хоёрдугаарт: Төрийн ихэнх байгууллагад одоо ч байсаар байгаа “Дотоод ажлын өдөр” гэж нэг өдөр иргэдэд үйлчилдэггүй байсныг болиулсан. Өөрөөр хэлбэл бүтэн 8 цаг иргэдэд үйлчлэх цаг нэмэгдэж байна гэсэн үг.

Гуравдугаарт: үйлчилгээний танхимд орчин үеийн техник, технологийг ашиглан компьютер, дэлгэц/touchscreen system/-ийг суурилуулсан. Одоо иргэд манай үйлчилгээний танхимаас иргэний бүртгэлтэй холбоотой бүхий л мэдээллийг цаасан болон электрон хэлбэрээр өөрсдөө авах боломжтой болсон. Өөрөөр хэлбэл иргэд иргэний бүртгэлтэй холбоотой мэдээллийг заавал ажилтан дээр очиж дараалал үүсгэхгүйгээр өөрсдөө авах боломжтой боллоо гэсэн үг. Энэ нь үйлчилгээний ачааллыг бууруулж байгаа бас нэг хэлбэр юм.

Дөрөвдүгээрт: үйлчилгээний танхимд “Үйлчилгээний лавлагааны цэг” буюу “ресепшн”-ийг ажиллуулж эхэлсэн. Иргэд эндээс бас хэрэгтэй мэдээллээ авч болно. Энэ

нь бас л ажилтны ачааллыг бууруулах нэг арга хэмжээ юм.

Тавдугаарт: бид үйлчилгээний танхимд бусад улс оронд байдаг “өнгөний систем”-ийг нэвтрүүлсэн. Иргэд үйлчилгээний танхимд орж ирээд ямар өнгөтэй цонхноос ямар үйлчилгээ авах вэ гэдгийг мэдэх боломжийг бүрдүүллээ. Жишээлбэл Гадаад паспортын асуудлаар бол цэнхэр өнгийн “цонх” дээр очиж үйлчлүүлэх гэх мэт. Энэ нь иргэд буруу газар дараалалд зогсож цаг алдах, чирэгдэхээс урьдчилан сэргийлсэн, үйлчилгээний ачааллыг багасгах бас нэг арга хэмжээ болж байгаа юм.

Зургаадугаарт: гадаад паспорт авахаар захиалсан иргэнд гадаад паспортыг нь бэлэн болсон тухай мэдээллийг гар утсанд нь мессежээр илгээдэг болсон. Энэ нь тухайн иргэн гадаад паспортаа бэлэн болсон үгүйг байцаагчаас асууж ачаалал үүсгэхгүйгээр, хугацаа алдахгүйгээр өөрөө шууд олголтоос очоод паспортаа авчихна гэсэн үг.

Долоодугаарт: Бид нууцлалыг өндөржүүлэх үүднээс системийн хэмжээнд ашиглаж байгаа компьютерүүдийг төвлөрсөн удирдлага, хяналтын нэгдсэн тогтолцоотой болгох зорилгоор хамгийн сүүлийн үеийн хяналтын системийг /domain control system/ нэвтрүүлж эхлээд байна.

Мэдээллийн санд мэдээлэл оруулж буй ажилтны компьютерт хийсэн бүх бичлэгийг үсэг, үг, өгүүлбэрээр харах, хадгалах, шаардлагатай бол тухайн цаг мөчид яг юу бичиж байгааг нь хяналт тавьж буй албан тушаалтан дэлгэцэн дээрээ харах боломжтой юм.

Ингэснээр мэдээллийн санд гаднаас хөндлөнгийн мэдээлэл халдахаас хамгаалах, хянах ажил нэг шат ахиж байгаа хэрэг юм.

Дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр иргэний бүртгэл, мэдээллийн байгууллагын үйлчилгээний ачааллыг багасгах, хүнд суртал чирэгдлийг арилгахад үр дүнтэй алхам болсон гэж үзэж байна.

Цаашид иргэний бүртгэлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох ажлын хүрээнд мэдээлэл, технологийн орчин үеийн ололтыг үр өгөөжтэй ашиглан үйлчилгээг хялбаршуулах, бүртгэлийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, онлайн болон шуудангийн үйлчилгээг ашиглан иргэдэд бүртгэлийн үйлчилгээг хүргэх ажлыг дэс дараатай авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.



Ж.НОРОВСАМБУУ

Төрийн албаны зөвлөлийн дарга

**ХҮНИЙ ЭРХ БА ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ГОМДОЛ, МАРГААН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ**

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсад Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр”-ийн “Хүний суурь эрхийг хангах нь” 2 дугаар бүлгийн 2.2.2-т төрийн жинхэнэ (захиргааны болон тусгай) алба хаших эрхийг хангах талаар дараах зорилго, зорилтуудыг тодорхойлсон байдаг. Үүнд:

“– Төрийн захиргааны болон тусгай алба хаших нөхцөл болзол нь нийт иргэний хувьд адил тэгш байх үндсэн дээр төрийн албанд иргэдийг шалгаруулж авах, мэргэшүүлэн ажиллуулахдаа намчирхах, нутгархах, танил талаар дэмжих, улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлах, авлигад автах зэрэг хууль бус үйлдэлд өртөхгүй, тийм хандлага гаргахгүй байх баталгаа бий болгоно.

- Төрийн захиргааны албан хаагчийг тухайн орон тоо нь хэвээр байхад “баг бүрдүүлэх”, “бүтцийн өөрчлөлт хийх”, “албан тушаалын нэр өөрчлөх” зэргээр хууль тойрч төрийн алба хаагчдын тогтвортой, мэргэшсэн ажиллагааг алдагдуулдаг гажуудлыг таслан зогсоох арга хэмжээ авна.

- Төрийн жинхэнэ албан хаагчдыг улс төрийн үйл ажиллагаанаас зааглахын хамт улс төрийн алба хашихыг зоривоос жинхэнэ албанаас чөлөөлөгдсөний дараа нэрээ дэвшүүлдэг үндэслэл журмыг тогтооно.

- Төрийн албаны зөвлөлийг хараат бус ажиллуулж, төрийн албанд томилох, дэвшүүлэх, бууруулах, шилжүүлэх, халахад гарч байгаа хүний эрхийн зөрчлийг арилгаж, уг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна” гэжээ.

Өмнөх жил Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан хүний эрхийн байгууллагуудын үндэсний чуулганд зориулан хийсэн “Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагааны улмаас хохирсон иргэдийн эрхийг нөхөн сэргээх” сэдэвт судалгааны багаас гаргасан дүгнэлтэнд “төрийн алба, түүний

дотор төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар халах асуудалтай холбогдуулан нэн тэргүүний ээлжинд эрх зүйн орчныг өөрчлөх шаардлагатай байна” гэж тэмдэглэсэн билээ.

Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар ажлаас халж байгаа нь угтаа намын харьяалал, танил тал харах байдал, “баг бүрдүүлэлт”, “бүтцийн өөрчлөлт” зэрэг хууль бус үйлдлээс үүдэлтэй бөгөөд цаашилбал Төрийн албаны төв байгууллагын хараат бус байдлыг хангаж, эрх мэдлийг нь өргөтгөх асуудалтай харилцан уялдаатай болохыг удаа дараагийн баримт бичгүүдэд тэмдэглэсээр ирснийг Та бүхэн мэднэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулсан “Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2008.05.06-ны өдрийн хуульд дээрх Хөтөлбөрийн заалтыг хэрэгжүүлэх, төрийн албыг мэргэшсэн, тогтвортой байлгах зарчмыг хангаж, төрийн албаны эрх зүйн орчныг боловсронгуй болгох үүднээс хэд хэдэн өөрчлөлтийг нэмж тусгасан юм. Тухайлбал:

- ТАТХ-ийн 17.12-т байсан “Төрийн байгууллага нь ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн захиргааны албан тушаалд иргэнийг 6 сар хүртэл хугацаагаар түр томилж болно” гэсэн заалт нь төрийн албаны сул орон тоог карьерийн зарчмаар нөхөж, төрийн мэргэшсэн тогтвортой байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлэхэд саад учруулж байв.

Өөрөөр хэлбэл, томилох эрх бүхий албан тушаалтнууд танил тал, намын харьяалал харгалзан төрийн албаны мэргэшлийн шалгалт өгөөгүй, “өөрийн” хүнийг “түр” нэрийн дор төрийн захиргааны албан тушаалд томилох, түр ажиллаж байгаа хүн нь мэргэшлийн шалгалтанд орж, доогуур оноо авсан ч өндөр оноо авсан хүнийг биш, тухайн “түр” хүнээ үргэлжлүүлэн ажиллуулах, шалгалтанд тэнцээгүй байсан ч ажлын байрыг нь чөлөөлөхгүй байх, түүнчлэн тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг “түр” томилогдон ажиллаж байгаа хүндээ тохируулан зарлах зэргээр шударга бус үйл ажиллагаа явуулдаг, тэр ч бүү хэл хуулийн энэ заалтыг ашиглаж, албан тушаалын авлига явагддаг гэсэн олон нийтийн шүүмжлэл гардаг байсныг ч үгүйсгэх аргагүй юм. Энэ заалтыг хүчингүй болгосноор “түр” нэрээр “өөрийн” хүнийг төрийн жинхэнэ албанд “шургалуулах” гэсэн оролдлого хаагдаж байгаа гэж үзэж байна.

Төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Их Хурлын, тэрчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшихээр болсон, өөрийн санаачлагаар төрийн албанаас чөлөөлөгдсөн бол төрийн

жинхэнэ албанд эргэж ороход мэргэшлийн шалгалт өгч байхаар зохицуулалт хийгээд байна.

Учир нь төрийн улс төрийн албан тушаал эрхлэх, эсвэл төрийн алба хашихаас өөрийн хүсэлтээр татгалзах нь хувь хүний сонголт, эрхийн асуудал бөгөөд харин төрийн жинхэнэ албыг орхихын өмнө энэ сонголтынхоо учир холбогдлыг сайтар ойлгож, ухамсарлахыг шаардаж байгаа хэрэг болно. Ингэснээр төрийн жинхэнэ албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн жинхэнэ албыг өөрийн итгэл үнэмшлээр, сэтгэл гарган гүйцэтгэх чин эрмэлзэлтэй хүмүүсээр бүрдүүлэх, төрийн жинхэнэ албаны мэргэшсэн, тогтвортой байх “Мерит” зарчмыг хангах нөхцөл бүрдэх юм.

Гэвч намын харьяаллаас хамаарч туйлшрах, улс төрийн намуудын шахалт, шаардлагад автах байдлаар энэхүү сонголтыг хийснээс төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зөрчигдөх, улмаар гомдол маргаан үүсэх нөхцөлийг бүрдүүлж байгаа нь саяхны орон нутгийн хурлын сонгуулийн үеэр ажиглагдаж байна.

- Төрийн байгууллага нь Иргэний хуульд заасан хуулийн этгээдийг (нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар) өөрчлөн байгуулах, эсхүл зохион байгуулалтын бүтэц нь өөрчлөгдөхөд “бүтцийн өөрчлөлт” хэмээх ямар ч хуульд байхгүй нэр томъёоны дор төрийн жинхэнэ албан хаагчдыг үндэслэлгүйгээр ажлаас халах, чөлөөлөх явдал ялангуяа УИХ, Засгийн газар шинээр байгуулагдах бүр ихээхэн давтагдах хандлагатай явж иржээ.

Иймд үүнийг таслан зогсоож, төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг хэрэгжүүлэх үүднээс дээрх тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаал (ажлын байр)–ын тодорхойлолтонд заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн бол түүнийг уг албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах талаар шинээр заалт нэмж, харин хоёр болон хэд хэдэн байгууллага нэгдэж, нийлснээс тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаал (ажлын байр)–ын орон тоо цөөрсөн бол уг албан тушаалыг эрхэлж байсан хүмүүсийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, мэдлэг, ур чадвар, ажлын дадлага, туршлага зэргийг харгалзан тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн сайн хангаж буй албан хаагчийг томилох эрх бүхий албан тушаалтан шалгаруулж авахаар хуульчилсан билээ.

Үүнийг энд зориуд тэмдэглэж байгаа нь шинээр зохион байгуулагдаж байгаа өнөөгийн Засгийн газрын үед ч хуулийн энэхүү заалтыг сайтар ойлгож, төрийн жинхэнэ албан хаагчийн эрхийг хөндөхгүй байхыг холбогдох байгууллага, албан тушаалтнуудын

анхааралд хандуулахыг зорьсон хэрэг юм.

Төрийн жинхэнэ албан тушаал болон төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг тогтоож өгөөгүйгээс төрийн жинхэнэ албанд анх орох иргэнийг болон төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах, сул орон тоог эдгээр сонгон шалгаруулалтын үндсэн дээр нөхөх үйл явцад хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдох, төрийн жинхэнэ албаны сул орон тоог нийтэд зарлахдаа уг ажлын байранд тавигдах шаардлагыг тодорхой нэг хүнд тохируулан боловсруулах хандлага түгээмэл байсаар ирснийг харгалзан төрийн албан тушаалд тавих тусгай шаардлагыг батлан мөрдүүлж байхаар хуульд тусгаад байна.

Үндсэн хуулийн дөчин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана.”, ТАТХ-ийн 3.4-т “төрийн захиргааны болон төрийн тусгай албыг төрийн жинхэнэ алба гэнэ” гэж заасан.

Төрийн албаны тухай хуулийн 2002 оны шинэчилсэн найруулгаар төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүрэг, эрх болон хориглох зүйл, төрийн жинхэнэ алба эрхлэх болзол, журам, сул орон тоог нөхөх, туршилтын хугацаа, төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас чөлөөлөх, халах, сахилгын шийтгэл ногдуулах зэрэг асуудлыг нийтлэг байдлаар зохицуулах эрх зүйн орчин бий болсон тул төрийн жинхэнэ албан тушаалын ангилал, зэрэглэлийг нийтлэг байдлаар тогтоох нь зүйтэй гэж үзэж холбогдох зохицуулалтыг хийгээд байна.

Өнгөрсөн оны 12 дугаар сард зохион байгуулсан “Хохирогчийн эрхийн баталгаа” сэдэвт Хүний эрхийн үндэсний чуулган дээр Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр хэлсэн үгэндээ “Төрийн албан хаагчийг хууль бусаар халж, чөлөөлөх явдал тасрахгүй байна...Намчирхах, нутгархах, тал тохой татах, төрөл садансах зэрэг янз бүрийн ашиг сонирхлын зөрчлийн үүднээс төрийн албанд ажиллаж байгаа иргэнийг дур зоргоороо халж сольсон удирдах албан тушаалтныг тухайн албан тушаалын шаардлагыг хангахгүйгээ харуулсан гэж үзэж хариуцлага тооцож байх нь зүйд нийцнэ” гээд Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдлыг хангах, төрийн албан хаагчийн эрхийн баталгааг сайжруулах талаар Төрийн албаны төв байгууллага үзэгдэж харагдахуйц ажил хийж, ахиц гаргах шаардлагатай байгааг цохон тэмдэглэсэн билээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан Улсын Их Хурлаар батлуулсан “Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-д Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн эрх мэдлийг нэмэгдүүлэх талаар олон чухал асуудлыг

Энэ хүрээнд юуны өмнө төрийн алба (түүний дотор хүний нөөцийн удирдлага)-тай холбогдсон асуудлаар гарсан эрх бүхий албан тушаалтны хууль бус шийдвэрийг хүчингүй болгох эрх хамаарч байна.

Төрийн албан тушаалдавч ажиллуулахыг хориглосон болон төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөхөх талаарх хуулийн заалтыг зөрчиж иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд томилсон, түүнчлэн төрийн жинхэнэ албан хаагчийг ажлаас үндэслэлгүйгээр халсан болох нь тогтоогдсон тохиолдолд төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг Төрийн албаны төв байгууллага хүчингүй болгох эрхтэй байх нь төрийн албаны хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн албаны стандартын удирдлагыг хэрэгжүүлэхэд маш чухал ач холбогдолтой. Өмнө нь ийм эрх хэмжээ байхгүй байснаас хуулийн дээрх заалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага тодорхой бус, хохирсон иргэд шүүхэд энэ асуудлаар хандахаас бэрхшээн хохирлоо барагдуулж чадалгүй үлдэх нь цөөнгүй байлаа.

Түүнчлэн, ТАТХ-ийн 39.1-д зааснаар Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон (төрийн жинхэнэ албан тушаалд орох, албан тушаал дэвшүүлэх, бууруулах, сургалтанд хамруулах, цол, зэрэг дэв олгох, цалин хөлсийг өөрчлөх, шагнаж урамшуулах, төрийн албанаас чөлөөлөх, түр чөлөөлөх, төрийн албанаас халах, сахилгын шийтгэл ногдуулах зэрэг) асуудлаар гарсан маргааныг хянан шийдвэрлэх бүрэн эрх Төрийн албаны зөвлөл болон түүний салбар зөвлөлүүдэд байдаг хэдий ч УИХ-ын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан маргаан хянан шийдвэрлэх журамд зааснаар зохих журмаар байгуулагдсан маргаан хянан шалгах комиссын “дүгнэлт”-ийг Зөвлөлийн хуралдаанаар хянан хэлэлцээд, уг дүгнэлт үндэслэлтэй эсэхийг ТАЗ-ийн тогтоолд зааж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлдэг, түүнийг эс зөвшөөрсөн тал нь шүүхэд гомдлоо гаргах эрхтэй байсан билээ.

Ийнхүү Төрийн албаны зөвлөл нь маргаантай асуудлаар гарсан эрх бүхий албан тушаалтны шийдвэртэй шууд харьцдаггүйгээс ТАЗ-ийн шийдвэр биелэгдэхгүй, төрийн жинхэнэ албан хаагчийг удаан хугацаагаар чирэгдүүлэх, хуульд заасан хугацаа алдах, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх зэрэг сөрөг байдал давтагдсаар ирсэн юм. Энэ асуудал дээрх судалгааны багийн дүгнэлтэнд ч дурдагдаж байсан билээ.

ТАТХ-д нэмэлт, өөрчлөлт орсноор төрийн жинхэнэ албан тушаалдавч ажиллуулахыг хуулиар хориглосон тохиолдлыг зөрчин ажилд авсан, төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах талаар хуульд заасан дараалал, шаардлагыг зөрчсөн болон ажлаас үндэслэлгүйгээр халсан нь тогтоогдсон зэрэг төрийн жинхэнэ албаны хүний нөөцийн удирдлагатай холбогдох асуудлаар гарсан эрх бүхий албан тушаалтны энэхүү хууль бус шийдвэрийг Төрийн албаны төв байгууллагаас шууд өөрчлөх буюу хүчингүйд тооцож, буруутай албан тушаалтанд шүүгч хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэж байхаар боллоо.

Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйл (Төрийн албаны зөвлөлийн бүрэн эрх)-ийн 35.1.2-т орсон өөрчлөлтөөр "...энэ хуулийн 39.1-д заасан маргааныг хянан шийдвэрлэх, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учирсан хохирлыг арилгуулахаар төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах" эрхтэй байхаар зохицуулалт орлоо.

Төрийн албаны төв байгууллагын гаргасан шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй албан тушаалтныг шүүгч 25000-40000 төгрөгөөр торгохоор заасан юм.

Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт Төрийн албаны Зөвлөлийн салбар зөвлөл байдаг бөгөөд, яаманд Төрийн нарийн бичгийн дарга, агентлагт дарга, аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тухайн Тамгын газрын дарга толгойлдог. Эдгээр салбар зөвлөлийн үйл ажиллагаа болон гаргасан шийдвэрийн талаарх гомдлыг Төрийн албаны зөвлөл хянаж барагдуулдаг бөгөөд 2007 онд 100, 2008 оны эхний хагаст 40 орчим гомдол маргааныг хянан шийдвэрлээд байна. Ирж байгаа гомдол, маргааны дийлэнх нь ажлаас үндэслэлгүйгээр халагдсан, албан тушаал, зэрэг дэв, цалин бууруулсан тухай албан тушаалтны шийдвэрийг салбар зөвлөл хянаад хэвээр үлдээсэн тухай маргаан эзэлж байна. Салбар зөвлөлөөр хянагдаж байгаа гомдол, маргаан болон гаргаж байгаа шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хангуулах талаар байнга зөвлөгөө үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш Төрийн албаны зөвлөлд ирсэн ажлаас үндэслэлгүйгээр халагдсан тухай 5, сонгон шалгаруулалт хууль зүйн дагуу явагдаагүй тухай 5, албан тушаал, цол, зэрэг дэв, цалин бууруулсан тухай 2 гомдол маргаан ирснийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хянан хэлэлцэж, салбар зөвлөлийн 3 тогтоол болон

удирдах албан тушаалтны 4 хууль бус шийдвэрийг тус тус хүчингүй болгон шийдвэрлэж, төрийн албан хаагчийг ажилд нь эргүүлэн томилуулаад байна.

Нийслэлийн захиргааны хэргийн шүүх 2007 онд төрийн албанаас үндэслэлгүйгээр халагдсан, чөлөөлөгдсөн талаар гаргасан 32 нэхэмжлэлээс нэхэмжлэгч, хариуцагч эвлэрсэн буюу нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан 3, шийдвэрлэсэн хэрэг 29, үүнээс нэхэмжлэлийг хангаж, ажилд нь эргүүлэн тогтоохоор шийдвэрлэсэн 19, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан 4, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон 6 байна. Түүнчлэн 2008 оны эхний хагаст нийт 19 хэрэг шийдвэрлэснээс 1 нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзаж, үлдсэн 18-аас нэхэмжлэлийг хангасан 6, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан 3, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон 9 хэрэг байна.

Илтгэлд дурдсан судалгааны багийн дүгнэлтэнд “Төрийн албаны салбар зөвлөл гэх хууль бусаар халах шийдвэр гаргасан албан тушаалтнаар ахлуулсан зөвлөл байх шаардлагагүй, харин түүний оронд хөндлөнгийн шинжээч, мэргэжилтнүүдээс бүрдсэн комисс дүгнэлтээ Төрийн албаны зөвлөлд танилцуулж байх механизм байж болохыг хуульчлах нь зүйтэй юм” гэж дурдсан.

Салбар зөвлөлийн дарга нь төрийн жинхэнэ албан хаагчийг томилж, чөлөөлөх эрх бүхий албан тушаалтан байгаа нь тухайн албан тушаалтанд хууль зөрчсөн шийдвэрээ эргэж харах шүүхийн хэллэгээр бол “урьдчилан шийдвэрлэх үйл ажиллагаа явуулах” боломж олгож байгаа сайн талтай ч ихэвчлэн гаргасан шийдвэрээ хамгаалж үлддэгээс төрийн албан хаагчийг удаан хугацаагаар чирэгдүүлэх, шат дамжлага болдгийг нуух хэрэггүй. Эдүгээ Төрийн албаны Зөвлөлийн салбар зөвлөлийг зарим газарт орон тооны байдлаар ажиллуулахаар хуульчлаад байгаа хэдий ч энэ асуудлыг хэрхэн зүй зохистой зохион байгуулах талаар ойрын хугацаанд яаралтай авч хэлэлцэх шаардлага тулгарч байгаа юм.

Цаашид:

Төрийн жинхэнэ албан тушаалд авч ажиллуулахыг хуулиар хориглосон тохиолдлыг зөрчин ажилд авсан, төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах талаар хуульд заасан дараалал, шаардлагыг зөрчсөн болон ажлаас үндэслэлгүйгээр халсан, төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг харгалзахгүйгээр цалин хөлс, цол, зэрэг дэв, албан тушаал бууруулсан нь тогтоогдсон зэрэг төрийн жинхэнэ албаны хүний нөөцийн удирдлагатай холбогдох асуудлаар гарсан эрх бүхий албан тушаалтны хууль бус шийдвэрийг Төрийн албаны

төв байгууллага өөрчлөх буюу хүчингүйд тооцохоор шийдвэрлэсэн тохиолдолд буруутай албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож байх, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учирсан хохирлыг арилгуулах, төрийн албанд ажиллаж байгаа иргэнийг дур зоргоороо халж сольсон удирдах албан тушаалтныг тухайн албан тушаалын шаардлагыг хангахгүйгээ харуулсан гэж үзэн зохих хариуцлага тооцох тухай саналыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд өргөн мэдүүлдэг байх

Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зөрчигдсөн тухай гомдол, маргааныг хянан шийдвэрлээд гаргасан шийдвэрийн эцсийн үр дүнгийн талаарх мэдээллийг гомдол гаргагч төрийн албан хаагч өөрөө эргэж мэдээлдэг байх, төрийн захиргааны байгууллагууд болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ч өөр хоорондоо албан ёсоор мэдээлэл солилцож, ерөнхий дүнг олон нийтэд мэдээлдэг болох

Төрийн жинхэнэ албан хаагчдыг танил тал, намын харьяалал харгалзах болон “бүтцийн өөрчлөлт” нэрээр үндэслэлгүйгээр ажлаас халсан, албан тушаал бууруулсан, ёс зүй зөрчсөн, албан тушаалаа урвуулан ашигласан зэрэг асуудлаар зөвхөн гомдол, маргаан гарахыг хүлээж суух биш, харин энэ талаарх мэдээллийг бүртгэдэг бүртгэлтэй болж, мөрөөр нь шалгаж, арга хэмжээ авдаг тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.



М.АРИУНБАЯР

Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх
газрын орлогч дарга

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХҮНД СУРТЛЫГ БИЙ БОЛГОЖ БҮЙ ЗАРИМ АСУУДАЛ**

Өнөө үед засаглалын бүтэц тогтолцоо, түүний шат дамжлага болон үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төрийн албан хаагчаас шалтгаалан хувь хүний хөдөлмөр эрхлэх, үйл ажиллагаа явуулах, түүнтэй холбогдон гарах асуудлуудад эрх нь хөндөгдөж үүнийг хүнд суртал гэж нэрлээд бидний чихэнд нэгэнтээ танил болжээ.

Энэхүү хүнд суртал хэмээн нэрийдсэн үйлдэл, эс үйлдэхүй нь үйл ажиллагааны үндсэн болон бусад чиглэл онцлогоос хамаарч харилцан адилгүй байдаг байна. Хүнд суртал гэх энэ ойлголт нь хууль, түүнийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллага, энэ хүрээнд үйл ажиллагаагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн хоорондын харилцаанаас бий болсон үзэгдэл юм.

Иймд өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамаарч бий болж буй хүнд суртлын асуудлыг хөндөж байна.

Манай агентлаг нь 2005 онд Засгийн газрын шийдвэрээр Газрын тосны хэрэг эрхлэх газартай нэгдэж, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар болон байгуулагдаж Ашигт малтмалын тухай хууль, түүнийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдхүүний тухай хууль болон эдгээртэй холбогдох бусад хүчин төгөлдөр хуулиудыг хэрэгжүүлэн ажилладаг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм.

2006 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Ашигт малтмалын тухай хууль нь манай агентлагийн гол эрх зүйн баримт бичиг болж байна. Сүүлийн үед эрдэс баялгын салбар нь улс орны хөгжлийн тэргүүлэх салбарын нэг гэж тооцогдож байгаагаас улбаалан энэхүү салбарт үйл ажиллагаа явуулах сонирхолтой дотоод гадаадын маш олон аж ахуйн нэгж бий болсон. Энэ нь хэдийгээр зүй ёсны асуудал

боловч үүнтэй холбоотойгоор манай агентлагийн үйл ажиллагааг шүүмжилж хүнд суртал ихтэй, аж ахуйн нэгжийн эрх ашгийг маш ихээр хохироодог байгууллагын нэг гэж тооцож байна.

Агентлагийн үйл ажиллагаатай холбоотойгоор аж ахуйн нэгжүүдэд учирч буй хүндрэл, чирэгдэл нь өөрөөр хэлбэл хүнд суртал гэж нэрлэж буй энэхүү асуудал нь өнөөдөр харьцангуй өндөр байгааг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй юм. Үүнтэй холбогдуулан маш олон жишээ баримт, асуудлыг гаргаж тавьж болох хэдий ч зарчмын цөөн асуудлыг энд онцлон танилцуулъя.

Үүнд дараах асуудлуудыг хөндөж байна.

-Агентлагийн үйл ажиллагааны дотоод болон гадаад үйл ажиллагааны харилцан уялдаа холбоо.

-Мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журмууд болон түүний хэрэгжилтийг хангаж буй байдал

-Үйлчлүүлж буй аж ахуйн нэгж байгууллага, хувь хүний асуудал

Хүнд суртал, аж ахуйн нэгжийн эрх ашиг буюу цаашилбал хүний эрхтэй холбогдох энэхүү асуудлуудыг хөндөн ярилцахдаа хамгийн түрүүнд өөрсдийн үйл ажиллагааны өнөөгийн бодит байдал, энэ нь бусад төрийн болон орон нутгийн байгууллагуудтай хэрхэн уялдаж байгаа, хууль тогтоомжийн уялдаа холбоо, мөн хүнд сурталд өртөж буй аж ахуйн нэгжүүдийн өөрсдийн нь асуудлыг хамруулахыг зорилоо.

Цаашид илтгэлдээ хүнд суртал гэж хэлэхээсээ илүү учирч байгаа болон учруулж байгаа хүндрэл бэрхшээл, саад тотгор гэж нэрлэх нь зүйтэй санагдаж байна. Учир нь эдгээрийн эцсийн дүгнэлт нь хүнд суртал, үүнтэй холбоотой эрх хөндсөн асуудал болох юм.

Манай агентлагийн хувьд хүнд суртал үүсэх хамгийн үндсэн нөхцөл, хүчин зүйлс бол төрийн албан хаагчдын мэдлэг ур чадварын байдал, мэдээллийн ил тод нээлттэй байдлаас шууд шалтгаалж байгаа гэдгийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Өнөөдөр ашигт малтмалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд агентлаг нь нэн тэргүүнд мэргэжлийн боловсон хүчнээр чадавхижуулах шаардлагатай байсан боловч энэхүү бодлого алдагдсанаас үүдэн аж ахуйн нэгжүүдэд цаг тухайд нь мэргэжлийн зөвлөгөө өгч чаддаггүй, эсвэл санаатай болон санаандгүй байдлаар өгдөггүй байдал бий болсон. Дотоод үйл ажиллагааны уялдаа холбоо нь ойлгомжгүй болж өөрт үл хамаарах мэргэжлийн асуудалд оролцох оролцоо ихэссэн нь ажиллаж буй мэргэжилтнүүдийн ажиллах орчинг

тодорхой бус болгох явдал байсаар байна. Мэргэжлийн өндөр чадвартай, салбарын үйл ажиллагааны онцлогийг мэддэг, мэдэрдэг, өөрөөр хэлбэл “амьдралын туршлагатай” боловсон хүчнүүд нь зонхилон үйлдвэрлэл дээр ажиллаж, “хэн нэгний” гэх тодотголтой төрийн албан хаагч ихэссэн нь үйл ажиллагаанд учруулж буй саад бэрхшээлийг нэмэгдүүлж байна. Агентлагт хандан үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдэд мэдээлэл асар их хаалттай байна. Тухайн аж ахуйн нэгжээс хандан гаргасан өргөдөл, хүсэлт, тайлан, мэдээ, гомдол, саналыг хэрхэн шийдвэрлэж байгаа, ямар хугацаанд, хэн гэдэг албан тушаалтан эсвэл мэргэжилтэн шийдэж буйг мэдэж байх нь тухайн аж ахуйн нэгж, хувь хүний асар том эрх байх ёстой байтал энэхүү мэдээлэл ор тас хаалттай байгаа юм. Аж ахуйн нэгжүүдээс өөрийнхөө асуудлыг ямар зарчмаар, ямар хугацаанд, ямар шат дамжлагатай шийдвэрлэх ёстойг мэдэх бүрэн эрхтэй бөгөөд энэ зарчим, хугацаа, үе шатыг дагаж мөрдөхийг шаардах эрхтэй. Гэтэл үүнийг олон нийтэд нээлттэй, ил тод байлгах асуудлыг бид бүрэн шийдвэрлэж чадаагүй байгаагаас хүндрэл чирэгдэл үүсгэж, төрийн байгууллагын шуурхай байх зарчмыг алдагдуулж байгаа юм. Ашигт малтмалын тухай хууль бүрэн дүүрэн хэрэгжихэд агентлаг зөвхөн дотоодынхоо асуудлыг шийдвэрлэх бус гадаад тал буюу бусад төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, орон нутгийн байгууллагуудаас энэхүү хуультай холбоотой өөрт хамааралтай хэсгийг биелүүлэхийг шаардах, хууль эрх зүйн болон мэргэжлийн зөвлөгөө өгөх, хамтрах зэрэг асуудлыг хэрэгжүүлэх ёстой юм. Энэ асуудал үндсэндээ орхигдоод байна.

Хууль тогтоомжинд заасан зарим нэг заалтууд нь хоорондоо цаг хугацааны хувьд нийцэхгүй, мэргэжлийн онцлогийн нэгдмэл байдлыг тусгаагүй, цаг үеийн шаардлагыг харгалзаагүй зэргээс хүндрэл үүсгэдэг байдал манай агенлагт байна. Энд тодорхой ганц нэг жишээг дурдъя. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгохдоо аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын саналыг авахаар тусгасан хугацаа нь энэхүү асуудлыг тухайн Иргэдийн төлөөлөгчдийн хурал хуульд нийцүүлэн, орон нутгийн эрх ашгийг бүрэн дүүрэн тусгаж шийдвэрлэхэд хангалтгүй байгаагаас санал өгөх хугацаа нь удааширч аж ахуйн нэгжүүдэд хуульд заасан хугацаанд нь тусгай зөвшөөрөл олгох асуудлыг нь шийдвэрлэх боломж олгодоггүй юм. Орон нутгийн иргэдийн байгууллага, Засаг дарга, түүний дэргэдэх болон харьяаллын байгууллагууд нь Ашигт малтмалын тухай болон бусад хуулиар хэрэгжүүлэхээр заасан үүргээ өнөөг хүртэл бүрэн биелүүлээгүй эсвэл биелүүлдэггүй, орон нутгийн хөгжлийн чиг хандлагаа тодорхойлоогүй, хуульд заасан бусад эрх үүргээ хэрэгжүүлж мэддэггүй эсвэл санаатай болон санаандгүй байдлаар зөрчих хандлага нь манай байгууллагаар үйлчлүүлж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хүндрэл бэрхшээл саад тотгорыг бий болгож байна. Геологи, уул уурхай болон түүний кадастрын асуудал хариуцсан нэгжүүд нь хоорондоо салшгүй уялдаа холбоотойг тусгалгүйгээр тус тусад нь ангид мэт авч үзсэн хуулийн зарим заалтууд нь

тухайн асуудлыг шийдвэрлэхэд эсвэл хэтэрхий олон дамжлага бий болгох, эсвэл зарчмын хувьд нэг ижил асуудлыг шийдвэрлэх боломжгүй болгосноос тус тусдаа өөр өөр байдлаар шийдвэрлэгдэж аж ахуйн нэгжүүдэд хүндрэл, саадыг учруулж байна. Ашигт малтмалын салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс хариуцлагатай байхыг бүхий л талаар шаардаж байгаа өнөө үед үүнийг улам сайжруулах, хуулиар олгогдсон эрхээ эдэлж байгаа шигээ үүрэг хүлээж, зөрчсөн үед нь түүнд таарсан хариуцлага ногдуулах боломжгүйгээс, бий болсон асуудлыг тохирсон хэмжээнд нь, тухайн цаг үед нь шийдэж болохгүй байгаа юм. Иймээс зарим асуудлын шийдвэр нь цаг хугацааны хувьд удааширч хүндрэлийн тухай, хүнд суртлын тухай ойлголтыг бий болгодог.

Тухайн хүний эрх бусад хүний эрхээр хязгаарлагдаж байдаг шиг зөвхөн дээрхи 2 байдлаас гадна үйлчлүүлж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь эргээд өөр үйлчлүүлэгчид эсвэл өөрт нь хүндрэлийг үүсгэдэг гэдгийг бас харгалзан үзэх нь зүйтэй. Төрийн байгууллага хэдийгээр өөрт байгаа алдаа дутагдлыг гэнэт нэг өдөр биш ч гэлээ аль болох богино хугацаанд засч залруулах нь зөв бөгөөд ийм боломж байгаа боловч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд шууд оролцох, нөлөөлөх ёсгүй учраас үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд явуулах, бусдын эрхийг хүлээн зөвшөөрч байхыг шаардах эрхтэй. Манай байгууллагаар үйлчлүүлж байгаа аж ахуйн нэгжүүд нь мэргэжлийн салбарт байгаа онцлогоо ойлгож ажиллах зайлшгүй шаардлагатай байна. Нийтлэг хамгийн гол дутагдал нь хүн болгон компанийн захирал болж болох авч, энэ салбарт ажиллаж байна гэдэг утгаараа мэргэжлийн геологич инженер, уул уурхайн инженер, санхүүгийн болон компьютерийн мэргэжилтэн болох боломж байхгүй гэдгийг ойлгохыг хүсч байна. Мэргэжлийн бус хүмүүс тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргахдаа бичиг баримтаа дутуу бүрдүүлэх, мэдээ тайлан, төлөвлөгөөг хүргүүлэхдээ мэргэжлийн шаардлага, журам, заавар, стандартуудыг хангаагүй байгаагаас өөртөө асуудал үүсгэх, үүнийгээ шийдвэрлэх боломжгүй эсвэл дутуу дулимаг шийдвэрлэсэн байдлаасаа болж бий болсон хүндрэлээ тухайн төрийн захиргааны байгууллага эсвэл төрийн албан хаагчын хүнд суртал хэмээн нэрийдэх явдал нэлээн түгээмэл байгааг дурьдах нь зүйтэй. Төрийн захиргааны байгууллага гэдэг утгаараа бид өргөдөл, хүсэлтийг нь судлан үзэж шийдвэрлэх, бодит зааврын дагуу бэлтгэсэн мэдээллийг хүлээн авч, дахин боловсруулж нэгдмэл мэдээллийн сан бий болгох, үүнийхээ үндсэн дээр эрдэс баялгийн салбарын өнөөгийн байдал, хэтийн төлөвийн чиг хандлагыг боловсруулах үүрэгтэй билээ. Энэхүү үүргээ биелүүлэх үүднээс тодорхой шаардлагыг холбогдох журам, зааврыг мөрдлөг болгон тавьж, хэрэгжүүлж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдээс шаардах нь зүй ёсны хэрэг юм. Ийм шаардлагыг нэгдсэн журам зааврын хүрээнд хийж гүйцэтгэхийг бид өөрсдийн мэргэжилтнүүдэд үүрэг болгож байгаа бөгөөд аж ахуйн нэгжүүд мэргэжлийн ажилтан байхгүйгээс болж биелүүлэх боломжгүй байгаа нь өөрт болон бусдад хүндрэл үүсгэж

байна. Иймээс тодорхой хэмжээнд геологи уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүд нь мэргэжлийн боловсон хүчинтэй байх нь хүндрэл, саад тотгорыг арилгахад маш их дөхөм болно.

Хэдийгээр энэ мэтчилэн олон өөрсдөөс хамаарах болон эс хамаарах байдлаас шалтгаалан учирч буй хүнд суртлын бодит тохиолдлуудыг нэрлэж болно. Гэхдээ энэ нь зайлшгүй байх ёстой зүйл гэж үзэхгүй байгаа ба манай агентлаг нь өөрсдийн хүч бололцоонд тулгуурлаж, бий болсон дутагдалтай асуудлуудыг шийдвэрлэхээр шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Эцэст нь дээрхи хүнд суртлыг бий болгож буй асуудлуудыг судлан дараахь дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Төрийн захиргааны байгууллага болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллагуудын харилцан уялдааг сайжруулах, холбогдох мэдээ мэдээллийг цаг алдалгүй түргэн шуурхай солилцох боломжийг бүрдүүлэх, цахим нэг сүлжээнд холбох, хамтран ажиллах талаар бусад төрийн байгууллага ч тэр манай агентлагийн зүгээс ч мөн адил нэлээн идэвхи чармайлт гаргах хэрэгтэй байна.

Мэргэжлийн салбарт ажиллах боловсон хүчний сонголтыг оновчтой хийх, тэдгээр ажилтан албан хаагчдыг чадавхижуулах, ёс суртахууны хэм хэмжээг нь дээшлүүлэх нь зүйтэй байна.

Ашигт малтмалын тухай хууль, түүнийг дагаж гарсан журмыг цаашид улам боловсронгуй болгох, хуульд тусгагдсан зарим нэр томъёог нэг мөр ойлгомжтой болгон хэрэглэх нь зүйтэй байна.

Ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компани, иргэдийн дунд сургалт зохион байгуулах, шинээр батлагдсан дүрэм журмуудыг сурталчлан таниулах зэрэг үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, аж ахуйн нэгжүүд мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байх зэрэг нь хүндрэл учрах нөхцөлийг эрс багасгана гэж үзэж байна.



Д.ОЮУНЧИМЭГ

Гаалийн ерөнхий газрын дэд дарга

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДАЛ БА ХҮНИЙ ЭРХ

Гаалийн байгууллага нь өөрийн хариуцсан асуудлаар хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж, төр засгийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгжид хүргэх үүрэгтэй байгууллага юм. Хуулийг албадан сахиулах шийдвэр гаргадаг төрийн тусгай чиг үүргийн байгууллагын хувьд хүний эрхийн асуудалтай холбогддог билээ.

1281 – Гааль сонсож байна

Гаалийн байгууллагын талаар нийгэмд үүссэн ташаа ойлголт, гаальд байгаа ажлын дутагдлууд нь нээлттэй, ил тод үйл ажиллагаа дутсантай шууд холбоотой юм. Энэ байдалд бид дүгнэлт хийж, шат дараалсан тодорхой ажлуудыг төлөвлөн хийж байна.

1996 оны Гаалийн тухай хуулийг шинэчлэн найруулж УИХ-аар батлуулан 2008 оны 7 дугаар сарын 1-ээс эхлэн хэрэгжүүлж эхэллээ. Гаалийн шинэ хуульд “Гаалийн хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, зөвлөгөө” гэсэн “Гуравдугаар бүлэг”-ийг тусгайлан нэмж оруулсан байгаа.

Хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 1281 гэсэн шууд утас ажиллуулж байна. Энэ утсан дээр “Гаалийн зөвлөх” болон түүнээс дээш цолтой гаальчид ажиллаж, гаалийн асуудлаар лавлагаа өгч, үйлчлүүлэгчдийн санал хүсэлтийг хүлээн авч шуурхай барагдуулахад анхаарч байна. Шуурхай утас ажиллуулж эхэлсэн 7 дугаар сарын 1-ээс хойшхи хугацаанд нийт 541 асуулт тавьж, 71 санал гомдол иржээ. Түүнчлэн Улаанбаатар, Замын-Үүд зэрэг томоохон гаалийн газруудад мэдээллийн автомат машин ажиллуулж эхэлсэн.

Гаалийн байгууллага 2008 оныг Гааль, бизнесийн түншлэлийг хөгжүүлэх жил болгон зарлан ажиллаж байна. МҮХАҮТ-тай хамтран Гааль, бизнесийн зөвлөлдөх хороог байгуулж, мэргэжлийн холбоодтой ажилладаг боллоо. Ноос, ноолуур, хүнс, барилгын

материал, арьс шир, шувууны аж ахуйны үндэсний бизнес эрхлэгчидтэй тогтмол уулзалт хийж, тэдний санал, хүсэлтийг сонсч, учирч байгаа саад бэрхшээлийг арилгах, цаашдын үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна. Харьяа гаалийн газар, хороод өөрсдийн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудтай зөвлөлдөх уулзалтуудыг хийж эхлээд байгаа бөгөөд цаашид энэ ажлыг тогтмолжуулна.

Гаалийн ил тод байдлыг хангах зорилгоор бид бүтцийн өөрчлөлтийг хийсэн. Тухайлбал, УГЕГ болон харьяа байгууллагуудад гаалийн хууль тогтоомж, бүрдүүлэлтийн үйл ажиллагааг олон түмэнд тайлбарлан таниулах үүрэг бүхий нэгжийг байгуулан ажиллаж байна. Хэрэг зөрчил гарсны дараа бус гарахаас өмнө урьдчилан сэргийлж ажиллахад гол анхаарлаа чиглүүлэх зарчмын бодлогыг гаальчдын өмнө дэвшүүлэн ажиллаж байгаа. Гаалиар үйлчлүүлэхээр ирж буй иргэдэд гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа тов тодорхой, ойлгомжтой байх ёстой. Гаалийн дүрэм, журам, хяналтын үйл ажиллагаа иргэдэд ил тод бус, хаалттай байх тусам гаалийн байцаагчийн эрх мэдэл нь “нэмэгдэж”, гуйлгаж, улмаар шан харамж авах хөрс бүрдэдгийг бид мэдэж байгаа. Тийм ч учраас бидний дунд энэ бодлогыг хэрэгжүүлэхэд гардан оролцож хувь нэмрээ оруулахгүй, гаалийн байгууллагыг аль болох хаалттай байх сонирхолтой гаалийн ажилтнууд мэр сэр байгааг нуух юун. Иймд бид өөрсөддөө шүүмжлэлтэй хандаж, гаалийн байгууллагыг ил тод болгох чиглэлээр хийх ажил бидний өмнө их байгааг ухаарч, тууштай ажиллах болно.

Гаалийн үйл ажиллагааны ил тод бус байдлыг хувийн ашиг хонжоо олох гэсэн зарим этгээд овжноор ашиглаж, гааль, иргэн, аж ахуйн нэгжийн хооронд “сайн дурын зуучлалыг” явуулж, нийгэмд зохисгүй уур амьсгал бүрдүүлж, гаалийн байгууллагын нэр хүндэд халдаж байна.

Гаалийн зуучлагч болон бусад институц

Гаалийн үйл ажиллагааг ил тод, ойлгомжтой, нийтэд дөхөм болгоход гаалийн байгууллагын шууд үйл ажиллагаанаас гадна гааль, бизнес эрхлэгчдийн дунд зуучлах үүрэг бүхий ГААЛИЙН ЗУУЧЛАГЧИЙН институц байдаг. ГААЛИЙН ЗУУЧЛАГЧ гэдэг нэрнээсээ үйл ажиллагаа нь тодорхой ойлгогдож байгаа биз ээ. Энэ институц Монгол Улсад 10 гаруй жилийн өмнө бий болж, үйл ажиллагаа явуулж байгаа боловч олон улсын хэмжээнд байдаг сонгодог утгаараа төдийлөн ажиллаж чадахгүй байна. Гаалийн харилцаанд оролцогч аливаа этгээд заавал гаалийн бүх дүрэм, журмыг мэдэх шаардлагагүй. Бизнес эрхлэгчийг төлөөлж гаалийн байгууллагатай эрх зүйн харилцаанд орж, түүний бараанд гаалийн бүрдүүлэлт хийлгэх эрх, үүрэг бүхий гаалийн зуучлагч байгууллагуудад гааль болон аж ахуйн нэгжүүд шаардлага тавьж ажиллах цаг нэгэнт болжээ.

“Гаалийн шинэчлэл” төсөл – Үндэсний нэг цахим цонх

Гаалийн байгууллага өөрийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгох, мэдээллийн нээлттэй байдлыг хангах, гадаад худалдааг хөнгөвчлөх, гаалийн бүрдүүлэлтийг хялбарчлах ажлыг 2009-2012 онд баримтлах стратегийн зорилтоо болгон ажиллаж байна.

Азийн хөгжлийн банк, БНСУ-ын Засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа “Гаалийн шинэчлэл” төслийн хүрээнд мэдээллийн автоматжуулсан нэгдсэн системийг бий болгосноор ЦАХИМ ГААЛЬ сонгодог утгаараа бий болж, гаалийн үйл ажиллагааг бүрэн автоматжуулж, бизнес эрхлэгчид гаалийн байгууллагад сүлжээгээр мэдүүлэх, татвар тооцоог хийх боломжийг бүрдүүлж, аливаа хүнд суртлыг арилгах, гаалийн ажилтан, бизнес эрхлэгчдийн “нүүр тулсан” (Face-to-Face Contact) харьцааг халах боломжтой болно. Хөгжингүй орнуудад гаалийн байцаагч экспортлогч, импортлогч компани байтугай гаалийн зуучлагчтай “нүүр тулж” харьцдаггүй бөгөөд гагцхүү компьютерээр дамжуулан ажил үүргээ гүйцэтгэж байдаг.

Төслийг 2010 онд багтаан хэрэгжүүлэх бөгөөд гаалийн мэдээллийн автоматжуулалтыг хөгжингүй орны түвшинд хүргэх, гаалийн дэд бүтэц, хяналтын техник хангамжийг сайжруулах, гаалийн лабораторийг өргөжүүлэх зорилготой.

Автоматжуулалтын төвшнөөр гааль өнөөгийн нөхцөлд ч тэргүүлж байгаа бөгөөд 3 жилийн дараа цаасгүй бүрдүүлэлт рүү шилжих гэж байна. Гэвч гадаад худалдаанд оролцогч төрийн болон бизнесийн бусад байгууллагууд гаальтай хамт хөл нийлүүлж автоматжуулалтыг нэвтрүүлж, “ҮНДЭСНИЙ НЭГ ЦАХИМ ЦОНХ”-ыг хэрэгжүүлээгүй тохиолдолд гаалийн байгууллагын үйл ажиллагаанд бэрхшээл учирч, хүнд сурталгүй, түргэн шуурхай үйлчлэх зорилт бүрэн хэрэгжихгүй нь ойлгомжтой билээ.

Гадаад хүчин зүйлс-Хяналтын зохистой орчин

Хэдийгээр дээр дурдсан ажлуудыг гаалийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа боловч хүнд суртал, авлигатай нэр холбогдох явдал гарсаар байна. Энэ асуудлыг шийдэхэд гаальчид биднээс хамаарах зүйл байгаа боловч төр засгийн бодлогын хэмжээнд шийдвэрлэвэл зохих асуудлууд байна.

Гаалийн хэмжээнд авлигаас бүрэн ангижрахын тулд орчин үеийн хяналтын техник хэрэгслээр гаалийг хангах шаардлага нэн чухлаар тавигдаж байна. Мөн ачиж буулгах механикжсан ажиллагаатай ложистик терминалын аж ахуй байгуулж, ачаа тээврийг олон

улсын стандарт бүхий гаалийн битүүмжлэл тавих боломжтой тээврийн хэрэгслээр зөөх зэрэг тээвэр ложистикийн асуудлыг цогцоор нь холбогдох яам, агентлагуудыг оролцуулан шийдвэрлэх хэрэгтэй байна. Ингэснээр гаалийн байцаагчид зохих ёсоор хяналт тавих нөхцөл бүрдэж, өөрийн үзэмжээр бус цэгцтэй, хүнд сурталгүй, ил тод хяналтын үйл ажиллагааг явуулна. Тээвэр ложистикийн төвийг байгуулах эхний алхмыг Замын-Үүдээс эхэлж байгаа бөгөөд улсын эрх ашгийн үүднээс шуурхай, нэгдсэн бодлоготой хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Гаалийн байгууллага бол хууль хэрэгжүүлэх байгууллага билээ. Гэтэл дээд байгууллагаас гарсан шийдвэрүүд нь өөр хоорондоо зөрчилдсөн, ойлгомжгүй байгаагаас тухайн шийдвэрийг гаалийн байгууллага, импортлогч, экспортлогч өөр өөрөөр тайлбарлах, улмаар асуудлын шийдвэрлэлт удаашрах, эцэст нь гаалийн байгууллага руу бүх бурууг тохох, гааль асуудал шийдэхгүй хүнд суртал гаргаж буй мэт ташаа ойлгогдох байдал гарч байна.

“ҮЛ ТЭВЧИХ” бодлого (NON-TOLERANCE)

Аливаа байгууллага, тэр дотроо гаалийн байгууллагын ажлын амжилтын үндэс суурь нь боловсон хүчин билээ. Мэдлэгтэй, чадварлаг, оюунлаг, гаалийн сэтгэлгээтэй байцаагчийг олон болгохын төлөө бид ажиллаж байна.

Шударга ажилласных нь төлөө гаалийн байцаагчийн нэр төрд нь халдах, гүтгэх явдал байсаар байна. Энэ тохиолдолд гаалийн байгууллага өөрийн ажилтнаа тууштай хамгаалах болно.

Харин дүрэмт хувцас өмсөж, хүний эрхэнд тодорхой хэмжээгээр халдах хуулиар олгогдсон энэ эрхийг хэтрүүлж, ёс зүйгүй аашилж байгаа гаалийн байцаагчдын хувьд “ҮЛ ТЭВЧИХ” бодлого баримталж ажиллаж байна.

Ил тод байдлыг хөхиүлэн дэмжих, үйлчлүүлэгчдээ дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хангахын чухлыг гаалийн байгууллага бүрэн ухамсарлаж байгаа. Монголын гаальчид бид энэ үзэл бодлын дор нэгдмэл санаатай тууштай ажиллах болно. Төрийн бүх шатны байгууллагууд нэгэн жигд энэ чиглэлээр ажиллаваас бид хамтдаа тулгамдаж буй асуудлыг даван туулна гэдэгт итгэлтэй байна.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.



Ц.САНДУЙ

Нийслэлийн газрын албаны дарга

НЭЭЛТТЭЙ ГАЗРЫН ХАРИЛЦАА

Чуулганы төлөөлөгч Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Манай улс ардчилсан нийгэмд шилжиж, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн тунхагласнаас хойш багагүй хугацаа өнгөрч, төрөөс хүний хөгжлийг хангах, хүний эрхийг хамгаалах, түүнийг бодитойгоор хэрэгжүүлэхэд ихээхэн анхаарч ирлээ. Энэ чиглэлийн олон арга хэмжээ зохион байгуулж байгаагийн нэг нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор жил бүр болдог “Хүний эрхийн үндэсний чуулган” юм.

Хүний эрхийн хамгаалалт, түүний хэрэгжилт нь аливаа хууль тогтоомжийг хэрэгжүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэдэг, ялангуяа эрх, лизенз олгодог байгууллагуудын үйл ажиллагаатай шууд холбоотой байдаг. Төрийн захиргааны шинэтгэлийн хүрээнд төрийн захиргааны бүх шатны байгууллагуудын үйл ажиллагаа илүү нээлттэй, ил тод болж, иргэдэд хүрэх үйлчилгээний чанар сайжирч байгаа хэдий ч хуулийг нэг мөр дагаж хэрэгжүүлдэггүй, төрийн албан хаагчдын ёс зүй учир дутагдалтай, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг хангалтгүй зэрэг олон хүчин зүйлээс хамаарч хүний эрх зөрчигдөх, иргэд хохирох, нийгмийн шударга ёс алдагдах явдал байсаар байгаа нь иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын судалгаа, санал шүүмжлэлээс харагдаж байдаг юм.

Иймд нутгийн захиргааны болон мэргэжлийн байгууллагуудад хуулиар олгогдсон эрхийн хүрээнд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг илүү нээлттэй, ил тод явуулах, иргэн бүрд газрыг хүртээмжтэй, зүй зохистой хуваарилах, хүнд суртал, шат дамжлагыг багасгах зэргээр газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх явцад хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх хариуцлагатай үүрэг манай байгууллагын өмнө тавигддаг билээ.

Энэ зорилтоо хэрэгжүүлж, газрын харилцааг шударга байлгах, мэдээллийн ил тод,

нээлтэй байдлыг хангах, мэргэшсэн, ёс зүйтэй албан хаагчдыг төлөвшүүлэх замаар хүнд суртлыг үгүй болгох чиглэлээр сүүлийн үед зохион байгуулж байгаа ажлаасаа танилцуулахыг энэхүү илтгэлийнхээ гол зорилго болголоо.

Монголчууд эрт дээр үеэс газар дэлхийгээ дээдлэн шүтэж, онголон тахиж, хайрлан хамгаалж ирсэн боловч газрыг байгалийн баялаг, хамгийн үнэ цэнэтэй капитал гэдэг талаас нь төдийлөн харж байгаагүй юм. Харин Монгол Улс ардчилсан төрийн тогтолцоо, чөлөөт зах зээлийн харилцаанд шилжсэн 1990-ээд оноос энэ хандлага өөрчлөгдөж, газрын асуудал нийгмийн суурь харилцааны нэг болон төлөвшиж, улс орны эдийн засаг, иргэдийн амьдралд чухал нөлөөтэй хүчин зүйл болоод байна. Газрыг эзэмшиж ашиглах, өмчлөх замаар түүнийг эдийн засгийн эргэлтэнд оруулан, ашиг шимийг нь хүртэх гэсэн иргэдийн сонирхол сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байна.

Газар бол байгалийн чухал нөөц баялаг бөгөөд амьдралын эх үүсвэр, нийгмийн оршин тогтнож үйл ажиллагаа явуулах үндэс болохын зэрэгцээ хамгийн гол нь өмчлөлийн зүйл, үйлдвэрлэлийн хэрэгсэл, хөрөнгө оруулалт, бизнесийн эх сурвалж болж байдгаараа ихээхэн ач холбогдолтой байдаг. Хүн амын эрчимтэй өсөлт, үйлдвэржилт, шинжлэх ухаан, техникийн дэвшил, технологийн хөгжил нь газар, газраас үндэстэй байгалийн нөөц баялгийн хэмжээ хязгаар, байршлаас хүн төрөлхтний хувь заяаг улам хамааралтай болгож байна. Газрын нөөц бол хязгаарлагдмал, харин хүний хэрэгцээ шаардлага хязгааргүй гэдгийг харгалзан түүнийг эдийн засгийн эргэлтэнд бүрэн утгаар нь оруулах нь улс орны хөгжил, түүний дотор хувь хүмүүсийн амьдралд ихээхэн ач холбогдолтой юм.

Монгол Улсын газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг Улаанбаатар хотод улсын нийт хүн амын 38.9 хувь оршин сууж байна. Нийслэлийн хүн амын 94.1 хувь нь Улаанбаатар хотод, бусад нь хаяа хот, тосгодод амьдарч байна. Нийслэлийн нутаг дэвсгэрийн 470.0 мянган га газрын дөнгөж 6 хувийг хот тосгон, бусад суурины ангиллын газар эзэлж байгаа юм.

Хөдөө орон нутгаас шилжин ирэгсдийн тоо байнга нэмэгдэж, хотын газрын нөөц жил ирэх тусам багасаж байгаатай холбоотойгоор газрын эрэлт хэрэгцээ Нийслэл хотод их байна. Дэд бүтэц сайтай, сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн үйлчилгээнд ойр газарт амьдрахыг хэн боловч хүсэх нь зүйн хэрэг. Хот хаяагаа тэлэхийн хэрээр хотын төвд, ашигтай газарт байрлалтай үл хөдлөх эд хөрөнгийн үнэ улам бүр нэмэгдэж байна. Юм юмандаа ойр, дуу чимээ багатай, цэвэр эрүүл агаартай орчинд орон сууцны барилга барьж худалдах, хүн ам шигүү суурьшсан олны хөлийн газарт үйлчилгээний

газар ажиллуулах нь өнөөдөр хамгийн ашигтай бизнес болж, иргэд, бизнесийнхэн энэ зүгт хошуурах болсныг ч буруутгах аргагүй.

Газаргүй л бол “хүн биш” юм шиг ойлгож алга дарам ч болов газар олж авах гэж улайрах, хаана ч хамаагүй хашаа хатгаж, “хэзээ нэг цагт хэрэг болно” гэсэн сэтгэлээр хандан газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах биш, харин ч үхмэл хөрөнгө болгож байгаагийн аль аль нь буруу хандлага юм.

Газартай холбоотой асуудалд нийгэм бүхэлдээ анхаарал хандуулж, дээрээс дэмжлэг, доороос шүүмжлэл их байгаа нь Нийслэлийн газрын албаны үйл ажиллагааг ил тод, шударга явуулахыг зүй ёсоор шаардаж байгаа юм. Бид газартай холбоотой бүхий л асуудлыг иргэд, олон нийтэд нээлттэй байлгах, газар зохион байгууллалтын ажилд тэдний оролцоог нэмэгдүүлэхийг зорьж хичээж, энэ талаар багагүй ажил хийж байна.

Улаанбаатар хотын газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломжийг хангахын тулд тэдний төлөөлөл болох Нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгчидтэй нягт хамтран ажилладаг юм. Тухайн жилд иргэдэд эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалтыг Нийслэл, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган ИТХ-аар хэлэлцүүлж батлуулдаг бөгөөд энэ чухалт баримт бичгийн төслийг боловсруулахдаа дүүргүүдийн Засаг дарга, Нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдөөс урьдчилан санал авч, төслийг НИТХ-ын “Газрын хороо”-гоор хэлэлцүүлэн тал бүрээс нь нухацтай ярилцан байж батлуулдаг юм. Түүнээс гадна тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг байгууллагын вэб сайтад тавьж, иргэд олон нийтэд санал бодлоо илэрхийлэх боломж олгож байна.

Тухайн жилд газрын харилцааны асуудлаар нийслэл хотод мөрдөж ажиллах чухал баримт бичиг болох “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г олон нийтэд танилцуулах, мэдээлэл олж авах бололцоог хангахад бид бас чухал ач холболдол өгч ажиллаж байна. Жил жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг тусгай товхимол болгон хэвлүүлж, Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын болон өөрийн байгууллагын вэб сайтад байршуулж, “Нээлттэй хаалга”-ны өдрүүдээр иргэдэд тайлбарлан танилцуулж байна. НИТХ, түүний тэргүүлэгчид, Хурлаас байгуулагддаг ажлын хэсгийн гишүүд, нийслэлийн газрын харилцааны асуудлыг анхаарлынхаа төвд ямагт байлгаж, энэ талаар Нийслэлийн Засаг даргын тайлан, мэдээллийг сонсох, иргэд сонгогчдын гомдол мэдээллийн дагуу хяналт шалгалт хийх, газар дээр нь явж танилцах зэргээр ажиллаж байгаа нь хотын газар ашиглалтын байдал иргэдийн өдөр тутмын хараа хяналтанд байгаагийн баримт

гэж ойлгож болно.

Нийслэлд хот төлөвлөлт, газар ашиглалтын чиглэлийн хэд хэдэн төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа бөгөөд тэдгээрт иргэд, тэдний төлөөллийг аль болох өргөнөөр оролцуулахыг зорьж байна. Тухайлбал, гэр хорооллыг барилгажуулж, орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр, гэр хорооллын нөхцөлийг сайжруулах стратеги, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах төсөл зэрэгт тухайн хороо, хэсэгт амьдарч байгаа иргэдийн санал бодлыг тусгах, тэдний эрх ашигт нийцүүлэх бодлого баримталж байгаа юм.

Нийслэлийн газар ашиглалтыг зохион байгуулахдаа иргэд, олон нийтийн оролцоог хангаж байгаа нэг хэлбэр нь СӨХ-д орчны газрыг ашиглуулж байгаа явдал юм. 2008 оны 06 дугаар сарын 13-нд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Монголын Сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөлийн ерөнхийлөгч нар нийтийн зориулалттай орон сууцны байшингийн орчны газрыг СӨХ-үүдэд ашиглуулахад баримтлах 7 чиглэл бүхий харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, газрын маргаан, зөрчилгүй 187 сууц өмчлөгчдийн холбоодод орчны газрыг нь ашиглуулах шийдвэр гаргаж, Чингэлтэй дүүргийн 35, Баянгол дүүргийн 45, Сүхбаатар дүүргийн 20, Хан-уул дүүргийн 12 СӨХ-ийн орчны газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, газар ашиглуулах гэрээг байгуулаад байна.

Сүүлийн жилүүдэд иргэний нийгмийн байгууллагууд Нийслэлийн газрын харилцааны асуудалд онцгой анхаарал хандуулж, газрын маргаантай асуудлуудыг судалж, шийдвэрлэх зорилгоор Захирагчийн ажлын алба иргэний “Эрс шинэчлэл” хөдөлгөөнтэй хамтарч байгуулсан ажлын хэсгийн хүрээнд нийтийн эдэлбэрийн газар, ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбайд олгосон газруудын судалгаа гаргаж, газар дээр нь явж танилцан, санал дүгнэлт боловсруулж, шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

Бид байгууллагынхаа ажлыг хөнгөн шуурхай болгож, хүнд суртлыг арилгах, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр нэлээд ажлуудыг зохион байгуулж байгаа юм. Нийслэлийн газрын албанд Авлигатай тэмцэх дэд зөвлөл байгуулан, үйл ажиллагааны чиглэл, ажлын төлөвлөгөө гарган, ажлыг нь тогтмолжуулж байна. “Нийслэлийн газрын албаны хөдөлмөрийн дотоод журам”-д ажилтнуудын ёс зүйн асуудлаар тусгай бүлэг нэмж оруулан мөрдөж байна. Ажилтнууд дээр сахилга, ёс зүйн карт хөтөлж, энэ талаар тэдэнд тавих шаардлагыг өндөржүүлэн ажиллаж байна. Өнгөрсөн онд Нийслэлийн газрын алба, Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй

хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж, АТГ-аас төрийн байгууллагуудад хандаж гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр олон арга хэмжээ зохион байгуулсан нь үр дүнтэй болов.

Нэг ажлын байран дээр удаан хугацаагаар ажиллах нь ажиллагсдыг зогсонги, идэвхигүй, санаачилгагүй болгодог тал ажиглагддаг, нөгөө талаар хүнд суртал, авлигаас урьдчилан сэргийлэх үүднээс Нийслэл, дүүргийн газрын албаны нэлээд тооны ажилтнуудыг өөр хооронд нь сэлгэн ажиллуулав. Цаашид ч энэ ажлыг тодорхой дараалал, үе шаттайгаар хийж байх болно.

Нийслэл, дүүргийн газрын албаны ажлын уялдааг сайжруулах, зарим ажил, үйлчилгээний хэтэрхий төвлөрсөн байдлыг арилгаж, шат дамжлага, чирэгдлийг багасгахын тулд Газар өмчлөлийн хэлтсийн дүүрэг хариуцсан мэргэжилтнүүдийг хариуцсан дүүрэгт нь ажиллуулж байна. Ингэснээр иргэдийг нийслэл, дүүргийн газрын албаны хооронд нааш цааш олон дахин явуулж чирэгдүүлдэг дутагдал арилж байна.

Өмнө нь Нийслэл, дүүргийн Засаг дарга нар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд гарын үсэг зурж баталгаажуулдаг байсныг өөрчилж, газрын албаны дарга гарын үсэг зурж баталгаажуулдаг болсноор үйлчилгээний шат дамжлага цөөрч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргэдэг үйлчилгээ илүү хөнгөн шуурхай болж байгаа юм.

Бид Албаны үйл ажиллагааны үр дүнгийн талаар үйлчлүүлэгч-иргэдийн санал бодлыг сонсох, тэдний санал зөвлөгөө, шүүмжлэлийг ажилдаа тусгаж хэрэгжүүлэх талаар анхаарч, хэд хэдэн удаа иргэдийн дунд санал асуулга явууллаа.

Өнгөрсөн хавар их, дээд сургуулийн багш, судлаачдын багийг ажиллуулж, 281 иргэн, 50 аж ахуйн нэгж, байгууллагын дунд судалгаа явуулсан. Энэхүү судалгаа нь газрын албаны үйлчилгээний чанар, хүртээмж, тулгамдаж байгаа асуудлуудыг үйлчлүүлэгчдийн оролцоотойгоор, үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас хараат бус нөхцөлд судлах, түүний үр дүнд тулгуурлан Газрын албаны үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж гаргах зорилготой байлаа. Дээрх судалгаанд хамрагдсан нийт иргэдээс Нийслэлийн газрын албанаас үзүүлж буй үйлчилгээний 13 төрлийн 9 шалгуур үзүүлэлтээр санал авч, тухайн асуултад иргэдийн 2/3-оос дээш нь эерэг үнэлгээ өгсөн тохиодолд $+/$, түүнээс бага үнэлгээ өгсөн тохиодолд $-/$ тэмдэглэл хийж, нэгтгэн дүгнэхэд нийт 109 үнэлгээнээс 45 нь $+/$, 64 нь $-/$ байна. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцсон нийт иргэдийн 41.2 хувь эерэг үнэлгээ өгсөн байна.

Харин судалгаанд хармрагдсан 50 байгууллагаас үйлчилгээний 9 төрлийн 9 шалгуур үзүүлэлтээр санал авч, нэгтгэхэд 66 үнэлгээний 36 нь $+/$, бусад нь $-/$ үнэлгээ байна. Нийслэл, дүүргийн газрын албанаас үйлчлүүлэгч дээрх байгууллагуудын 54.5 хувь нь эерэг үнэлгээ өгчээ. Эндээс Нийслэл, дүүргийн газрын албаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ ойролцоогоор 50 хувь байна гэсэн дүгнэлт хийсэн юм.

Газрын албаныхан иргэдийг чирэгдүүлдэг, хүнд сурталтай, авлигачид гэж хэлүүлдэг нь иргэд олон нийтэд газар, газрын албатай холбоотой мэдээ, мэдээллийг түргэн шуурхай хүргэдэггүйгээс болж байна гэж үзэж байгууллагынхаа дотоод үйл ажиллагаанд мэдээллийн технологийн давуу талуудыг нэвтрүүлж ажиллах, мөн зарим үйлчилгээ, лавлагааг онлайнаар хүргэх ажлуудыг эрчимтэй авч хэрэгжүүлж байна. Жишээлбэл www.gazar.ub.gov.mn вэб сайтыг нээн ажиллуулж газартай холбоотой шийдвэр, газрын албад, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай мэдээ, мэдээллийг өдөр тутам иргэд, олон нийтэд хүргэж байна. Ийм мэдээллийг олон нийт хүсч байсан нь сайтыг ажиллуулсан 3 сард нийтдээ 60 гаруй мянган удаа хандаж мэдээлэл авснаас харагдаж байна. Түүнчлэн бид вэб хуудсаараа дамжуулан иргэдээс төрөл бүрийн судалгаа, санал асуулга авч байгаа бөгөөд “Иргэн та одоогоор газар өмчилж аваагүй бол хаана өмчилж авахыг хүсэж байна вэ” гэсэн асуултад оролцсон иргэдийн 75.52 хувь нь Улаанбаатар хотод газар өмчилж авахыг хүссэн бол 2.36 хувь нь “одоогоор шийдээгүй байна” гэж хариулжээ. Цаашид ийм хэлбэрийн санал асуулга, судалгааг байнга явуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг хичээх болно.

Мөн www.cityland.mn вэб сайтыг нээн ажиллуулж газар эзэмших эрхийн барьцааны тухай мэдээллийг нийтэд нээлттэй болгож, газрын төлбөрийн бүсчлэл, хэдэн төгрөг төлөх ёстойгоо шууд мэдэх боломжийг бүрдүүлж байна. Жишээлбэл газрын барьцааны тухай мэдээлэл нь арилжааны банкуудад маш чухал мэдээлэл байдаг бөгөөд банкууд энэ үйлчилгээг таатай хүлээж авч, хамтарч ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлж байна. Бусдаас газрын эрхийг шилжүүлж авах гэж байгаа этгээд тус газрын эрх банкны барьцаанд байгаа, эсэх мэдээллийг шууд интернэт ашиглан авах боломж бүрдлээ.

Бид байгууллага дээрээ үйлчлүүлэгч, иргэдэд мэдээ, мэдээллийг хүргэх зорилгоор өндөр хурдны интернэтийн холболт бүхий “Мэдээллийн төв”-ийг нээн ажиллуулж эхлээд байна. Тус мэдээллийн төвөөр үйлчлүүлсэн хэн боловч интернэтийг үнэгүй ашиглахаас гадна, манай вэб сайтууд руу хандаж, хэрхэн мэдээлэл авах талаар зөвлөгөөг авч, олж авсан мэдээллээ хэвлэх, хувилах зэрэг үйлчилгээг авах боломжийг бүрдүүлж өгөөд байна. Ийнхүү байгууллагаа нээлттэй, ил тод, иргэд олон нийтэд хүргэдэг үйлчилгээгээ түргэн шуурхай, чанартай хүргэх ажлуудыг зохион байгуулж байгаа бөгөөд цаашид ч олон

ажлыг төлөвлөөд байна.

Цаашид газрын харилцааны шинэчлэлийг эрчимжүүлэх, үйлчилгээг улам бүр сайжруулахын тулд дараах хэдэн асуудалд илүү анхаарал хандуулах ёстой гэж бид үзэж байгаа юм.

Нийслэл, дүүргийн газрын албаны үйл ажиллагааг илүү ил тод, тунгалаг байлгах, үүний тулд үйл ажиллагааны талаарх сурталчилгааг сайн хийж, интернет ашиглаж мэдээллийн нээлттэй байдлыг хангаж ажиллах.

Үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ялангуяа газар зүйн мэдээллийн системд тулгуурлан нийслэлийн газар ашиглалтын хэрэгцээг тодорхойлж, дараа жилийн газар зохион байгуулалтын төлөвлөлтийг оны эхнээс боловсруулж, иргэд, олон нийтэд жилийн туршид санал бодлоо илэрхийлэх боломж олгох.

Ажлын шат дамжлагыг цөөлөх, зарим дүрэм журмыг хялбаршуулах чиглэлээр эрх бүхий байгууллагад санал гаргах. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг бусдад шилжүүлэх, хугацааг сунгах зэрэг зарим ажил, үйлчилгээг бүртгэлийн аргаар зохион байгуулах, өөрөөр хэлбэл энэ бүхэнд Засаг даргын захирамж гаргахгүйгээр Газрын албаны дарга шийдвэрлэдэг болох асуудлыг тавьж шийдвэрлүүлэх.

Нийслэл, дүүргийн газрын албаны үйл ажиллагааг онлайн хэлбэрт оруулж, цахим үйлчилгээг улам боловсронгуй болгох зорилт тавьж байна. Жишээ нь газрын төлбөрийн нэмэмжлэл, өргөдөл, албан бичгийн хариу, архивын лавлагаа зэргийг онлайн хэлбэрээр өгөх боломж байгаа гэж үзэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.



Б.ГАНБААТАР

Монголын Өмгөөлөгчдийн Холбооны удирдах
зөвлөлийн гишүүн,
“Элч” хууль зүйн товчооны захирал

**ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД
ТУЛГАРЧ БҮЙ ХҮНД СУРТАЛ**

Өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нийгмийн харилцааг зохицуулж буй бүхий л хууль тогтоомж, хуульчилсан акт шийдвэрүүд нь хүний эрхийг зөрчихгүй нийгмийн харилцааг зохицуулж чадаж байна уу, эсхүл тодорхой түвшинд хүнд суртлыг бий болгон, улмаар эрх зүйн харилцааг зохицуулж байна уу гэдэгт өмгөөлөгч болоод, өмгөөллийн байгууллага шүүмжлэлтэй хандах учиртай гэж үздэг. Өмгөөллийн үйл ажиллагааны хүрээ хязгаар, хүмүүнлэг, ардчилсан нийгэм байгуулж буй манай нийгэмд өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй үед хууль хэрэглээний явцад хүнд суртал юунаас үүсч байгааг судлах түүний шалтгаан нөхцөлийг тодруулах зайлшгүй шаардлага байгаа нь нийгмийн хэрэгцээ болон үйлчлүүлэгчийн хүсэл зориг байна гэж үзэхэд хилсдэхгүй юм.

Өмгөөлөгчийн ажил хэргийн онцлогийг УИХ-ын дарга Д.Дэмбэрэл Монгол улсад өмгөөлөх байгууллага байгуулагдсаны 80 жилийн ойд зориулсан мэндчилгээндээ “Өмгөөлөл нь хууль зөрчигчид төдийгүй аливаа хууль бус үйлдэл, хүчирхийлэл, эрх мэдэлтнүүдийн дураараа авирлах ямарваа нэг дарамтанд өртөгсдийн хувьд хуулийн бодитой өмөг түшиг, найдвар нь байдаг...” гэж дүгнэж мэндчилгээ хүргүүлсэн нь хүнд суртал гаргах аливаа үйлдэлтэй тэмцэж хүний эрхийг тууштай хамгаалах зайлшгүй шаардлага буйг илтгэсэн хэрэг гэж үзнэ.

Хүнд суртал буюу бюрократизм нь судлаачдын үзэж байгаагаар төр үүссэн тэр цаг үеэс үүсэлтэй боловч манай улсын хувьд “Оросоор дамжин нэвтэрч, өнгөрсөн зууны хориод оноос дэлгэрэн 1990 он хүртэл үргэлжилсэн...бүр удамшсан” гэж Доктор Л.Түдэв үзсэн байна. Ер нь хүнд суртал нь хувь хүн төдийгүй хуулийн этгээд зарим тохиолдолд төрийн эрх ашиг, үйл ажиллагаанд ч сөргөөр нөлөөлдөг гэж үзэж болно.

Илтгэгч Өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад байнга тулгардаг төрийн

байгууллага, албантушаалтнууд, шүүх, хуулийн байгууллагуудийн үйлдэл, эс үйлдэхүйгээс улбаатай хүнд суртлыг нуршин өгүүлэхийг зорьсонгүй. Харин түүний шалтгаан нөхцөл, уг сурвалжийг өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хөндөхийг зорьлоо.

Өмгөөллийн үйл ажиллагаа нь хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөх, эсвэл процессийн үйл ажиллагаанд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс зөвхөн хууль хяналтын байгууллагын/шүүх, прокурор, цагдаа-мөрдөн байцаах байгууллага, шийдвэр гүйцэтгэх байгууллага/ хүрээнд хийгдэх ажиллагаагаар хязгаарлагдахгүй, үүнээс ч баялаг агуулгатай юм. Өөрөөр хэлбэл өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хууль тогтоогчоос батласан хууль, гүйцэтгэх засаглалын хүрээн дэх хуулийг хэрэгжүүлэх шийдвэр үйл ажиллагаанд мэргэжлийн түвшинд анализ дүгнэлт өгөх замаар өмгөөллийн үйл ажиллагаа бүрэн төгс хэрэгждэг юм.

Иймээс илтгэлдээ өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад:

-Хууль тогтоох

-Гүйцэтгэх

-Шүүх эрх мэдлийн хүрээнд хүнд суртал, хүний эрх зөрчих үзэгдлийг хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх явцтай холбон авч үзсэн болно.

1. Хууль тогтоох байгууллагаас батлан гаргаж буй хууль нь тодорхой, ойлгомжтой, энгийн байх нь түүнийг хэрэгжүүлэх явцад хүндрэл учруулдаггүй, хүнд суртал гарахыг хязгаарладаг талаар эрдэмтэн судлаачид сургасан байна.

Иргэд, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах явцад хууль тогтоогчоос батлан гаргаж буй хууль нь Монгол Улсын Үндсэн хууль болоод олон улсын гэрээний хэм хэмжээтэй зөрчилдөх явдал нэлээд гарч байна.

Тухайлбал: ЭБШ хуулийн 230-р зүйлийн 1-д зааснаар “дор дурьдсан тохиолдолд хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаахаар шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана”, 315-р зүйлийн 1-ийн 2-т зааснаар “тогтоолыг хүчингүй болгож, хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буюу анхан шатны шүүхээр хэлэлцүүлэхээр буцаах” гэсэн заалтууд нь олон жилийн турш шүүхийн практикт хэрэглэж иржээ. Шүүхийн шатанд хэлэлцэгдэж буй эрүүгийн хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд буцаах гэсэн ойлголт нь МУ-ын Үндсэн хуулийн 14-р зүйлийн 1-д “Монгол улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн 16-р зүйлийн 14-т “...гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. “ гэсэн

зарчим, Эрүүгийн Байцаан Шийтгэх хуулийн 13-р зүйл “гэм буруугүйд тооцох” зарчим, 14-р зүйл “хууль шүүхийн өмнө эрх тэгш байх” зарчим, 15-р зүйл “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах” гэсэн зарчмуудтай зөрчилдсөн хуулийн заалтыг өнөөдрийг хүртэл хэрэглэсээр ирсэн нь хууль өөрөө хүнд суртлыг бий болгож хүний эрхийг зөрчихөд хүргэсэн гэж дүгнэж болох юм. Өөрөөр хэлбэл ЭБШ хуулийн заалтын дагуу шүүх нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын байгууллагын дутуу хийсэн ажлыг гүйцээх, заавар чиглэл өгсний дараа дахин эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж буй нь гэм буруутай эсэх асуудлыг шийдэхээс өмнө ял шийтгэл ноогдуулна гэсэн дотоод итгэлээ бүрдүүлж, улмаар олон сар жил хугацаагаар байцаан шийтгэх ажиллагаа үргэлжилж байгаа нь хүнд суртлыг бий болгож хүний эрхийг зөрчихөд хүргэж байна. Шүүхээр гэм буруугүй нь тогтоогдож цагаадсан иргэд болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хянан шалгагдаад гэм буруу нь тогтоогдолгүй, эрүүгийн хэргийг нь хэрэгсэхгүй болсон тохиолдолд ТӨР-өөс иргэддээ “таны гэм буруу нотлогдоогүй тул уучлаарай” гэж хэлсэн тохиолдол байдаг билүү?

Мөн түүнчлэн Монгол улсын гавьяат хуульч Б.Чимид гуай өөрийн бүтээлдээ “... 2006 онд үндсэн хуулийн цэц СЕХ-ны аливаа шийдвэрийг цэц хянах ёстой гэсэн хөнгөн хийсвэр, омголон дүгнэлт гаргаж, УИХ түүнийг хүлээн зөвшөөрч улмаар /ЗХХШТХ/-иас “Сонгуулийн Ерөнхий Хороо” гэсэн заалтыг хассантай холбоотой”...гоор захиргааны олон зүйл маргааныг захиргааны шүүхийн харьяаллаас гаргасанаар хууль зүйн томоохон гажиг суужээ. “Томоохон гэдэг сүржин үг бус гүйцэтгэх эрх мэдлийн томоохон олон мянган байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд тавих дагнасан шүүхийн хяналтыг дөнгөж төлөвшиж байхад нь үл ойлгон нураасан хэрэг бөгөөд үүний улмаас захиргааны байгууллага албан тушаалтны хууль бус ажиллагаанаас цаана нь иргэд хохирсоор байж болох тул “жигжигхэн ” гэх үндэсгүй билээ”¹ гэж дурьджээ.

Дээрх хоёр жишээнээс нэгтгэн дүгнэвэл хууль тогтоогчдоос гаргаж буй хууль нь шинжлэх ухааны үндэслэл муутай, судалгаа шинжилгээгүй, эрдэмтэн мэргэдийн санал зөвлөмжийг тусгаагүй, эрх зүйн харилцааг зохицуулж буй хуулийн заалт нь хийдэл, зөрчилдөөнтэй, Үндсэн хуулийг зөрчиж байгаа нь өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүнд суртлыг бий болгож улмаар хүний эрхийг зөрчихөд хүргэж байна. 1990-ээд оны үед эрүүгийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалдаг хүрээлэн ажиллаж байсан нь хуулийг хэрэглэх үед гарч байгаа хүндрэл, гажуудлыг судлан, хуульд өөрчлөлт оруулах, хуулийг батлахдаа үндэслэл болгож байсан нь ихээхэн ач холбогдол өгч байсан гэж үзэж байна.

¹ Б.Чимэд. Сонгуульд суралцахуй /тогтолцоо, үйл явц, эрх зүй/. УБ. 2008., 280 дахь тал

2. Гүйцэтгэх эрх мэдэл нь төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, иргэд байгууллагад үйлчлэх үндсэн чиг үүрэг хэрэгжүүлдэг. Гэтэл зарим байгууллага, албан тушаалтан энэ үүргээ умартан иргэд, байгууллага, тэдгээрийн төлөөлөгчид хүнд суртал гаргаж байна. Энэ нь өмгөөлөгчид бидний өмгөөллийн үйл ажиллагаа, цаашлаад хүний эрхийн хэрэгжилтэд шууд сөргөөр нөлөөлдөг. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтнуудын хүнд суртал нь өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэхгүй байх, хариу өгөхгүй байх, ажлын байрандаа байхгүй байх, иргэдийг даргалан харьцдаг, нээлттэй байх ёстой мэдээллийг нийтэд хүргэхгүй байх зэрэг хэлбэрээр илэрч байна.

Энэ нь гүйцэтгэх эрх мэдлийн албан тушаалтнууд өөрсдийгөө ард иргэдэд үйлчлэх чиг үүрэгтэй болохоо ухамсарлаагүйтэй холбоотой болно.

Төрийн байгууллагууд дотоод журмаараа иргэд, байгууллагын өргөдөл, гомдол, саналыг хүлээн авах, үйлчлэх ажлын өдөр, цагийг богиносгон тогтоодог зохисгүй хандлага байна.

Түүнчлэн, төрийн байгууллагууд дотоод дүрэм, журмаа Монгол Улсын үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн боловсруулах ажил тун дутмаг байгаа, энэ нь хүнд сурталд автсаны илэрхийлэл болсон тухай судалгаа гарчээ².

Мөн төрийн байгууллагууд иргэдийн хэрэгцээт мэдээллийг вэб сайтандаа тавьж, тавьсан мэдээллээ байнга шинэчлэхгүй байгаа нь иргэд, хуулийн этгээдийг төрийн байгууллагын үйл ажилгаатай танилцах, улмаар хүсэлт, өргөдөл, гомдол гаргахад хүндрэл учруулаад зогсохгүй аливаа мэдээлэл авах тухай бүр албан тушаалтны хаалга сахих үр дагаврыг бий болгож байна.

Төрийн үйл ажилгаанд Электрон засаглалыг хөгжүүлж ил тод байдлыг нэвтрүүлэх, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг түргэн шуурхай болгох, улмаар хүнд суртлыг багасгах зүйтэй санаачлага³ гарч байгаа боловч дорвитой ажил хэрэг болж чадахгүй байна.

Цагдаагийн байгууллагын зарим албан хаагчдын үйл ажиллагаа нь өмгөөлөгчийн ажил хэрэгт хүнд суртал, хүндрэл учруулдаг бөгөөд энэ нь үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг шууд хөнддөг.

² Авилгатай тэмцэх газар, Нээлттэй нийгэм форум, "Глоб интернэшнл" ТББ. Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдал /мониторингийн тайлан/. УБ.2008., 55 дахь тал.

³ Ц.Мөнх-Оргил: Мэдээллийн технологийн салбарт эрх зүйн зохицуулалт үгүйсгэгдэж байна. <http://www.forum.mn/>

Тодруулбал: Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас эрүүгийн хэргийг шалгах явцдаа ЭБШ хуульд заасны дагуу цагаатгах болон яллах талын нотлох баримтыг тэгш байдлаар цуглуулах үүрэгтэй байтал зөвхөн яллах талын нотлох баримтыг давамгайлан цуглуулснаас шүүхийн шатанд яллах талыг баримтлан мөрдөн байцаалт явуулсан гэдэг гомдлыг өмгөөлөгч нараас байнга гаргадаг нь мөрдөн байцаагч, түүнд хяналт тавьж байгаа прокурорын үйл ажиллагаатай шууд холбоотой.

Гэм буруугийн асуудлыг зөвхөн шүүх шийдвэрлэх ёстой атал мөрдөн байцаалтын явцад мөрдөн байцаагч нь Сэжигтэн, яллагдагчид гэм буруутай нь нотлогдсон мэтээр хандаж мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа явдал нь өмгөөлөгч, мөрдөн байцаагчийн хооронд зохисгүй харилцаа үүсэх үндэс болж байна.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн ажлын зохион байгуулалт, ажил хэргийн соёлоос шалтгаалан гэрчүүдийг удаан хугацаагаар хүлээлгэх, чирэгдүүлэх, цаашилбал сүрдүүлэх, хуулийн хугацаанд эрүүгийн хэргийг шалгалгүй удаах зэрэг үйлдлүүд нь өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэл учруулдаг юм.

3. Шүүх нь хүний эрхийг хамгаалах гол баталгаа, хүнд сурталгүй байгууллага байх учиртай. Энэ талаар Доктор Ж.Бямбаа шүүх нь "...үл бүтэх этгээдүүдийн очдог газар биш, үнэн шударгыг эрхэмлэн хүндэтгэдэг хүн бүхний өөрөө хүсэж ирдэг ариун үнэний хүрээлэн, ардчилсан эрх зүйт төрийн нэгэн гол цөм гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Тиймээс ч тэр шинжээрээ хууль, ардчилал, шударга ёс, хүний эрхийн найдвартай хамгаалалт-өмөг түшиг нь шүүх болох учиртай гэж хэлэх бүрэн үндэслэл бий"⁴ хэмээн тэмдэглэсэн байна.

Гэтэл бид бодит байдал дээр шүүн таслах ажиллагааны явцад хүнд суртал гарч, хүний эрх зөрчигдөж байгаа талаар ярьсаар байна. Аливаа эрүү, иргэний маргааныг хянан шийдвэрлэхдээ хуульд заасан хугацаанд шийдвэрлэдэггүй шүүхийн байгууллагын ажилтан албан хаагчдаас иргэдтэй ёс зүйгүй харьцдаг, удаан хугацаагаар хүлээлгэн чирэгдүүлдэг, хэрэг маргааныг буруу шийдвэрлэснээс шүүхийн олон шатыг дамжин цаг хугацаа алддаг зэрэг олон шалтгааныг бид ярьдаг боловч өнөөдрийг хүртэл иргэд байгууллагын зүгээс гарч байгаа гомдол тасрахгүй байгаагийн шалтгаан нөхцөлийг тодруулахыг хичээлээ. Үүний нэг нь шүүхийн ажлын ачаалал мөн.

1992 онд шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш захиргааны дагнасан шүүх байгуулагдаж шүүхийн орон тоо нэмэгдсэн боловч шүүхийн ачаалал буурахгүй, харин өсөн нэмэгдэж байна.

⁴ Ж.Бямбаа. Мөрдөн мөшгих, шүүн таслах ажиллагаан дахь өмгөөллийн зарим асуудал. Өмгөөлөгч сэтгүүл. 2008 оны №04 /20/

УДШ-ийн 2008 оны эхний 9 сарын шүүн таслах ажлын нэгдсэн дүнгээс авч үзвэл анхан шатны шүүхийн нэг шүүгчид дунджаар 113 хэрэг ногдож байна /илтгэлийн хавсралт 1-ээс үзнэ үү/. Тус судалгаанаас авч үзвэл нэг шүүгчид ногдох хэргийн ачаалал өндөр байгаа нь шүүх маргааныг хуулиар тогтоосон хугацаанд шийдвэрлэх боломжгүй болох нөхцөл байдлыг үүсгэх бөгөөд үүнээс болж иргэд, хуулийн этгээдээс чирэгдүүлсэн, хүнд суртал гаргасан гэсэн гомдол тасрахгүй байх бөгөөд энэ нөхцөл байдал нь өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүндрэл учруулах бодитой хүчин зүйл болох нь ойлгомжтой.

Нэг шүүгч тухайн жилдээ хэд хоног ажиллаж байна вэ гэдгийг судлан үзлээ. Жилийн 365 хоног, үүнээс долоо хоног бүрийн амралтын өдрүүд буюу 96 хоног, баяр ёслолын амралтын өдрүүд буюу 10 хоног, ээлжийн амралт хугацаа 24-60 хоног байдаг зэргийг тооцон үзвэл тухайн шүүгч өвчилж, чөлөө авалгүйгээр жилдээ ойролцоогоор 194 хоног ажиллах бөгөөд, нэг шүүгч өдөрт нэг хэргийг шийдвэрлэхээр байна гэсэн судалгаа гарч байна.

Ийм ажлын зохион байгуулалт, ачаалал байгаа нөхцөлд иргэдийг гомдол тасрахгүй, хүнд суртал гаргаж байна гэж үзэхээс ч аргагүй нөхцөл байдлыг бий болгож байна.

Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хүний эрхийг хязгаарлаж байгаа аливаа тохиолдолд шүүх засаглал үйлчилж байна гэж үзэж болно. Харин зах зээлийн өнөөгийн нийгэмд иргэд байгууллагын зөрчигдсөн эрхийг сэргээж байгаа шүүхийн ажиллагаа нь шүүх засаглал гэхээс илүү маргаан гаргаж буй этгээдүүдийн маргааныг шийдвэрлэх, үйлчилгээний шинж чанарыг агуулж байна гэж үзэж болно. Тухайлбал зөрчигдсөн эрхээ сэргээлгэхийн тулд иргэн хуулийн этгээдээс шүүхэд нэхэмжлэл гаргахын өмнө Улсын тэмдэгтийн хураамж төлж байгаа нь зөрчигдсөн эрхээ шүүхээр сэргээлгэхийн тулд төлбөр төлж байгаа үйлдэл мөн. Энэ үүднээс нь авч үзвэл иргэд байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна гэсэн сэтгэхүй шүүгч болон шүүхийн байгууллагын ажилтнуудад огт байхгүй байна гэж хэлж болно. Уг үүргээ ухамсарлаагүйн улмаас ялангуяа захиргаа, иргэний маргаанд шүүх засаглалыг хэрэгжүүлж байгаа мэтээр хандах хандлага давамгайлж байгаа нь шүүхийн ажиллагаанд илтэд мэдрэгддэг юм.

Зах зээлийн нийгэмд эрх зүйн харилцаа улам боловсронгуй болж олон хууль шинээр батлагдан гарч, мөн нэмэлт өөрчлөлт орж байгаа нь зүй ёсны юм. Энэхүү олон тоогоор батлагдан гарч байгаа хуулийг хэрэглэх нэгдсэн ойлголт аргачлал буюу хууль хэрэглээний явцад тогтвортой нэгдсэн нэг ойлголтыг бий болгохгүй байгаа нь хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцад илэрч, удаан хугацаагаар үргэлжлэн, олон шатны

шүүхээр дамжин, улмаар маргаанаа шийдвэрлүүлж буй хувь хүн болон хуулийн этгээдэд шүүх хүнд суртал гаргаж байна гэсэн ойлголтыг өөрийн эрхгүй төрүүлдэг. Тухайлбал: ХЗҮТ-өөс явуулсан судалгаагаар Татварын хуульд 80 удаа нэмэлт, өөрчлөлт орсон дүн гарч байгаа нь үүнийг нотолж буй нэг жишээ юм. Ийм учраас МУ-ын Дээд Шүүх Үндсэн хуулиар олгосон эрхийнхээ дагуу шинээр батлагдан мөрдөгдөж буй хуулийг цаг хугацаа алдалгүйгээр тайлбарлах, үүнийгээ мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд шуурхай хүргэснээр эрх зүйн харилцааг зохицуулж байгаа хуулийг хэрэглэхээс өмнө тодорхой ойлгоцыг бий болгох бөгөөд энэ нь, өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Мөн өмгөөлөгч бид өөрсдийн үйл ажиллагаандаа хүнд суртал байгаа эсэх талаар судлан үзэх ёстой. УДШ-ээс явуулсан судалгааны дүнг үндэслэл болговол⁵ 2006, 2007 онуудад 240 гаруй шүүх хуралдаан буюу нийт шүүх хуралдааны 10,43 хувьд өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бөгөөд үүний улмаас шүүх хуралдаан хойшилсон байна. Үүнд бид шүүмжлэлтэй хандаж, өмгөөлөгч нарын ажлын хариуцлагыг улам сайжруулах нь зайлшгүй шаардлагатай болохыг ухамсарлан ойлгож байна.

Мөн дурьдах ёстой нэг зүйл бол Монгол Улсын Өмгөөллийн тухай хууль, бусад хуульд Өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх баталгааг хуульчилсан боловч өмгөөлөгчийн хууль ёсны үйл ажиллагаанд саад учруулсны төлөө хүлээлгэх хариуцлагыг хуульчлаагүй орхигдуулсан явдал юм.

Өмгөөлөгчийн бүрэн эрхийг хуулиар хэрхэн бататган бэхжүүлж, энэ бүрэн эрхийг хэрэгжүүлэх баталгааг хэрхэн зохицуулснаас өмгөөлүүлж байгаа хувь хүн болон хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээхэд шууд хамааралтай нөхцөл байдал бий болно. Мөн өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад гарч болох хүнд суртал болон хууль бус үйлдлийг таслан зогсооход ихээхэн ач холбогдолтой болох юм. Сүүлийн үед өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад тухайн өмгөөлөгчийг өмгөөллийн ажиллагаатай нь холбогдуулан янз бүрийн хэлбэрээр дарамтлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гүтгэх, эрх чөлөөнд нь халдах, шүүхээр нотлогдоогүй хэрэг маргааны талаар нийтэд мэдээлэл хийж буруу ойлголт, төсөөлөл бий болгож байгаа нь өмгөөллийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж буй хэлбэрүүд мөн.

Аливаа эрх зүйн харилцаанд хувь хүн, хуулийн этгээд оролцохдоо тэрхүү харилцаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг судлахаасаа илүү энэ талаар мэргэшсэн

⁵2008 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн УДШ-ээс зохион байгуулсан “Өмгөөлөгчийн ёс зүй ба хариуцлага” сэдэвт уулзалт ярилцлагын материал.

хуульч буюу өмгөөлөгчөөс эрх зүйн туслалцаа авч ажиллах нь цаг хугацаа хэмнэх, үр дүнтэй гэж үзэх болжээ. Энэ чанараараа өмгөөллийн үйл ажиллагаа бол нийгмийн шударга ёс, хүний эрхийн баталгаа болохоос гадна хүнд суртлыг хязгаарлах хөшүүрэг гэж үзэх үндэслэлтэй юм.

Энэхүү илтгэлийг бичихэд өөрийн санаа бодлоо илэрхийлж, зөвлөж байсан өмгөөлөгч нар болон судалгааны материал өгсөн байгууллагуудад баярласнаа илэрхийлэе.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

**УДШ-ийн Судалгааны төвөөс авсан
/2008 оны 9-р сарын/ нэгдсэн дүн**

/Улсын Дээд Шүүх-17 шүүгч/

Д/д		Шийдвэрлэсэн хэрэг
1.	Эрүүгийн хэргийн танхим	345
2.	Иргэний хэргийн танхим	442
3.	Захиргааны хэргийн танхим	124
4.	Захиргааны давж заалдах шат	239
5.	Нийт	1150

Жич: судалгаанаас үзвэл УДШ-ийн нэг шүүгчид дунджаар иргэний хэрэг **88**, эрүүгийн хэрэг **69**, захиргааны **60** хэрэг ногдож байна.

/давж заалдах шат-101 шүүгч/

д/д	Хэргийн төрөл	Шийдвэрлэсэн хэрэг
1.	Эрүүгийн хэрэг	1537
2.	Иргэний хэрэг	1102
3.	Нийт	2639

Нэг шүүгчид дундажаар 26 хэрэг ногдож байна.

Анхан шатны шүүх 254 шүүгч

Захиргааны анхан шат 56 шүүгч

Нийт 310 шүүгч

Шийдвэрлэсэн хэрэг- 35246

Нэг шүүгчид дундажаар-113 хэрэг ногдож байна.



Д.СОЛОНГО

МУИС-ийн ХЗС-ийн Төр, захиргааны эрх зүйн
тэнхимийн эрхлэгч, хууль зүйн ухааны
доктор, профессор

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХҮНД СУРТАЛ

Төрийн захиргааны байгууллага дахь хүнд суртал, түүнийг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг нээн илрүүлэх, хүнд суртлын улмаас иргэдийн эрх, эрх чөлөө хэрхэн зөрчигдөж байгааг судлан тогтоох шаардлагатай хэмээн үзэж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хүний Эрхийн Үндэсний Комиссоос тухайн сэдвээр судалгаа хийлгэхээр бидний хэдэн тухайлбал, доктор Г.Банзрагч, П.Одгэрэл, Д.Солонго, Ш.Цогт нарын судлаачид итгэл хүлээлгэсэн билээ.

Тиймээс сонгон авсан төрийн захиргааны байгууллагуудын хүрээнд хэрэгжиж буй хууль тогтоомжийн өнөөгийн байдал, тэдгээрийг хэрэгжүүлэх явцад учирч буй бэрхшээл, иргэдэд үйлчлэх үйл ажиллагаан дахь хүнд суртлыг тогтоох, улмаар олон нийтийн зүгээс шаардаж буй захиргааны шийдвэрийн ил тод байдлыг хангах, мэдээллийг жигд хүртээмжтэй, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай болгох үүднээс дээрх асуудлуудыг судлан тодорхойлох нь уг судалгааны ажлын үндэслэл, шаардлага болсон юм.

Бид захиалагчийн зүгээс санал болгосон дөрвөн салбарын хүрээнд хүнд суртлын талаар иргэдийн санаа бодлыг судалж, хүнд суртлын улмаас хүний эрх хэрхэн зөрчигдөж байгаад дүн шинжилгээ хийж, хүнд суртлыг багасгах, арилгах, шат дамжлагыг цөөрүүлэх талаар дүгнэлт гарган, зөвлөмжийн төсөл боловсруулах зорилго дэвшүүлэн ажиллалаа. Иймээс дээрх зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлж ажиллах оролдлого хийсэн. Үүнд:

Сонгон авсан төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаандаа удирдлага болгодог хууль, бусад эрх зүйн актууд болон дотоодод нь үйлчилдэг дүрэм, журам, үйл ажиллагаанд нь дүн шинжилгээ хийх;

-Сонгон авсан төрийн захиргааны байгууллагуудад хүнд суртлыг бий болгож буй бодит хүчин зүйлүүдийг судлан тогтоох;

-Сонгон авсан төрийн захиргааны байгууллагууд дахь хүнд суртлын талаар иргэдийн төсөөллийн судалгаа явуулж, дүн шинжилгээ хийх;

-Хүнд суртлын улмаас иргэдийн эрх, эрх чөлөө хэрхэн зөрчигдөж байгаад дүн шинжилгээ хийх;

-Сонгон авсан төрийн захиргааны байгууллагууд дахь хүнд суртлыг багасгах, тухайн байгууллагын үйлчилгээг ил тод, шуурхай болгох талаар санал, зөвлөмж боловсруулах зэрэг болно.

Авилгал, хүнд суртлын асуудлыг хөндсөн судалгаа шинжилгээг ерөнхийдөө хоёр үндсэн чиглэлээр хийдэг юм байна. Эхнийх нь санал асуулгад тулгуурлан авилгал, хүнд суртлын талаар олон нийтийн ойлголт төсөөлөл, хандлагыг судалдаг бол хоёр дахь чиглэл нь чанарын аргуудыг хэрэглэж асуудлын мөн чанарын талаар гүн гүнзгий мэдээлэл олж авдгаараа тус тус онцлогтой. Бид тухайн асуудлыг тоон болон чанарын судалгааны аргуудыг хавсруулан судаллаа.

Түүврийн хувьд зорилтот болон санамсаргүй түүврийн аргыг хослуулсан. Чанарын судалгаанд зорилтот түүврийн техникийг, харин олон нийтийн санал асуулгыг явуулахдаа энгийн санамсаргүй түүврийн техникийг ашигласан. Ингэхдээ бүс нутаг, хүйс, нас, боловсролын ялгаа бүхий бүлгүүдийн төлөөллийг хангахад анхаарч гурван шаттай түүвэрлэлтийн техникийг хэрэглэв.

Судалгааны түүврийн нэгж нь хувь хүн бөгөөд өрхөөр дамжуулан хувь хүнээ сонгож судалгаа хийлээ.

Түүвэрлэлтийн эхний шатанд судалгааг манай улсын эдийн засгийн 5 бүсийг төлөөлсөн 5 аймаг болон Улаанбаатар хотыг хамруулан бүсийн түүвэрлэлт хийсэн. Түүвэрлэлтийн 2 дахь шатанд судалгаанд хамрагдах захиргааны байгууллагуудын жагсаалтанд үндэслэн судалгаанд оруулах аймаг нийслэл, сум дүүргийг сонгосон. Түүвэрлэлтийн гурав дахь шатанд өрхөд суурилсан түүвэрлэлтийг хийсэн. Түүвэрлэлтэнд хамрагдах хүмүүсийг санамсаргүйгээр сонгох нь судалгаанд хамрагдах боломж хүн бүрт ижил гэдгийг харуулахын зэрэгцээгээр үр дүнд нөлөөлөх алдааг хянах боломж олгодог гэсэн үндэслэлийг баримталсан болно.

Судалгаанд сонгогдсон бүс нутагт чанарын судалгааны ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын аргуудыг хэрэглэсэн бөгөөд нийт 60 хүнийг хамруулсан.

Ганцаарчилсан ярилцлагаар 50 хүнээс урьдчилан бэлтгэсэн ярилцлагын удирдамжаар мэдээлэл авсан. Учир нь энэ бол төрийн албан хаагчдыг нэг дор цуглуулах боломжгүй үед хэрэглэхэд тохиромжтой арга юм билээ. Бид 2 удаагийн бүлгийн ярилцлагыг зохион байгуулсан бөгөөд нэг удаагийн бүлгийн ярилцлага 5 хүний бүрэлдэхүүнтэй байв.

Түүнчлэн судалгааны ажлын зорилго, судалгааны ач холбогдолтой уялдуулан баримтын шинжилгээний, тоон болон чанарын судалгааны аргуудыг хавсран хэрэглэсэн. Баримтын шинжилгээрээр сонгон авсан төрийн захиргааны байгууллагуудын хувьд үйлчилж буй хууль, хуулийн дэд акт болон тэдгээрийн дотоодод үйлчилж буй дүрэм, журмууд нь хүнд суртлыг бий болгох шалтгаан болж буй эсэхэд эрх зүйн дүн шинжилгээ хийсэн.

Тоон судалгаагаар /асуулгаар/ хүнд суртлын талаархи иргэд, төрийн албан хаагчдын хандлагыг тогтоох, хүнд суртлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг илрүүлэхийг зорьсон.

Чанарын судалгааны аргаар /бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагаар/ хүнд суртлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг илрүүлэх, түүнийг багасгах арга замыг эрэлхийлэх зорилгоор төрийн захиргааны албан хаагчдын санаа бодлыг судалсан.

Судалгаанд баримтын шинжилгээ, тоон болон чанарын судалгааны аргуудыг хэрэглэсэн нь мэдээллийн чанарыг улам баталгаажуулах ач холбогдолтой болсныг онцлон тэмдэглэж байна.

Судалгааны түүврийн дагуу нийт 1200 өрхөд асуулгыг тараасан боловч түүнээс 100 орчим нь асуулгыг бүрэн бус бөглөсөн, логикийн зөрчилтэйн улмаас хүчингүйд тооцогдсон. Иймд нийт 1107 иргэний асуулга судалгаанд хамрагдаж буй юм.

Судалгааны үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдагчдын 56 хувийг 18-34 насны залуучууд эзэлж байгаа нь манай улсын насны бүтцийн тархалттай ойролцоо байгааг харуулж байна. Боловсролын хувьд авч үзвэл 41 хувь нь дээд, 33.9 хувь нь бүрэн дунд боловсролтой байлаа.

Нийт судалгаанд оролцогчдын 60.8 хувийг хөдөө, үлдсэн хувь нь хотын оршин суугч хүн амыг төлөөлж байгаа нь түүврийн үндэслэл бүхий, найдвартай байдлыг илтгэн харуулж байна.

Бидний судалгааны гол объект болох “Хүнд суртал” хэмээх үзэгдлийн талаархи олон нийтийн ойлголт төсөөллийг тандаж тогтоох зорилгоор “Хүнд суртал гэж юуг хэлэх вэ” гэсэн асуултыг нээлттэй тавьсан бөгөөд судалгаанд хамрагдсан хүн амын 10 хувь нь төрийн албан хаагч дур зоргоороо аашлах, 7.7 хувь нь албан тушаалаа урвуулан ашиглаж бусдаас мөнгө төгрөг авах, 7.2 хувь нь ёс суртахуунгүй зан авир гаргах, 6.1 хувь нь аливаа асуудлыг олон шат дамжлагатайгаар шийдэх, чирэгдүүлэх явдлыг хүнд суртал хэмээн тайлбарласан нь нийт хариултуудын дотор өндөр хувийн жинг эзэлж байна. Ерөнхийдөө тухайн төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагч ажлын байр, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглаж дур зоргоороо авирлаж байгаа аливаа үйлдлүүд, асуудлыг олон үе шатаар дамжуулан иргэдийг чирэгдүүлэх үйлдлийг хүнд суртал хэмээн үзэж байгаа нь судалгаанаас илт харагдаж байлаа. Үүнээс гадна нийт судалгаанд хамрагдсан хоёр хүн тутмын нэг нь хүнд сурталыг тодорхойлж хэлэхэд хүндрэлтэй байна гэж үзсэн нь бидний анхаарлыг татсан бөгөөд, эдгээрийн дотор боловсролын түвшин доогуур, эсвэл залуучуудын эзлэх хувийн жин өндөр байгаа нь харагдаж байлаа.

Өнөөдөр таны сэтгэлийг ямар асуудал хамгийн их зовоож байна вэ? гэсэн асуултанд ажилгүйдэл (67.6%), ядуурал (59.6%), хүнд суртал (48.8%), хуулийн хэрэгжилт (43.7%) гэж хариулснаас үзвэл хүнд суртал нь нийгмийн сэтгэл зовоосон асуудлын нэг болох нь харагдаж байна.

Гэхдээ сонгосон төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг судлах явцад дэвшилттэй, эерэг буюу хүнд сурталыг бууруулах талаар тодорхой ажил хийгдэж байгааг тэмдэглэх нь зүйтэй юм. Тухайлбал, Гаалийн байгууллагад олон эерэг сайн зүйлүүд жишээлбэл, терминалийн дотоод зохион байгуулалт, рентген болон ачиж буулгах тоног төхөөрөмж, компьютер, мэдээллийн сүлжээний ахиц дэвшил байгааг, Дорноговь аймгийн захиргаа, Замын-Үүд сумын захиргааны иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шуурхай барагдуулах талаар зохион байгуулж хэрэгжүүлж буй арга хэмжээ, Нийслэлийн Иргэний бүртгэлийн албанаас бүртгэлийн төрөл тус бүрээр шаардлагатай мэдээлэл бэлтгэж иргэдэд хүртээмжтэй олшруулан үйлчилж байгаа зэргийг сайшаан онцолж байна. Өнөөдрийн энэ арга хэмжээ аль нэг байгууллагын баярын хурал биш учраас бид илтгэлдээ голлон оршиж буй хүндрэл, дутагдал, тэдгээрийг арилгах, сайжруулах талаар голлон хөндсөн болно.

Хүнд суртал гэдэг нь “бюрократизм” гэдэг үгний оновчтой бус орчуулга юм. Энэ нь францаар “бюро” /bureau/ буюу “бичгийн ширээ” “крати” /-cratie/ хэмээх төгсгөлөөс бүрдэх /грекийн kratos буюу засаглал, эрх мэдэл гэсэн үгнээс үүдэлтэй/ “захиргааны засаглал” гэсэн утгатай үг. Социологч Макс Вебер “брюкрати”-г хууль ёсны засаглалын рациональ хэлбэр хэмээн эерэг байдлаар тодорхойлсон байдаг. Учир нь бусад хэмжээгүй эрхт

засаглалыг бодвол түшмэдийн засаглалын үед хуулийг баримтлах ёстой тул хэн нэгнийг дээгүүрт эсхүл доогуурт үзэх зэргээр дураар авирлах явдлыг зогсоох боломжтой гэж тэрээр үзсэн байна. Монголчууд бидний хувьд хүнд суртал гэдгийг төрийн захиргааны байгууллагын чирэгдэлтэй, хүний эрх, эрх чөлөөг хангахад саад тотгор болдог тогтолцоо хэмээн үзэх үзэл ойлголт тогтсон байдаг. Бидний хэдэн судлаач ч асуудалд энэ талаас нь хандаж, түүнийг байх ёстой зүйл гэхээсээ илүү гаж тогтолцоо, түүнтэй тэмцэх учиртай гэсэн байр сууринаас хандаж энэхүү судалгааг хийсэн болно.

“Захиргааны засаглал” нь өөрөө хүнд суртлыг бий болгох үндэс нь болдог. Учир нь захиргаа бол шатлан захирах ёсонд үндэслэдэг, олон тооны дүрэм, журмыг тогтоож мөрддөг зэрэг нь эргээд их хэмжээний зардал, ил тод бус байдал, олон шат дамжлагыг бий болгож түүний улмаас иргэдийн эрх зөрчигдөхөд хүргэдэг. Нэг үгээр хэлбэл хүнд сурталтанг хүнд сурталт тогтолцоо төрүүлдэг гэж болно.

Харин хүнд суртлын үндсэн шинж, түүнийг үүсгэж буй шалтгааныг тогтоохын тулд энэ талаархи нийтлэг ойлголтыг судалгааны үр дүнтэй харьцуулж үзсэн.

Хүнд суртлын илрэх шинж

Илрэх шинж	Нийтлэг ойлголт	Судалгааны дүн
Өргөдөл гомдлыг дарагдуулах	+	+
Дороос гарсан санал, гомдол, шүүмжлэлийг дарагдуулах	+	
Олон шат дамжлага буй болгож тэдгээрт алба хашиж буй түшмэдүүд нь идэвхгүй дамжуулагчийн үүрэг гүйцэтгэх	+	+
Голдуу хориглох хандлагатай олон тооны дүрэм, заавар, журам, тогтоол гаргах	+	+
Дүрэм журамд заагаагүй л бол ямар ч дэвшилттэй асуудал, санал санаачлагыг үл дэмжих	+	
Олон дарга бий болох	+	+
Албан хаагчид нь шүүмжлэлийн үр дагавараас болгоомжлох	+	
Иргэдийг чирэгдүүлэх, үйл ажиллагаа нь удаан, үр нөлөө муутай	+	+
Төрийн албан хаагчид ёс зүйгээ алдах /албан тушаалаа ашиглах, хээл хахууль авах, иргэдийг ялгаварлан гадуурхах гм/		+
Төрийн албан хаагчдад мэргэжлийн ур чадвар дутагдах		+
Төрийн албан хаагчдыг шалгаруулалт дутагдалтай		+
Төрийн албан хаагчид дур зоргоороо аашлах		+

(хүнд суртлын талаарх нийтлэг ойлголтонд түүний 11 үндсэн шинжийг тогтоосон байдаг ба бидний судалгааны үр дүнд иргэд эдгээрийн 9-ийг илэрдэг гэж үзсэн байна)

Захиргааны байгууллага дахь хүнд суртлын илрэх шинжүүдэд тулгуурлан түүнийг үүсгэж буй шалтгааныг тодорхойлох бололцоотой байна. Хүнд суртал нь субъектив, объектив шалтгаанаас болж гарч байна.

-субъектив шалтгаан нь захиргааны байгууллагад ажиллаж буй албан хаагчийн ёс зүй, мэргэжлийн ур чадвар зэрэг хувийн шинжээс үүдэлтэй бол;

-объектив шалтгаан нь уялдаа холбоо муутай, хэт олон хууль, дүрэм журам, захиргааны байгууллагын оновчгүй зохион байгуулалт, чиг үүргийн хуваарилалт буюу тогтолцоо, захиргааны байгууллагад ажиллагсдыг сонгон шалгаруулах, урамшуулах, хариуцлага тооцох механизмын дутагдал, ажлын байрны баталгаагүй байдал гэх мэтийн улмаас үүсэж байна.

Нэгүгээр хэлбэл “Хүнд суртал” нь төр–иргэний хоорондын харилцааны явцад бий болох бөгөөд иргэдээс төрийн байгууллагын үйл ажиллагаанд өгч буй сөрөг үнэлэлт хэмээн ойлгож болох юм. Манай улсад хүнд суртал ямар хэмжээнд байна вэ? гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан хүмүүсийн 48 хувь нь дээд цэгтээ хүрсэн гэж үзсэн байна. Иймээс бид хүнд суртал нь нийгмийн өмнө тулгарч буй шийдвэрлэвэл зохих асуудлын нэг болжээ гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Бидний судалгааны дүнгээс харахад иргэдийн үзэж байгаагаар хамгийн их хүнд сурталтай төрийн байгууллагын тоонд газрын асуудал эрхэлсэн байгууллага, иргэний бүртгэлийн байгууллагууд орж байна. Энэ үзүүлэлт ч бусад энэ чиглэлээр хийсэн судалгааны үр дүнгүүдтэй ерөнхийдөө дүйж байгаа билээ.

Захиргаа төрийг төлөөлж иргэнтэй харилцаанд ордог тул, тодруулбал иргэнд чиглэгдсэн хуулийг тодорхой тохиолдолд захиргаанаас буюу гүйцэтгэх засаглалын байгууллагаас хэм хэмжээний болон захиргааны акт гаргах хэлбэрээр хэрэгжүүлдэг учир хүнд суртлын тухай ойлголт ихэнхдээ захиргааны байгууллагатай холбогддог. Объектив утгаараа захиргаа нь хуулийг хэрэгжүүлэхийн тулд хууль болон захирамжилсан актын үндсэн дээр иргэдэд үйлчлэх үндсэн үүрэг бүхий “ажлын байр” гэж тодорхойлж болно.


Иймд хүнд суртлыг үүсгэгч нь захиргаа өөрөө бөгөөд түүний шалтгааныг “хүн–төрийн албан хаагч” ба “ажлын байр” болон эдгээрийн харилцан хамаарал бүхий тогтолцооноос хайх учиртай.

Юуны өмнө “хүнд суртал”-ын анхдагч эх сурвалж нь тухайн захиргаа хэмээх ажлын

байранд төрийн алба хашиж буй “төрийн албан хаагч”-ийн хувийн байдал гэж үзэж болох юм. Үүнд төрийн албан хаагчийн төрд алба хаших хүсэл сонирхол, мэргэжлийн ур чадвар, цаашдын итгэл үнэмшил голлох үүрэгтэй.

Төрд алба хаших боловсон хүчнийг зөв сонгох нь тухайн төрийн тогтолцооноос илүү чухал хэмээн ойлгож байна. Төрийн албаны хэчнээн сайн тогтолцоо байгаад тэнд ажиллаж буй төрийн албан хаагчид нь чин сэтгэлээсээ иргэдтэй харьцахгүй юм бол нөгөө л хүнд суртал хэмээх нийгмийн сөрөг үзэгдэл байсаар байх болно. Харин идэвхи санаачлагатай, мэргэжлийн өндөр ур чадвартай, ажилдаа сэтгэл гарган ажилладаг төрийн албан хаагч нь тухайн тогтолцооныхоо дутагдлыг боломжийн хэрээр нөхөж, хүнд суртлыг аль болохоор багасгахын төлөө байдаг.

Хүнд суртлыг үүсгэх субъектив шалтгаанд:



Төрийн албан хаагчийн идэвхи санаачлагагүй байдал: Төрийн албан хаагч нь тухайн хашиж буй албандаа тогтвор суурьшилтай ажиллах, амьдралд хүрэлцээтэй цалин хангамж авах, ахиж дэвших итгэл үнэмшил байхгүйгээс бүх хүч бололцоогоо дайчлах хүсэлгүй болж хариуцсан ажилдаа хайнга хандсанаар дараах хүнд суртлыг бий болгоно. Үүнд:

- олон шат дамжлага буй болгож тэдгээрт алба хааж буй түшмэдүүд нь идэвхгүй дамжуулагчийн үүрэг гүйцэтгэх,
- иргэдийн өргөдөл, гомдлыг дарагдуулах, чирэгдүүлэх
- дэвшилтэт, шинэлэг санал, санаачлагыг үл нэвтрүүлэх
- ажлын үр нөлөөг бууруулах гм.

Төрийн албан хаагчийн мэргэжлийн ур чадваргүй байдал: Төрийн албанд ажиллах боловсон хүчний сонгон шалгаруулалтанд танил тал, хамаатан садны холбоог харах, мөнгөөр үнэлэх, улс төрийн намын харьяаллыг харгалзах, мөн мэргэжлийн давтан сургалт тогтмол зохион байгуулахгүйгээс төрийн албан хаагчийн мэргэжлийн ур чадвар

илт дутагдаж байна. Үүний улмаас дараах хүнд суртлыг бий болгоно. Үүнд:

- төрийн ажлын үр нөлөөг бууруулах,
- ажлаа мэдэхгүйгээс иргэдийг чирэгдүүлэх, бухимдуулах,
- иргэдийн эрхийг зөрчих г.м.

Төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхлыг илүүд үзэх байдал: Тухайн албан тушаалд тогтвортой ажиллах бололцоогүйгээс /бодит байдал дээр сонгуулийн 4 жилээр хэмжигдэж байгаа тул/ олдсон богинохон хугацаанд эрх мэдлээ ашиглан хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилготой байна. Үүнээс үүсэж буй хүнд суртлын хэлбэрүүдэд:

төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлүүд /дур зоргоороо авирлах, хууль ёсны зарчмыг умартах, авилгалд автах г.м./,


иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдөх,

төр /захиргаа/ иргэдийн хооронд үл итгэлцэл бий болох, нийгэмд захиргааны үйл ажиллагааны талаарх сөрөг үнэлэмж бий болох гэх мэтийг хамааруулан ойлгож байна.

Төрийн алба нь нийтийн ашиг сонирхолд чиглэгдсэн хуулийг хэрэгжүүлэхийн тулд хууль болон захирамжилсан актын үндсэн дээр иргэдэд үйлчлэх үндсэн үүрэг бүхий “ажлын байр” юм. Иймд тухайн ажлын байрны тодорхойлолт, баталгаа, дотоод зохион байгуулалтыг боловсронгуй, үр дүнтэй болгох чиглэлээр эрх зүйн актаар нарийвчлан зааж өгөх нь хүнд суртлыг бууруулахад чухал ач холбогдолтой.

Төрийн албаны эрх зүйн зохицуулалт болон зохион байгуулалт муу байгаа нь хүнд суртал үүсэх нэг үндсэн гол шалтгаан болж байна.

Хүнд суртлыг үүсгэх объектив шалтгаанд: (2 үндсэн шалтгааныг нэрлэе)



Эрх зүйн зохицуулалтын дутагдал:

Дээр дурьдсанчлан захиргаа нь хууль хэрэгжүүлэхийн тулд хууль болон захирамжилсан актын үндсэн дээр бий болгосон ажлын байр юм. Өөрөөр хэлбэл хуулиар захиргаанд буюу төрийн албан хаагчид тодорхой чиг үүргийг хариуцуулаад, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах тусгай эрх мэдлийг олгоод, түүнийх нь төлөө төрөөс цалин өгч, ажиллах нөхцөлөөр хангах учиртай. Гэтэл манайд чиг үүргийн хуваарилалт тодорхой бус, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй байгаагаас тухайн ажлыг хариуцсан албан тушаалтан тодорхой бус, мөн тухайн асуудлыг өөрийн үзэмжээр шийдэхээс өөр аргагүйд хүрдэг. Энэ нь захиргаа ба иргэдийн хоорондын харилцаанд хүндрэл учруулж байна. Жишээ нь нийслэлийн дүүргүүд дээр иргэдээс газартай холбоотой эрхээ эдлэхээр гаргасан хүсэлт өргөдлийг шийдвэрлэхдээ удаан хойрго ханддаг. Тухайн асуудлаар хандсан иргэдийн хүсэлтийг хүн тус бүрээр тухай бүрт нь шуурхай шийдэж хариуг өгдөггүй, хэдийгээр ихэнхидээ эерэг шийдвэр гаргадаг ч нэг удаад доод тал нь 80, заримдаа бүр 150 хүний материалыг хуримтлуулж байгаад Засаг даргад танилцуулж шийдвэр гаргадаг гаж зуршил тогтсон байна. Иргэдээс авсан судалгаанд Та эдгээр байгууллагуудыг яагаад хүнд сурталтай гэж үзэж байна вэ? гэсэн асуултанд чирэгдүүлдэг, удаадаг гэж 63.5% нь хариулсан нь газрын асуудал эрхэлсэн байгууллагатай холбоотой байлаа.

Хууль болон хуульчилсан актуудын харилцан уялдаагүй, зөрчилтэй байдлаас болж иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдөж, захиргаа иргэдийн хоорондын харилцаанд хүндрэл учирч байна. Тухайлбал хууль нь нийгмийн хурдацтай өөрчлөлтийг гүйцэхгүй хоцрогдох, шинээр батлагдсан хуультай уялдуулан холбогдох дүрэм журмуудыг өөрчилж чадахгүй байна /Жишээ нь, Гаалийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсан боловч дүрэм, журмууд нь бараг хуучнаараа байна/.

Төрийн албан хаагчдын тогтвортой ажиллах эрх зүйн орчин бүрдээгүй. Төрийн албан хаагчийн ажлын байрны хамгаалалт: УИХ болон Орон нутгийн иргэдийн хурлын сонгууль болгоны дараа төрийн албан хаагчдын халаа сэлгээ маш ихээр хийгдэж байна. Өөрөөр хэлбэл төрийн албан хаагчдын тухайн ажлын байранд ажиллах хугацаа бодит байдал дээр 4, түүнээс ч бага жил байна. Энэ нь тухайн төрийн албан хаагчийн хувьд хариуцсан салбартаа мэргэших боломж байхгүй, цаашид төрд тогтвор суурьшилтай ажиллах итгэл найдвар байхгүйгээс төрийн албыг хувийн ашиг сонирхлын үүднээс буруугаар ашиглаж иргэдийг чирэгдүүлэхэд хүргэх нэг шалтгаан болж байна.

Эрх зүйн хяналт бараг байхгүй. Захиргааны үйл ажиллагаанд тавих хяналт сул, хуулийн хяналтын хамрах хүрээ зөвхөн “захиргааны акт”-аар хязгаарлагдаж байна. Иймд

захиргааны зарим үйл ажиллагаа хуулийн хяналтанд тухайлбал, захиргааны хэргийн шүүхийн хяналтанд хамрагдахгүй учир төрийн албан хаагчид эрх мэдлээ урвуулан ашиглах боломж нээгдэж, иргэд зөрчигдсөн эрхээ хамгаалуулах боломж хязгаарлагдахад хүрдэг.

Төрийн албаны хариуцлагын тогтолцоо бүрдээгүй. Төрийн албан хаагчийн хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй болгонд тохирсон, эргээд уг төрийн албан хаагчид хариуцлага тооцох үр дүнтэй үйлчлэх эрх зүйн орчин алга байна. Захиргааны хэргийн шүүхээс төрийн албан тушаалтны шийдвэр хууль зөрчсөн, улмаар иргэдийн эрх ашиг зөрчигдсөнийг тогтоодог хэдий ч тухайн албан тушаалтанд хариуцлага тооцож чаддаггүй учир иргэдийг дахин дахин чирэгдүүлж хүнд суртал гаргасаар байна.

2. Зохион байгуулалт /менежмент/-ын дутагдал:

Төрийн албан хаагчийн чиг үүргийн хуваарилалт оновчтой биш. Захиргааны эрх зүйн салбарын хуулиудад чиг үүргийн хуваарилалт маш ерөнхий, эсвэл хэд хэдэн албан тушаалтанд давхцуулсан байдгаас хэн хариуцсан нь тодорхой бус, мөн тухайн асуудлыг хэрхэн шийдэх талаар бараг зохицуулалт байхгүй учир хүнд суртал бий болох нэг шалтгаан нь болж байна.

Тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийгдээгүй;

Захиргааны байгууллагын ажлын уялдаа холбоо муу;

Иргэдэд үйлчлэх \зөвлөх\ үүргээ мартсан;

Мэдээллээр хангадаггүй зэрэг нь бидний судалгааны явцад ажиглагдлаа.

Энэ бүхний үр дүнд иргэнд ямар үр дагавар учирч байгааг тогтоох зорилгоор “Хүнд суртлаас болж та хэрхэн хохирч байна вэ?” гэсэн асуулт тавихад 59.8% нь бухимдана, 46.3% нь эдийн засгийн дарамт учирна, 45.1% нь эрх зөрчигдөнө, 40.5% нь төр иргэдийн хооронд үл итгэлцэл үүснэ гэж хариулсан байна.

Төгсгөлд нь: төрийн захиргааны байгууллага дахь хүнд суртлыг багасгахад нөлөөлөхүйц арга замыг нэгд боловсон хүчний хувьд, хоёрт ажлын байрны хувьд дараах чиглэлээр санал болгож байна.

Боловсон хүчний хувьд:



Идэвхи санаачлагыг дэмжих: Төрийн захиргааны байгууллагын хүнд суртлыг багасгах нэг гол нөхцөл нь албан хаагч нь хариуцсан ажилдаа идэвхи санаачлагатай ажиллах явдал юм. Төрийн албан хаагчийн идэвхи санаачлагатай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд дараах зүйлсэд анхаарах шаардлагатай байна:

- Тогтвортой ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх,
- Улс төрийн болон бусад дарамт шахалтаас ангижруулах

Мэргэшүүлэх: Захиргааны байгууллагаас иргэдэд үзүүлж буй ажил үйлчилгээний чанар нь төрийн албан хаагчийн тухайн салбартаа хуримтлуулсан туршлага, мэргэшсэн байдлаас шууд хамаарна. Энд юуны өмнө захиргаа нь улс төрөөс ангид улс төрийн шийдвэрийг /засгийн газрын мөрийн хөтөлбөрийг/ хэрэгжүүлдэг мэргэшсэн аппарат байх ёстой. Мэргэшсэн захиргааны аппарат бүрдүүлэхэд дараах зүйлсэд анхаарах шаардлагатай байна:

- Төрийн алба болгонд тохирсон боловсрол, мэргэжлийн шаардлага тавих
- Төрийн албан хаагчийн давтан сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах,
- Төрийн албан хаагчийн мэргэжлийн ур чадвар, ажилласан жилээс хамааран албан тушаал дэвших тогтолцоог бий болгох.

Ашиг сонирхлын зөрчлийг арилгах: Төрийн албан хаагч нь хашиж буй төрийн албаа хувийн зорилгоо гүйцэлдүүлэх хэрэгсэл болгох, төрд ажиллах хүсэл сонирхолгүй байдал нь иргэдэд хүнд дарамт болон тусаж байна. Иймэрхүү хууль бус байдлыг таслан зогсоохын тулд:

- Төрийн албанд тавих эрх зүйн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох,
- Аливаа зөвшөөрөл олгох болон бусад шийдвэр гаргах ажиллагааг хууль болон бусад хэм хэмжээний актаар нарийвчлан зохицуулах гэсэн гурван бүлэг арга замыг санал болгож байна.

Ажлын байр /Төрийн алба/-ны хувьд

Энэ хүрээнд эрх зүйн зохицуулалтын болон зохион байгуулалтын гэсэн хоёр үндсэн чиглэлээр тус бүр гурван дэд чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг тэмдэглэж байна. Үүнд:

Эрх зүйн зохицуулалтын хувьд:

Цогц системтэй суурь зохицуулалт бий болгох: Хүнд суртал нь төрийн байгууллагаас иргэдтэй харилцах харилцааны явцад үүсэж байна. Иймд захиргаа ба иргэдийн хоорондын харилцааны суурь системтэй зохицуулалтыг бий болгох нь

зүйтэй юм. Үүнд захиргааны эрх зүйн харилцааны субъект болох, захиргаанаас гадагш иргэдтэй харилцах үйл ажиллагааны ямар хэлбэрүүд байх /шийдвэрийн төрлүүд/, эдгээр шийдвэрүүд ямар шаардлагыг хангах ёстой, хэрэв шийдвэр нь эдгээр шаардлагыг зөрчсөн бол ямар үр дагавар үүсэх зэрэг хамаарна.

Зохицуулах чадварыг сайжруулах: Хууль болон бусад эрх зүйн актын зохицуулалт нь нийгмийн харилцааны хурдацтай өөрчлөлтийг гүйцэхгүй хоцрох, эсвэл гадаадын өндөр хөгжилтэй орны хуулийг орчуулж хэрэглэснээс болж хэтэрхий ахадсан шаардлага тавих зэргээр тухайн нийгмийнхээ харилцааг зохицуулах чадваргүй болж иргэдэд хүндрэл учруулдаг. Иймд хууль, бусад эрх зүйн актын хэрэгжилтэнд судалгаа хийж нэмэлт өөрчлөлтийн төслийг байнга давтамжтайгаар хэлэлцүүлж байвал зүйтэй байна. Судалгааны байдлаас ажиглавал хүнд сурталтай холбоотойгоор “Төрийн албаны тухай хууль”-д төрийн албан хаагчийн эрх зүйн статусыг тодорхой болгох үүднээс: төрийн албан хаагчийг томилох, ажлаас чөлөөлөх, халах, төрийн албаны хариуцлагыг тодорхой болгох зэрэг нэмэлт өөрчлөлт хийх хэрэгтэй байна.

Шийдвэр гаргах ажиллагааг ил тод болгох: Иргэд захиргааны байгууллагаас ямар нэгэн зөвшөөрөл авахад ямар бичиг баримт бүрдүүлэх, ямар болзол нөхцөлийг хангасан байх, ер нь юу шаардлагатай талаар тодорхой мэдээлэлгүй мөн шийдвэр гаргах ажиллагаа ямар үе шатаар явагдахыг ихэнхдээ мэддэггүй учир захиргаа ба иргэдийн хооронд үйл ойлголцол бий болдог. Иймд практикт их хэмжээгээр хэрэглэгддэг, маргаан үүсэж болохоор шийдвэр гаргах ажиллагаануудыг аль болохоор хуулиар, эсвэл хэм хэмжээний актаар урьдчилан зохицуулсан байх нь зүйтэй.

Зохион байгуулалтын хувьд:

Бүтэц зохион байгуулалт, чиг үүргийн хуваарилалтыг боловсронгуй болгох,

Нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлэх, иргэдэд зөв ойлголтыг бий болгох,

Мэдээллийн технологийг нэвтрүүлэх, иргэдэд ач холбогдлыг нь таниулан сурталчлах зэрэг болно.

Жич: Олгогдсон богино хугацаанд бүх асуудлыг хамруулан авч үзэх боломжгүй байсан тул бидний судалгааны тайлангаас тодруулж үзнэ үү. Хэвлэгдэж нийтийн хүртээл болно гэж итгэж байна.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИВЭЭЛ ДОР
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР,
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС,
НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛСАН
“ХҮНИЙ ЭРХ БА ХҮНД СУРТАЛ”
ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ**

2008 оны арваннэгдүгээр
сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

Олон улсын Хүний эрхийн өдөр, Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдсаны 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Хүний эрх ба хүнд суртал” сэдэвт Үндэсний чуулганыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс хамтран 2008 оны арваннэгдүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулав. Тус чуулганд төв, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийн болон олон улсын байгууллагууд, эрх зүйн боловсрол олгодог их, дээд сургуулиудын 700 гаруй төлөөлөгчид оролцов.

Үндэсний чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгч Намбарын Энхбаяр, НҮБ-ын Монгол Улс дахь суурин зохицуулагч, НҮБХХ-ийн суурин төлөөлөгч Дебора Комини, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Солонго нар үг хэлж, “Төрийн байгууллагын үйл ажиллагаанд ил тод байдлыг хангах”, “Хүний эрх ба иргэний бүртгэл”, “Гаалийн байгууллагын ил тод байдал ба хүний эрх”, “Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хүнд суртлыг бий болгож буй зарим асуудал”, “Өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүнд суртал” зэрэг илтгэлүүдийг сонсож хэлэлцэв.

Энэ удаагийн Үндэсний чуулганыг угтсан бэлтгэл ажлын хүрээнд төрийн захиргааны болон хууль хяналтын байгууллагад оршиж байгаа хүнд суртал түүнийг үүсгэж байгаа шалтгаан нөхцлийг тогтоох зорилгоор эрдэмтэд, судлаачдын 2 багийг сонгон шалгаруулалтаар бүрдүүлэн ажиллуулсан бөгөөд эдгээр багуудын судалгааны тайланг танилцуулж, хэлэлцүүлээ.

Чуулганд оролцогчдоос төрийн албан дахь хүнд суртлыг арилгах, хүний эрхийг хүндэтгэн төрийн албаны бүх шатанд шударга үйлчилж, иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг шуурхай барагдуулах, хууль ёсны эрхээ эдлэх, иргэдэд бэрхшээл, төвөг учруулахгүй ажил хэргийг нь бүтээж байх талаар сайн тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтыг цогцоор нь бүрдүүлэх шаардлагатай байгааг Үндэсний чуулганд оролцогчид санал нэгтэй хүлээн зөвшөөрч, уг чуулганаас дараах зөвлөмжийг гаргав.

Нэг. Төрийн захиргааны байгууллагуудад

1.1. Байгууллагын дотоод үйл ажиллагааг эрх зүйн актуудад нэг бүрчилсэн дүн шинжилгээ хийж, илүүдэл шат дамжлага бүрдүүлсэн, иргэдэд ямар нэг байдлаар хүндрэл, чирэгдэл учруулах боломжийг бүрдүүлсэн эсэхийг нягтлан, илэрсэн дутагдлыг засч цэгцлэх ажлыг 2009 оны 1 дүгээр сард багтаан хийж гүйцэтгэх;

1.2. Байгууллагынхаа үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, иргэд, хэвлэл мэдээллийн байгууллагын хүссэн цагтаа шаардлагатай мэдээлэл олж авах боломжийг бүрдүүлэх, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх талаар зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн, үр дүнг тооцож ажиллах;

1.3. Аливаа асуудлыг шийдвэрлэхдээ гаргаж байгаа шийдвэрийн үндэслэлийг олон нийтэд ойлгогдохуйц тусгаж, ил тод, нээлттэй байх, шаардлагатай хэсэг бүлэгт, эсвэл нийтэд шуурхай хүргэж мэдээллэх горимыг үйл ажиллагаандаа тогтмолжуулан хэвшүүлэх;

1.4. Олон нийтэд хандсан захиргааны шийдвэр гаргахдаа холбогдох байгууллага, иргэдийн саналыг аль болох өргөн авах, тэдгээрийг харгалзан тусгах явдлыг журамлан мөрдүүлэх;

1.5. Хуульд аливаа үйлчилгээ үзүүлэхдээ иргэдээс авахаар заасан төлбөр, хураамжийн төрөл, хэмжээг нягтлан үзэж, шаардлагагүйг нь хүчингүй болгож цөөрүүлж, багасгах арга хэмжээг авах ба хуулиас гадуур төлбөр, хураамж авахаар тогтоосон дүрэм, журмуудыг хүчингүй болгох, энэ зүй бус үйл ажиллагааг бүх салбарт таслан зогсоох;

1.6. Төрийн албан хаагчид албан үүргээ биелүүлэхдээ иргэдэд зохиомол хүндрэл үүсгэж, тэдний эрхийг үл хүндэтгэсэн байдал гаргасан тохиолдол болгонд хариуцлага тооцдог хяналт, хариуцлагын зарчмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох;

1.7. Төрийн албан хаагч ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, илрүүлэх ажилд хувь нэмэр оруулж идэвх санаачилгатай ажиллах;

1.8. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх нэг цэгийн үйлчилгээ буюу хүлээн авсан газар нь бусад бүх асуудлыг судлан шийдвэрлэж хариу өгөх тогтолцоог бий болгон ажиллах;

Хоёр. Гаалийн ерөнхий газарт

2.1. Захиргааны дүрэм, журам, зааврыг “Гаалийн тухай хууль”-тай нийцүүлэн боловсруулах, тэдгээрийг анх боловсруулах үе шатнаас нь эхлээд ил тод, гаалиар үйлчлүүлэгч (сонирхолын бүлэг)-ийн саналыг тусгаж боловсруулдаг журамд шилжих зорилгоор Дэлхийн банкны “Захиргааны актын стандартчилал” төсөлд хамрагдаж, гаалийн дүрэм, журмыг хүнд суртал, илүү шат дамжлагаас ангид байхаар боловсруулах;

2.2. Гаалийн байгууллагын үйл ажиллагааг ил тод болгож, нийтэд цахим мэдээллээр үйлчлэх зорилгоор төрийн хууль зүйн мэдээллийн систем болох “LEGALINFO” сүлжээнд гаалийн байгууллагыг холбох;

2.3. Экспортлогч, импортлогчийн гэрээний үнийг үндэслэн гаалийн татвар ногдуулдаг үйл ажиллагааг хэвшүүлж эхлэх;

2.4. Гаалийн зуучлагч мэдүүлсэн бараатайгаа холбоотой бүх хариуцлагыг гаалийн байгууллагын өмнө хүлээж, гаалийн байгууллага экспортлогч, импортлогчтой аль болох “нүүр тулсан” харьцаанд ордоггүй олон улсын жишгийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх;

2.5. Гаалийн хяналтын зохистой орчин (орчин үеийн хяналтын техник хэрэгслээр хангах, ложистик терминал байгуулах, олон улсын тээврийн стандартыг хэрэгжүүлэх, г.м.)-ыг бүрдүүлэх үе шаттай арга хэмжээ авах;

Гурав. Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвд

3.1. Иргэний бүртгэл, мэдээллийн үйл ажиллагааны иргэдэд үйлчлэх шат дамжлагыг цөөлөн, иргэдэд үзүүлж буй үйлчилгээг аль болох чирэгдэлгүй байхаар зохион байгуулах;

3.2. Дотоод үйл ажиллагааны хяналтыг сайжруулан, ажилтнуудын хариуцлагыг өндөржүүлж, хүн нэг бүрийн үйлчилгээний соёл, шуурхай байдлыг хангах, албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх талаар сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж үр дүнг нь тооцож ажиллах;

3.3. Байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэд, олон нийтийн гомдол, хүсэлт, саналыг үйл ажиллагаандаа харгалзан үзэх, иргэдэд зориулсан мэдээллийг аль болох ил тод, хүртээмжтэй хүргэх арга замыг сонгож ажиллах;

3.4. Баримт бичгийн лавлагаа олгох үйл ажиллагааг байгууллагын анхан шатны нэгжүүд болон бусад холбогдох байгууллагуудын цахим сүлжээгээр дамжуулан олгох тогтолцоо, механизм бүрдүүлэх;

3.5. Иргэдэд үйлчлэхдээ хууль тогтоомжид зааснаас илүү төлбөр, хураамж тогтоохгүй байхад онцлон анхаарах;

Дөрөв. Нийслэлийн Газрын албанд

4.1. Газрын харилцааг зохицуулж буй хууль тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон актуудын нэгдсэн бүртгэл хөтлөлтийг бий болгож, дотоод үйл ажиллагааны дүрэм, журмуудыг хуульд тогтоомжид нийцүүлэн шинэчилж, боловсронгуй болгох;

4.2. Газрын эзэмшил, ашиглалт, өмчлөлийн талаарх мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, газрын албадын хооронд мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгон иргэдийг газрын эзэмшил, ашиглалт, өмчлөлтэй холбоотой бодит мэдээллээр хангах нөхцлийг бүрдүүлэх;

4.3. Дотоод хяналтыг сайжруулан газрын албанд иргэдээс ирүүлсэн гомдол, хүсэлт, өргөдлийг зохих журмын дагуу хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэхэд онцгой анхаарч, энэ талаар хариуцлага алдсан албан хаагчид тухай бүр хариуцлага тооцдог тогтолцоо бүрдүүлэх;

4.4. Газрын харилцаанд оролцох эрх, түүнийг хэрэгжүүлэх арга замын талаар иргэдэд хангалттай мэдээлэл өгөх, эрхээ хамгаалах боломжийг нь тайлбарлан таниулах, зөвлөгөө өгөх ажлыг тогтмол зохион байгуулах;

4.5. Иргэдийн мэдээлэл олж авах боломжийг бүрдүүлэх, үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангах зорилгоор газрын харилцаатай холбоотой хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй үйлчилгээний талаар мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол хийх;

4.6. Шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, үйл ажиллагаандаа иргэдийн бүтээлч санал санаачилгыг тусгах үүднээс тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг иргэдийн оролцоотойгоор төлөвлөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж эхлэх;

4.7. Үйл ажиллагаандаа хяналт дүн шинжилгээ хийх;

Тав. Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газарт

5.1. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудтай харилцан уялдаагаа сайжруулж, хууль эрх зүйн талаас нь мэдээ мэдээллээр цаг алдалгүй түргэн шуурхай хангах, хамтарсан сургалтыг орон нутагт болон нэгдсэн байдлаар тогтмол явуулж байх;

5.2. Агентлагийн боловсон хүчний асуудалд анхаарал хандуулж, тэргүүн ээлжинд геологи уул уурхайн салбарын мэргэжлийн боловсон хүчнээр хангах ажлыг эхлүүлэх, тэдгээр ажилтнуудын мэдлэг, ур чадвар, ёс суртахууны хэм хэмжээг нь дээшлүүлэхэд чиглэсэн ажлуудыг зохион байгуулах;

5.3. Ашигт малтмалын тухай хууль, түүнийг дагаж гарсан журмыг цаашид улам боловсронгуй болгох, хуульд тусгагдсан зарим нэр томъёог нэг мөр ойлгомжтой болгон хэрэглэх;

Зургаа. Хууль, хяналтын байгууллагуудад

6.1. Хууль, хяналтын байгууллагуудын албан хаагчдад харилцааны ёс зүйн талаарх сургалтыг мэргэжлийн байгууллага, багш нартай хамтран тусгайлан боловсруулсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулах;

6.2. Үйл ажиллагааны талаар иргэдийн санал асуулгыг хагас жил тутам авах, үүний үр дүнд авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж хэвшүүлэх;

6.3. Хууль, хяналтын байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдол, хүсэлт, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх журмын хэрэгжилтийг сайжруулж, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг хагас, бүтэн жил тутам судлан үзэж байх;

6.4. Иргэдээс гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх үйл ажиллагааны журмыг зөрчсөн, хүнд суртал гаргасан албан хаагчдад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох тогтолцоог илүү үр нөлөөтэй болгох;

6.5. Шүүгч, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргасан талаар гомдол гаргасан тохиолдол бүрд судалгаа хийж, хариуцлага хүлээлгэсэн эсэх тухай олон нийтэд мэдээлдэг байх;

6.6. Энэ талаар мэргэжлийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих албан тушаалтан, нэгж байгууллага тусгайлсан хөтөлбөр боловсруулж, үйл ажиллагааныхаа талаар нийтэд тогтмол мэдээлдэг байх;

Долоо. Шүүхийн ерөнхий зөвлөлд

7.1. Шүүхийн байгууллага бүрт хэргийн хөдөлгөөн, өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэсэн байдал, шүүх хуралдааны тов, шүүгчдийн ажлын цагийн хуваарь, томилолт, шүүх хуралдаанд оролцож байгаа эсэх зэрэг мэдээллийг багтаасан шүүхийн цахим хуудсыг тогтмол ажиллуулж, түүгээр дамжуулан өргөдөл, гомдол хэрхэн шийдвэрлэсэн талаар иргэдэд байнга мэдээлэл хүргэж, хариу өгөх чиг үүрэг бүхий нэгж (ажилтан) ажиллуулах боломжийг судалж хэрэгжүүлэх;

7.2. Шүүх хуралдааныг товлосон цагтаа эхэлдэг болгох, хэргийн оролцогч нарыг цаг хугацааны болон эд материалын хувьд чирэгдэл, хохиролгүй шүүх хуралдаан явуулах талаар анхаарч, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

Найм. Прокурорын байгууллагад

8.1. Прокурор хуулиар хүлээсэн хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа аливаа илрэлүүдийг таслан зогсоохын тулд дотоодын хяналт, албаны шалгалтыг үр дүнтэй явуулж, шалгалтын мөрөөр илэрсэн зөрчлийн шалтгааныг заавал тогтоож, холбогдох арга хэмжээ авдаг байх явдлыг хэвшүүлэх;

8.2. Прокурорын мэргэжлийн ур чадвар, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээг авч, Прокурорын Мэргэжлийн Зөвлөл болон Ёс зүйн Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэдэг байх;

8.3 Мэдээлэл лавлагааны цэгийн үйл ажиллагаанд холбогдох дүрэм, зааварт заасны дагуу нээлттэй, үр ашигтай, шуурхай байх нөхцлийг бодитоор бүрдүүлэх, замаар иргэдийн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх журмын хэрэгжилтийг сайжруулах;

Ес. Цагдаагийн байгууллагад

9.1. Цагдаагийн байгууллагын цахим хуудасны мэдээ, мэдээллийг тогтмол, шуурхай шинэчилж, иргэдийн санал, гомдлыг цахим шуудангаар хүлээн авах, шуурхай хариу, зөвлөгөө өгөх ажлыг хэвшүүлэх;

9.2. Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллага, албан тушаалтанд гаргасан

санал, өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх журмыг дахин хянаж, иргэдийг чирэгдүүлэхгүй байх чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд нэмэлт эрх зүйн акт боловсруулан гаргах ажлыг зохион байгуулах;

9.3. Өргөдөл, гомдол шалгах эрх бүхий албан тушаалтны өргөдөл, гомдол хүлээн авч, шийдвэрлэж байгаа байдалд хяналт тавьж, гарсан дүгнэлтийг тэдний ажлыг үнэлэхэд шалгуур үзүүлэлт болгох;

Арав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт

10.1. Иргэд, байгууллагаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг судалж, холбогдох саналыг байгууллагын бодлого шийдвэрт тусган, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, байгууллагын үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр жилд 2 удаа мэдээлэх ажлыг зохион байгуулах;

10.2. Иргэд байгууллагаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх журмыг дахин хянаж холбогдох эрх зүйн акттай уялдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах, хэрэгжилтийг хангуулах;

Арван нэг. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар

11.1. Энэхүү зөвлөмжийн хэрэгжилтэд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс хяналт тавьж ажиллана.

11.2. Зөвлөмж болон түүний хэрэгжилтийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

11.3. 2009 оны 4 дүгээр улиралд багтаан зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх холбогдох байгууллагуудын тайланг хэлэлцэх, энэ талаар нийтэд мэдээлэх зорилгоор Чуулганд оролцсон бүх талуудыг хамарсан дугуй ширээний ярилцлага зохион байгуулна.

ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНД ОРОЛЦОГЧИД

*Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдсаны 60 жилийн ойн хүрээнд
Хүүхдийн хорих ангид зохион байгуулсан “Миний гэмшил, ухаарал”
сэдэвт зохион бичлэгийн уралдаанд түрүүлсэн бичлэгээс*

МИНИЙ ГЭМШИЛ, УХААРАЛ

Ц. Буянбат

Сайн байна уу? Эрхэм ах эгч та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Миний гэмшил ухаарал гэсэн агуу сэдвээр зохион бичлэгийн уралдаан зарласанд, басхүү оролцож байгаадаа маш их баяртай байна. Намайг энд хийсэн хэрэгтээ гэмшиж, өчүүхэн ч болтугай зүйл ухаарсныг минь хүмүүс ойлгоосой, өөр олон зүйлийг ухаараад, дахин ийм зүйл хийхгүй гэдэгт итгээсэй гэсэнд оршино.

Би энд ирээд засарч хүмүүжиж байгаадаа их баяртай байгаа. Намайг хүмүүс сайн хүүхэд, маш их өөрчлөгдөж байгаа гэж ярихад магнай хагарах дөхдөг юм. Гэхдээ би наранд /гадна/ байхдаа маш муу хүүхэд байсан. Өөрөөсөө өөр хэнийг ч хайхардаггүй, зугаа цэнгэлээс өөр зүйл боддоггүй. Цагдаа харахаараа айж бултаж явдаг, амьдрах гэж ядарч яваа, яг л миний аав, ээж шиг хүний зүйлийг хулгайлдаг, одоо бодоход үнэхээрийн сул дорой нэгэн байсан.

Энэ бүхэн намайг хөтөлсөөр би өөрийгөө маш аймшигтай зүйл хийхэд хүргэсэн. Би бүхэл бүтэн эцэг хүн, тэр дундаа эрдэнэт хүний амийг хөнөөсөн. Тэр үед намайг миний оюун санаа захирах бус, харин уур хилэн захирч байсан. Энэ бүхний тухай бодоход зарим үед би өөрөөсөө хүртэл айдаг. Би багаасаа хагас өнчин өссөн болохоор надад нэг зүйл маш их бодогддог. Тэр хүний хүү ээжээсээ ааваа нэхдэг болов уу? гэж. Тэгвэл тэр хүний сэтгэл зүрх нь урагдах шиг болдог байх даа. Миний бие хяхарч байгаа юм чинь. Би ер нь амьд явах эрхгүй хүн. Заримдаа би өөрийгөө маш их үзэн яддаг. Би ямар олон хүний итгэлийг хөсөрдүүлэв дээ. Ээж минь надад бурхан шүтээндээ итгэдэг шиг л итгэдэг. Үсэндээ гадагшилтал чуулсан цагаахан итгэлийг нь би одоо л нэг ойлгож байна. Би дахин л надад итгэсэн хүний итгэлийг алдахгүй, үнэнхүү сайн хүү, сайн хүн болно гэдэгтээ итгэл төгс байна. Миний үе тэнгийн найз нар минь ёс суртахуунаар цэвэр ариун, мэдлэг оюунаар өгөөмөр баян, ухаалаг, миний хийсэн зүйлийг бүү хийгээсэй гэж хүснэ.

МИНИЙ ГЭМШИЛ УХААРАЛ

О.Батбаатар

Би мянга есөн зуун ерэн нэгэн онд аз жаргалтай гэр бүлд анхны хүүхэд нь болон төрсөн. Түүнээс хойш аав ээж хоёр минь миний төлөө бүхнээ зориулж 1999 онд 10 жилийн сургуульд орж, амьдрал минь аз жаргалтай үргэлжилж байтал, гэтэл аймшигт тэр нэгэн өдөр аав минь краз машинтай Баянхонгороос ирж байгаад замдаа аваарт орж, аав минь нас барсан. Би тэр явдлаас болж сэтгэлээр унаж, сэтгэл санаа минь нэг л тогтворгүй, аавыгаа санан үргэлж л уйтгарлан суудаг байлаа. Түүнээс хойш би хэний ч үгэнд орохоо больж, зөрүүдлэн гадуур тэнэдэг боллоо. Аргагүй эрхэнд хүний төлөө сурж байгаа юм шиг үлгэн салган 9-р ангиа төгсөж, 10-таа орлоо. Ээж минь намайг үргэлж л лам хард үзүүлнэ. Би бас л тэндгээрээ тэнэж яваад дээрэм хийн хэд хоноод л баригдлаа. Баригдсан даруйдаа л “Ганц худаг”-т ачигдан ирж, мөрдөнд нь нэлээн удаан суулаа. Энэ хооронд ээж минь миний төлөө бас л хөөцөлдөж, долоо хоног бүр ирж эргэдэг байлаа. Удалгүй ял аван энэ хорих ангид ирлээ. Ээж минь бас миний төлөө санаа зовон байнга л ирдэг. Харин би өнгөрсөн амьдралаа орой бүр бодон, ямар муухай, ямар аймаар амьдарч байснаа, мөн ээж минь өдөржингөө ажил хийгээд орой гэртээ ирээд хүү нь бас л байхгүй, цай чанаад тавьж байхын оронд РС, билльярд тоглож явдаг байсандаа одоо харамсаад нэмэргүй боллоо. Гэхдээ орж болсон юм чинь гарч болно. Гараад би ээжийнхээ ачийг хариулахын төлөө, хүмүүсийн итгэлийг олж авахын төлөө үлдсэн амьдралаа зориулах болно.

Ээж ээ:

Энхрийлж өсгөсөн хүү тань

Ээж таныгаа даанч зовоолоо доо

Жаргаана гэж хүү нь бодсон ч

Эндэж алдахаа даанч мэдсэнгүй

Энэрэлт энэ хорвоог даанч хүү нь

Хар бараанаар бодож явсангүй

Үүрд жаргах юм шиг бодож

Үр чинь даанч том алдлаа

Гунигийн нулимс унагаад хүү чинь

Ээжийнхээ гомдсон сэтгэлийг тайтгаруулж чадсангүй

Энхрийлж бурхан ээж минь өршөө

Ухаан мунхаг хүүгээ алдсан ч та минь

Уужим сэтгэлээр харж цааш түлхсэнгүй

Чангаас чанга тэврэх юмсан ээжийгээ

Лааны дөл мэт дүрэлзэж явжээ хүү нь
 Анхаарч таныхаа сургаалыг сонссонгүй
 Алтан дэлхийд мөнхийн ус байдаг бол
 Рашаан болох тэр усыг
 Алт мэт нандигнан ээж таньдаа өгөхсөн
 Илгэн чулууг имтэртэл хадны чулууг хагартал амьдрах болно оо.
 Ээж ээ. Хүү нь таньдаа хайртай шүү, хүү нь ачийг нь хариулна аа.

МИНИЙ УХААРАЛ БА ГЭМШИЛ

Б.Энхболд

Сайн байна уу? Намайг Болдбаатар овогтой Энхболд гэдэг. Энэхүү зохион бичлэгийн уралдааныг зохион явуулж байгаа “Хүний эрхийн” хамт олон болон Бадамсүвд эгчдээ баярласнаа илэрхийлье. Намайг Б.Энхболд гэдэг. Би 16 настай. Би энэхүү шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа насанд хүрээгүйчүүдийн хорих ангид байгаа. Би одоо 6 жил 10 хоногийн хугацаанд өөрийгөө Монгол Улсын хуулиас гадуур байлгахад хүргэж өөрийнхөө ухаан бодол, бие бялдраас гарахааргүй зүйл хийж Монгол Улсын иргэний хуулиас гаж буруу зүйл үйлдэж, энэ нийгэмд ямар болохгүй хор уршиг тарьж, ардаа өч төчнөөн хүнийг хохироосноо одоо л ойлгож, маш их гэмшиж байгаа. Зөвхөн би ч гэлтгүй энэ танхимд хүрэлцэн ирээд байгаа анд найз нар маань мөн л адилхан гэмшиж байгаа гэдэгт би итгэж байна.

Энэхүү гэмшил маань энэ нийгэмд өчүүхэн ч гэсэн хувь нэмэр оруулахгүй ч харин надад засарч хүмүүжихэд маань багахан хувь нэмэр болно гэдэгт итгэж байгаа. Бас би гэмшийн хажуугаар зөндөө олон зүйлийг ухаарсан юм. Одоо би энэ хорих ангиас засарч хүмүүжээд өөрийн үлдсэн гэрэлт ирээдүйгээ шинээр эхэлж, эргээд алдахгүй байж өөрийн гаргасан алдаагаа яаж ухаарч, яаж засахаа хайрт аав ээж ах дүү нартаа болон анд найз нартаа харуулах болно оо. Миний гэмшлээ ухаарахад тусалсан 411-р ангийн хамт олон бие бүрэлдэхүүн болон Монхарбор төрийн бус байгууллагын ах эгч нартаа гүн талархал илэрхийлье. Бас би эндээс гараад ямар мэргэжил, ямар боловсролтой хүн болохоо өөрөө мэдэж байгаа болохоор нийгэмд ямар эерэг нөлөөтэй хүн болохоо аав ээждээ харуулахын төлөө ухаажин гаргасан алдаагаа давтахгүйн тулд ухаарч байгаа. Манай анги болон Монхарбор буюу төрийн бус байгууллагын ах эгч нарын маань санаачилгаар манай хүүхдүүдээс гарсан Хараацай хэмээх хамтлагийг гаргаж энэ олон хорих ангиудаар явж, алдаж эндсэн хүмүүст ухаарал хайрлан бас бид нарт ухаарал гээчийг ойлгуулж өгсөнд баярлалаа. Би хэдий ганцхан хоор дуу дуулж байгаа ч тайзны араас хараад зогсож байхдаа найзууд минь энэ хүмүүст юу ойлгуулж, юуг бодогдуулж

байгааг би нүдээрээ харж, юуг бодож тэр хүмүүс нулимс унагаадгийг би мэднэ ээ. Энэ бол ухаарал юм. Тиймээс ч манай хамтлагийн ахлагч Мөрөн ах маань тоглолт эхлэхээс өмнө үг хэлэхдээ бүгдээрээ алдсан алдаандаа хөтлөгдөн амьдрах биш, харин алдсан алдаагаа ахин давтахгүй ураарч амьдраач ээ гэж хэлж байгааг би, бид бүгд мэднэ. Ингээд энэ зохион бичлэгээ Хараацай хамтлагийнхаа Үзээд хэн ч атаархах гэрэлт ирээдүй бидэнд бий гэдэг үгээр өндөрлөе. Энэ бол зөвхөн миний гэмшлээ ойлгож ухаарсныг харуулах байх аа.

*Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдсаны 60 жилийн ойн хүрээнд
хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудын дунд зохион байгуулсан
“Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал-Хүний эрхийн баталгаа болох нь” сэдэвт
зохион бичлэгийн уралдаанд түрүүлсэн бичлэгээс*

“ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ- ХҮНИЙ ЭРХИЙН БАТАЛГАА БОЛОХ НЬ”

Б.Мэргэн МУИС-ийн ХЗС-ийн оюутан

Оршлын оронд - Хүний эрх баталгаажсан нь буюу түүхийн хуудас сөхвөл...

Хүний бие хүн болох шинж чанар нь түүнд эрх зүйн этгээд болох шинж чанарыг олгож буй ба хүн зөвхөн оршин байгаа гэдгээрээ л тодорхой эрхүүдийг эдэлдэг. Үүнийг хүний эрх гэдэг. Хүн төрөлхтөн түүхийн бүхий л цаг үед уг эрхээ баталгаажуулахын төлөө тэмцэл өрнүүлж ирсэн бөгөөд тэр чинээгээрээ тухайн цаг үеийн нөхцөл байдал, ёс заншил, соёлын иргэншлийн гаж үзэгдэл, хаан хийгээд язгууртнууд хэмээгдэх зүй бус эрх мэдэлтнүүдийн харгис дарангуйлал зэрэг олон бэрхшээлтэй тулгарч байв. Гэвч эцсийн бүлэгт шударга ёс ялж хүний эрх өөрийн бодит шинж чанараараа баталгаажсан бөгөөд түүхэн учиг шалтгааныг дор дурдъя.

Эртний Грек, Ром нь өнөөгийн соёл иргэншлийн эхлэх цэг нь байж судлаачид аливаа түүхэн хөгжлийн эх сурвалжийг нэн тэргүүнд тэндээс эрж хайдаг билээ. Тухайн үеийн Грект бурхан тэнгэр хүн бүрийг тэгш байхаар бүтээсэн төдийгүй хэнийг ч боол болгоогүй гэсэн үзэл санаа бий болж, бүхнийг хүчирхийлэгч, заан зааварлагч төр-засгийн эрхийг хязгаарлан, хувь хүний эрх чөлөөг улам бүр өсөн нэмэгдүүлэхийг зорьж байсан юм. Эртний сэтгэгч Аристотель “Аливаа хууль нь нэгэн төрлийн (жам ёсны) эрхэд үндэслэж байдаг бөгөөд хэрэв тиймгүй бол хууль нь хэмжээгүй эрхт ноёрхлын хэрэгсэл болж хувирна”¹ гэж хэлжээ.

Харин Дундад зуун бол хөдлөшгүй үнэнийг хүсэгч сохор итгэл, үг дуугүй захирагдах явдал, оюун ухаанаас давсан бишрэл ноёрхсон мистицизмын (мухар харанхуй сүсэг бишрэл) эрин үе байсан² бөгөөд эрх чөлөө хэмээх ойлголт нь хаан хийгээд түүний алтан ургийнханд хамаатай болтлоо явцуурч байв. Үүний дараагаар сэргэн мандалтын эрин үед хүний оюун санаа чөлөөлөгдөж, сохроор дагаж мөрдөх явдлыг ухаалгаар эргэцүүлэх явдал ялж, оюун ухаан эргэн ирснээр³ хэн бүхэнд хүртээлтэй эрх чөлөөний үзэл гарч ирэхэд хүргэсэн билээ. Ийнхүү эрх чөлөө нь нийт хүн төрөлхтөнд хамаатай юм байна

¹ Аристотель. Политика 12. 18. 1225а. С.19.

² Мөн ном. 52 дахь тал.

³ Боаз Д. Либертарианизм. (Орч. Б.Батчулуун). УБ., 2005.52 дахь тал

гэсэн үзэл төлөвшихөд өрнийн сэтгэгчид чухал хувь нэмрээ оруулжээ. Тухайлбал, английн сэтгэгч Ж.Локк “Хүний эрх төр үүсэхээс өмнө байсан учир бид түүнийг байгалаас заяасан эрх гэдэг. Байгал бидэнд эрхийг өгчээ...Хүн бүр төрөлхөөсөө амьд явах, халдашгүй байх, өмчлөх эрхтэй байдаг⁴ хэмээн номлож байв. Мөн эрх чөлөөний эцэг гэгддэг Ж.С.Милл “Соёл иргэншсэн нийгмийн гишүүнийг зүй ёсоор дарамталж, түүний хүсэл зоригийн эсрэг эрх мэдэлтний зүгээс үйлдэж болох цор ганц шалтгаан бол бусдад хор хөнөөл учруулахыг нь зогсоох явдал. Бие бялдар, ёс суртахууны давуу байдал нь түүнийг цагаатгах үндэс болохгүй⁵ гэж хувь хүний эрх чөлөөг хамгаалахыг сурталдаж байв.

Хүн төрөлхтөн эрх чөлөөний талаар олсон амжилтандаа тайвширч, Жэффэрсоны “байнгын сонор сэрэмж бол эрх чөлөөний үнэ төлөөс байдаг” гэсэн анхааруулгыг умартсаны учир XIX зууны сүүлийн хагаст АНУ болон Европ дахь төрүүд дайнаар шалтаглан улам бүр томорч хүний эрхийг уландаа гишгэж эхлэв. Гэвч дайны дараагаар буюу 1948 оны 12 дугаар сарын 10-ны түүхэн өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблей ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ-ыг баталснаараа цөмийн аюул, колончлол, тэгш бус байдалд нэрвэгдсэн дайны дараах ертөнцөд арьс өнгө, гарал үүсэл, итгэл үнэмшлээс нь үл хамааруулан хүний эрхийг тэгш хамгаалах⁶ тухай үзэл санаа дэлгэрэхэд үнэлж баршгүй нөлөө үзүүлсэн юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал-хүний эрхийн баталгаа болох нь

Орчин үеийн Үндсэн хуульт ёсны онолоор хүний жам ёсны эрх нь эрх зүйн үндсэн хэм хэмжээ хийгээд зарчмуудад зайлшгүй тусгалаа олсон байх ёстой. Ингэж байж гэмээнэ үндсэн эрх нь Үндсэн хуулиар хамгаалагдсан, төрийн эрх мэдлийг хязгаарлах хүчин чадалтай, хүний эрхийг хамгаалсан, шууд үйлчлэх эрх зүй болж чадна. Австрийн хуульч, эрх зүйн онолч Ханс Кельзен “Эрх зүйн цэвэр онол” бүтээлдээ эрх зүй өөрөө өөрийнхөө ертөнцийг цогцлуулахын тулд бусад бүх хэм хэмжээг бүтээх Үндсэн хэм хэмжээ байхад л хангалттай⁷ гэж бичсэн нь орчин үеийн үндсэн хуульт ёсны онолыг хөгжүүлж, хүний эрхийг хамгаалахад томоохон нөлөө үзүүлсэн юм. Кельзений үндсэн хэм хэмжээ нь аливаа улсын Үндсэн хуулинд тусгалаа олдог байна. Тиймээс Үндсэн хуулийг “...хамгийн дээд зарчим буюу хэм хэмжээнүүдийн хэм хэмжээ...” гэж тодорхойлдог.

Ийнхүү Кельзен Үндсэн хууль дах хүний эрхийг хамгаалах үзэл санаа төлөвшихөд онолын талаас нь үнэтэй хувь нэмэр оруулсан бол тэр нь улс бүрийн Үндсэн хуулинд бодит тусгалаа олж жинхэнэ утгаараа хүний эрхийн баталгаа болох үндсийг Хүний эрхийн түгээмэл тунхаглал тавьсан юм. Учир нь Түгээмэл тунхаглал нь шинээр тусгаар тогтносон улс гүрэн болон залуу ардчилуудын Үндсэн хуулиа боловсруулах үлгэр

⁴ Боаз Д. Либертарианизм. (Орч. Б.Батчулуун). УБ., 2005. 57 дахь тал.

⁵ Mill J. On Liberty. P. 135. Дам ишлэв. Вольф Ж. Улс төрийн философийн удиртгал.(Орч. Б.Батчулуун). УБ., 2002. 137 дахь тал

⁶ Арбур Л. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 60 жилийн ойн тусгай дугаар. УБ., 2008. IV дэхь тал

⁷ I bid. S 221-222.

загвар болсоор иржээ⁸. Тухайлбал, Түгээмэл тунхаглалыг үзэл санааг Болгар улс Үндсэн хуулийнхаа 2 дугаар бүлэгт (25-61 дүгээр зүйл), Эстони улс 2 дугаар бүлгийн 8-55 дугаар зүйлд, Япон улс 3 дугаар бүлэгт (10-40 дүгээр зүйл) Унгар 12 дугаар бүлэгтээ тусгасан бол манай улс Үндсэн хуулийнхаа 2 дугаар бүлэгт “Хүний эрх, эрх чөлөө” нэртэйгээр баталгаажуулж, 19.1 дүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн хүний эрхийг хамгаалалтыг бэхжүүлсэн байна.

Энд дурьдахгүй байхын аргагүй нэгэн зүйл бол Тунхаглалын удиртгал хэсэг “Хүн төрөлхтний ам бүлийн гишүүн бүхэнд угаас заяасан нэр төр болон тэдний адил, тэгш салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх...”, 1 дүгээр зүйл “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна” хэмээн эхэлдэг нь тохиолдлын хэрэг огт биш юм. Учир нь Үндсэн эрхүүдийн суурь эрхүүд нь Локкийн хэлж сүүлд багагүй эрдэмтэн судлаачдын хүлээн зөвшөөрснөөр “Хүн бүрийн төрөлхөөсөө амьд явах, халдашгүй байх, өмчлөх гэсэн заяамал эрхүүд юм” /Бастиа ч бас ингэж үзэж байв/⁹ Эдгээр эрхийн нэгдмэл зүй ёсны байдал нь хүний нэр төр (буюу эрхэмсэг оршихуй)-өөр илэрхийлэгдэж хамгаалагддаг. Энэ ч утгаараа ХХ зууны үед үндсэн эрхийн үндэс нь хүний эрхэмсэг оршихуй гэсэн санаа нэлээд дэлгэрсэн ба орчин үеийн либераль ардчилсан төрүүдийн Үндсэн хуулинд уг санаа бэхжигдсэн юм¹⁰. Тухайлбал, ХБНГУ-ын Үндсэн хууль (1949) чухамхүү энэ эрхээр эхэлдэг ба түүний 1 дүгээр зүйлд “Хүний нэр төр халдашгүй байна. Түүнийг хүндэтгэх ба хамгаалах нь төрийн бүх эрх мэдэлтний үүрэг мөн”¹¹ гэсэн байдаг.

Дүгнэх нь

Хүн төрөлхтөн хамтаар амьдарч, оюун ухаан бий болсон цагаас эхлэн хүний эрхийн тухай асуудал хөндөгдөж эхэлсэн бөгөөд маш олон саад бэрхшээлийг даван туулсны эцэст Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдан хүний төрөлхийн буюу зүгээр л оршин байгаагийнхаа хувьд эдлэх тэрхүү эрхүүдийг зарлан тунхагласан юм. Энэ нь эрх чөлөөг эрхэмлэдэг, хүний эрхийг дээдэлдэг улс бүрийн Үндсэн хуулинд тусгалаа олсоор өдгөө дэлхий дахинд хүний эрхийг төгс биш ч түүхэн дэх хамгийн ихээр хамгаалж буй цаг үеийг бидэнд авчраад байна. Ингэхээр Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь хүний эрхийн баталгаа мөнөөс мөн болж таарах нь.

⁸ Пан Ги Мун. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 60 жилийн ойн тусгай дугаар. УБ., 2008. II дах тал

⁹ Claude-Frederic Bastiat. The Law. /www.bastiat.com/

¹⁰ Сарантуяа Ц. Эрх зүй сэтгүүл №1/2. Үндсэн эрх болон хүний эрх: харьцуулалт, онолын эргэцүүлэл. УБ., 2000. 19 дэх тал

¹¹ Ведомство печати и информации федерального правительства. Основной закон Федеративной Республики Германия. 13 дахь тал.

“ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ- ХҮНИЙ ЭРХИЙН БАТАЛГАА БОЛОХ НЬ”

А.Онон МУИС-ийн ХЗС-ийн оюутан

Тэртээ дайны жилүүдэд хүмүүс айдас хүйдэс, аюул заналхийлэл дунд эрхийнхээ төлөө тэмцэх тэнхэлгүй байсан хэдий ч хүнд хэцүү байдал нь эргээд хүмүүст хүч чадал, урам зоригийг өгсөн байж болох юм. Энэ бүхнийг даван туулахын тулд хүний эрхийн төлөө тууштай тэмцэгчдийн зүгээс сэтгэл, хүч, зориг шаардан уг тунхаглалыг зохиосон бөгөөд агуулгын хувьд энэ нь хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн үнэтэй эрдэнэсийн сан юм. Нас хүйс, арьс өнгө, шашин шүтлэгээр ялгаварлахгүйгээр хүн бүр энэ эрдэнэсийн хишгээс хүртэх учиртай. Тиймээс НҮБ-д гишүүнээр элссэн улс орон бүр өөрсдийн үндсэн хуулиндаа уг тунхаглалд тусгагдсан хүний салшгүй эрхүүдийн тухай зааж өгсөн байдаг. Манай орны хувьд бодит байдал дээр эдгээр эрхүүд байнга зөрчигдөж байдаг бөгөөд энэ нь эрхийн хамгаалалтын системд дутагдал байгаатай холбоотой гэж би боддог. Ингээд бидний амьдралд элбэг тохиолддог хэдэн жишээ дурдъя.

Хэрвээ хүн бүр хоорондоо ахан дүүсийн ёсоор харилцаж, бие биенээ үргэлж хайрлан хүндэтгэх аваас амьдрал өөрөө аз жаргал, гэрэл гэгээгээр дүүрэн байх болно. Алдрын оргилд хүрсэн хүмүүст атаархаж суухын оронд илүү ихийг ерөөж урамшуул. Архин далайд живж яваа ядруухан хүмүүсээс жигшиж цэрвэхийн оронд ийм байдалд орох болсон шалтгааныг нь ойлгож сургамж ав. Дээрхийн гэгээн 14-р Далай лам “Монгол ахан дүүс минь архиа бага ууж, айргаа таваар ууцгаа” гэж эртнээс сургамжилснаас үзэхэд өнөөгийн Монгол орны хэтэрсэн архидалтыг урьдаас олж харсан бололтой. Сэтгэлийн тэнхээ муутай, амьдралын боломж нөхцөл доогуур, ар гэрийн анхаарал халамж дутуухан зэрэг шалтгаануудаас хамаарч олон хүн архинд орж байгаа нь харамсалтай.

Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууцад хэн ч болов халдах эрхгүй байдаг.

Гэтэл бидний өдөр тутмын амьдралд энэ эрх зөрчигдөж л байдаг. Автобусанд суугаад мессеж бичиж байхад ард суугаа хүмүүс түүнийг нь хамт уншилцаад л. Энэ нь магадгүй монгол хүний хэрэгт дуртай зангийн нэгээхэн илрэл байж болох ч бүдүүлэг хэрэг гэдэг нь ойлгомжтой. Эгэл жирийн амьдрал ихэнхдээ сайхан байдаг. Учир нь хүн хэдий чинээ алдартай байна, төдий чинээ ачааг нуруун дээрээ үүрдэг. Хамгийн энгийн жишээ дурдахад л дэлхийн хэмжээний од болох Бритни Спирсийн хувийн амьдрал бол зарим сэтгүүлчдийн хоолоо олж идэх хэрэгсэл болчихоод байна. Хүн л болсон хойно байнгын мөрдлөг мөшгилтөөс залхаж бухимдлаа тайлах гэсэн үйлдлийг нь жигшүүртэй мэт болгож бичээд нэр хүндийг нь унагааж байна. Угтаа бол тэдгээр хүмүүс чинь бидний

л нэгэн адил эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй шүү дээ.

Хүн бүр ямар ч алагчлалгүйгээр адил хэмжээний хөдөлмөрт адил хэмжээний шан хөлс авах эрхтэй. Бодит байдал дээр энэ эрх биеллээ олж чаддаг болов уу? Энэ асуултанд "тийм" гэж итгэлтэй хариулах хүн олдохгүй байх. Өөрт тохиолдсон нэг жишээг дурдъя. Ээж аав хоёр маань намайг одоо хүртэл балчир хэвээрээ гэж боддог. Учир нь би ажил хийх хүсэлтэйгээ илэрхийлэхэд тэд нааштай хариу өгдөггүй юм. Гэвч би амьдралдаа ганцхан удаа цагийн ажил хийж үзсэн бөгөөд тэндээс би маш олон зүйлийг мэдэрсэн. Ангийнхаа хэсэг хүүхдүүдтэй нэгэн хэвлэлийн компанид оройн 22 цагаас өглөөний 8 цаг хүртэл цаас зүсч, хооронд нь нааж, эвхэж бэлэн болгох ажил хийсэн юм. Тэр өдрийн төлөвлөгөөнд 12000 цаас бэлтгэх байсан хэдий ч ууртай зохион байгуулагчийн шахалтаар төлөвлөгөөг нь даван биелүүлж 25000 цаас бэлтгээд шөнөжин ажиллаад ядарсан бид нар урамшуулал бүхий овоо их мөнгө горьдож байтал хүн бүрт 5000 төгрөг өгчихөөд л хаалгаа цоожилчихсон. Урам зориг маань хугарах шиг болсон ч өөрийн хөдөлмөрөөр олсон мөнгө ямар үнэ цэнэтэй гэдгийг ойлгосон. Үүнтэй адилаар дэлхий даяар хэчнээн хүн хөлснийхөө дуслыг дутуу үнэлүүлж, өөр хэн нэгний дарамтан дор чичрэн бөхөлзөж явааг би таашгүй.

Түүнчлэн өдөр ирэх тусам хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо нэмэгдсээр байгаа бөгөөд түүгээр ч зогсохгүй хамгийн ядуу улс болох Африкийн хүүхдүүд бэлгийн мөлжлөгийн золиос болсоор байна. Энэ бүхнийг таслан зогсоох, аль эсвэл цааш нь дэвэргэх эсэх нь гагцхүү хүмүүс биднээс л шалтгаална.

Уг тунхаглалд "Хүн сурч боловсрох эрхтэй бөгөөд наад зах нь ерөнхий боловсрол үнэ төлбөргүй байвал зохино" гэж заасан нь манай улсын үндсэн хуулинд ч мөн тусгалаа олсон байдаг. Түүнчлэн "хүүхэддээ олгох боловсролын чиглэлийг сонгоход эцэг эх давуу эрх эдэлнэ" гэсний дагуу хүүхдээ ямар сургуульд оруулах нь эцэг эхээс ихээхэн шалтгаалдаг. Ерөнхий боловсролыг үнэгүй олгодог улсын сургуулиудаас гадна боловсролын үйлчилгээ үзүүлснийхээ хариуд их дээд сургуулийн сургалтын төлбөртэй тэнцэхүйц хэмжээний төлбөр авч, ашиг олдог "хувийн" гэх тодотголтой сургуулиуд гарын арван хуруунд багтахад больсон билээ. Үндсэн эрхээрээ үнэгүй олж авах боловсролыг өчнөөн мөнгө төлж сурчихаад гурвалж суугаад арай ядан мэдлэг олж авч байгаа жирийн сургуулийн хүүхдүүдээс илүү гарах зүйлгүй бол даанч харамсалтай.

Би эрх зүйч мэргэжлээр суралцаж байгаа болохоор гэмт хэрэгт сэжиглэдэн түр саатуулах газар саатуулагдаж байгаа хүмүүсийн, ялангуяа хүүхдийн эрх хэрхэн зөрчигддөг тухай мэдээллийг олонтаа сонссон. Жишээлбэл: Хүйтэн цементэн шалан дээр унтахад доороос нь хайрдаг бөгөөд тэнд арай удсан зарим нь шинээр орж ирсэн хүүхдүүдийг ор болгон ашиглаж дээр нь хэвтдэг тухай, бусдын нулимсан шүлсийг долоож доромжлуулдаг тухай гэх мэтчилэн хүний эрх байж боломгүйгээр зөрчигдсөөр байна. Үүний уг үндэс нь хүмүүсийн ухамсар гэр бүлийн хүмүүжил юм. Хайраар бялхаж, аз жаргалаар гэрэлтсэн

тийм гэр бүлд хүмүүс тайван амгалан байж, өөрийгөө өв тэгш хөгжүүлэх боловсролыг олж аван, улмаар өөрсдийн хүсэл зоригийг хангалттай илэрхийлж чадах төлөөлөгчдийг зөв сонгож, ирээдүйдээ үнэтэй хувь нэмэр оруулж чадна гэдэгт би итгэдэг.

2008 оны УИХ-ын сонгууль шударга явагдсан эсэх нь эргэлзээтэй. Иргэдийн сонголтыг гуйвуулж, бусармаг аргаар төрийн эрхэнд гарна гэдэг гутамшиг. Үүний эсрэг ард түмний бухимдал үнэхээр ширүүн илэрсэн бөгөөд тэр завшаанаар далимдуулсан хүмүүс ч олон бий. 7-р сарын 1-ний тэр үймээнээс хохирсон хүмүүс олон бөгөөд баривчлагдан саатуулагдсан хүмүүсийн ар гэрийнхнээс гадна галт зэвсэг хэрэглэсэн хэмээн сэжиглэгдэж байгаа цагдаагийн ажилтнуудын сэтгэл зүйн дайралтанд мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нар автах ёсгүй байдаг. Гэвч өлсгөлөн зарлаж өөрсдийгөө зовоон, эсвэл зулын гол болж биеэ шатаана гэж сүрдүүлж байгаа нь төрийн албан хаагчдын сэтгэл зүй болон дотоод итгэлд тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа нь дамжиггүй. Энэ асуудлыг гадны ямарваа нэг нөлөөлөлд автахгүйгээр зөв, хариуцлагатай шийдвэрлэнэ гэж найдъя.

Ганцхан тохиох хүний энэхэн амьдралд “Миний эрх, эрх чөлөө үргэлж бусдын эрхээр хязгаарлагдаж, тэдний эрхийг хүндэтгэснээр миний эрх хамгаалагдана” гэдгийг ухамсарлаж, хүн та өөрөө эрүүл, аюулгүй, хүний эрхийн баталгаа хангагдсан тийм орчин, тийм ирээдүйг бүрдүүлэхийн төлөө зүтгэж, эрхийнхээ төлөө гар өргөн нэгдэгтүн. Магадгүй та бид үүнээс ч илүү ихийг хийж чадна. Яг одооноос эхлээд хамтдаа зүтгэцгээе.

“ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ- ХҮНИЙ ЭРХИЙН БАТАЛГАА БОЛОХ НЬ”

П.Баттулга МУИС-ийн ХЗС-ийн оюутан

Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй./ХЭТТ 3-р зүйл/

Нэгэн их сэтгэгч¹ “Хүн гэж хүсэл эрмэлзлэл бүхий субъект, оюун ухаант амьтан болохынхоо хувьд сэтгэх хийгээд үйлдэх чадвартай юм. Энэ ч учраас ертөнц дээрх хамгийн гол зүйл нь хүн юм. Иймд хүний эрх халдашгүй ариун байх ёстой” гэж хэлжээ. Өнөө цаг үед төрөлхөөсөө бид халдашгүй, чөлөөтэй, ижил тэгш эрхтэй байхаар төрдөг бөгөөд төр засаг бидний эрх, эрх чөлөөг хязгаарлах бус харин хууль ёсны болгон баталгаажуулах үүрэгтэй юм байна гэдгийг соёлт хүн төрөлхтөн нэгэнт ойлгодог болжээ. Хэдийгээр хүн төрөлхөөсөө эрх, эрх чөлөөтэй боловч хүний эрх хэмээх ойлголт, хөдөлгөөн нь түүхэн үзэгдэл мөн хэмээн ном, зохиолд олонтаа дурддаг билээ. Тийм ээ. Хүн төрөлхтний түүх нь хүний эрхийн хөгжлийн түүхтэй салшгүй холбоотой бөгөөд эдүгээ хүртэлх дэлхийн түүх

¹ Германы сонгодог философийг үндэслэгч И.Кант

нь хүмүүсийн эрх чөлөөний төлөөх тэмцлийн түүх байсан юм хэмээн бид нүүр бардам хэлдэг билээ. Энэ тэмцлийн үр дүнд “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” хэмээх нэн чухал баримт бичиг бий болсон билээ. Нэн чухал гэсний учир юу вэ?

Аливаа зүйлийн утга, агуулга, зорилгыг сайтар судалж мэдье гэвэл түүнийг төрүүлсэн эх, үндсийг сайн мэдэж авах ёстой гэсэн үг бий.

Түүхийг сөхвөл хүн төрөлхтний ихэнх нь боолын нийгмийн үед эзний өмч, ярьдаг багаж, хэрэгсэл хэмээн үзэж түүний хувь заяа зөвхөн эзний мэдэлд байв. Феодалын нийгмийн үед ихэс дээдсүүдийн хамжлагат иргэн, хадмал зарц нь байв. Тэгвэл социалист нийгмийн үед төлөвлөлтийн үзэл санаагаар төргүй, ижил тэгш амьдралтай нийгмийг байгуулна гэсэн удирдагчдын утопи үзлийн уршгаар ажлын машин мэт зүтгэж байв. Энэ хугацаанд хүний эрхийг төрийн бодлогын түвшинд авч үзэж байгаагүй учраас хүний эрх, эрх чөлөө маш ихээр зөрчигдөж, бүр төрөөс түүнийг хязгаарлаж байв. Гэхдээ иргэншлийн хөгжлийн явцад хүн төрөлхтний эрх, эрх чөлөөний төлөөх эрмүүн тэмцлийн үр дүнд хүмүүсийн зан үйлийг хатуу дэг журмаар хязгаарлах явдал багассаар ирсэн юм.

Хөгжлийн явцад хүний эрхийн үзэл санааг үндсэн хуулийн хэмжээнд өргөмжилсөн олон баримт бичгүүд² гарч тэрхүү баримт бичгүүдэд тусгагдсан үзэл санаа цааш дэлгэрч олон орны үндсэн хуулиудад тусгалаа олжээ. Гэвч хүний эрхийн асуудал нь XX зууны II хагас хүртэл улс гүрнүүдийн дотоод асуудал хэвээр байж өөрийн иргэддээ ямар эрх эдлүүлж, үүрэг хүлээлгэх нь тухайн орны бүрэн эрхийн хүрээнд байв. XX зуун гарч түүхэнд үгээр илэрхийлшгүй гай зовлон учруулж, хэдэн арван сая хүний амь насыг авч одсон дэлхийн хоёр том дайн гарсан нь хүний эрхийн асуудал зөвхөн нэг улсын дотоод асуудал байх нь хангалтгүй юм байна гэдэгт хүн төрөлхтөн улам итгэлтэй болсон юм. Иймээс хүний эрхийг хамгаалах олон улсын механизм, түгээмэл тогтолцоог бий болгох үүднээс дэлхийн нөлөө бүхий гүрнүүд санаачлан 1945 оны 6 дугаар сарын 25-нд Нэгдсэн Үндэстний Байгууллага/цаашид НҮБ гэх/-ыг үүсгэн байгуулсан түүхтэй. Энэхүү түгээмэл тогтолцооны гол цөм нь 1948 оны 12 дугаар сарын 10-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргасан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” юм. Энэ ч үүднээс Түгээмэл тунхаглалын оршил хэсэгт хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, дээдлэх нь шударга нийгмийг байгуулах үндэс хэмээн, улс гүрнүүдийн хооронд найрсаг харилцааг бий болгож, хүмүүс эзэрхэг засаглалын эсрэг өөрийн эрхгүй зэвсэглэн босгохгүйн тулд гишүүн улсууд НҮБ-тай хамтран хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндлэн сахих, нийтээр нэг мөр ойлгож, хуулиар хамгаалж, баталгаажуулах нь нэн чухал гэж заасан юм.

² 1789 оны Францын “Хүний ба Иргэний эрхийн тухай тунхаглал”, 1791 оны АНУ-ын “Хүний Эрхийн Билл” г.м.

Хүн гэдэг амьтан энэ дэлхий дээр айх аюулгүй, амар тайван, гачигдах зовлонгүй амьдрахаас өөр юуг хүсэх билээ дээ. Хүний эрх хэмээх ойлголт нь хүний өөрийнх нь мөн чанараас урган гарсан, түүнийг хэн нэгэн бидэнд өгөөгүй юм бол түүнгүйгээр бид амьдарна гэдэг хоёр нүдээ таглачихаад юм харна гэж зүтгэхтэй адил хэрэг бус уу? Ийм учраас хүний эрхийг хуулиар хамгаалж, баталгаажуулах үүргийг төр засаг бидний өмнө хүлээх ёстой болдог. Гэвч төр бидний хамгийн наад захын эрх болох амьд явах эрхийг маань зөрчиж байдаг. Иймээс ард түмний хүсэл зориг нь засгийн эрх мэдлийн үндэс байж, хүн бүр шууд, чөлөөтэй саналаа өгөх замаар улсаа удирдахад оролцох эрхийг Түгээмэл тунхаглалд заасан байдаг³. Бид сайн сайхан амьдрал гэж юу болох тухайд бүрэн дүүрэн хариулт өгч чадахгүй ч гэлээ тэрхүү амьдралд хүрэх угтвар нөхцөл нь бид эрхээ эдэлж чадаж байна уу? гэдгээс хамаарна гэдэгтээ маргах хүн байхгүй биз ээ. Гэсэн ч Хүний эрхийн түгээмэл тунхаглал дан ганцаар хүний эрхийн баталгаа яаж болж чадахгүй гэж эсэргүүцэх хүн гарах байх. Би тэгж хэлж байгаа хүнийг буруу хэлж байна гэж хэлэхгүй. Гэхдээ би тэр хүнд бид эрх, эрх чөлөөгөө бүрэн эдэлж чадах нь эргэлзээтэй хэдий ч гүн ухаантан Сенекагийн хэлсэнчлэн “Бүх хүн эрхийг ашиглаж байгаад бус бүх хүнд эрх олгогдсонд эрхийн тэгш байдал оршдог” юм бол Хүний эрхийн түгээмэл тунхаглал бий болсон нь хүн бүрт энэ эрх, эрх чөлөөг ижил тэгш байдлаар олгогдсон юм. Харин Түгээмэл тунхаглалд тусгагдсан хүний эрхийн үзэл санааг цааш дэлгэрүүлж, дархлаажуулахын хирээр бидний хүсэн тэмүүлж буй хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн дэглэмийг дэлхий нийтээр бий болгосноор энэ нь бодит байдал дээр утгажиж эхэлдэг гэдгийг буурал түүх бэлхнээ харуулжээ.

Түгээмэл тунхаглалд тусгагдсан үзэл санаанууд нь шинээр тусгаар тогтносон болоод ардчилсан тогтолцоо руу шилжиж буй орнуудын хувьд Үндсэн хуулиа боловсруулахад нь гол эх сурвалж, үзэл баримтлал нь болсон төдийгүй түүний үзэл санааг дэлэгрүүлсэн олон гэрээ, конвенцууд батлагдан гарч улс орнууд түүнд нэгдэн орж дагаж, мөрдөж байгаа нь хүний эрхийн асуудал дэлхий нийтээр даяарчлагдахад шийдвэрлэх алхам болсон юм. Нөгөө талаар Үндсэн хуульт ёс хөгжихөд ихээхэн хувь нэмэр оруулсан юм.

Эцэст нь эртний Грекийн гүн ухаантан Аристотелийн “Бид уг зүйлийн зорилгыг сайтар мэдэж чадах аваас ямар үед тухайн зорилгоо хамгийн сайн гүйцэтгэдгийг амархан тогтоох боломжтой” хэмээн хэлснийг эргэцүүлвээс Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал нь нийгмийн гишүүн бүрийг жаргалтай сайхан амьдруулахын тулд хүний эрхийг нэн тэргүүнд тавигдах ёстой асуудал болгоод түүнийг хэрэгжүүлж, хамгаалах л зорилготой юм байна гэсэн ядмагхан дүгнэлтээр бичиж буй зүйлээ төгсгөө дөө.

³ Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал 21-р зүйлийг үзнэ үү.



НҮБХХ нь мэдлэг, туршлага, нөөцийг холбож, улс орнуудын өөрчлөлтийг олон нийтэд хүргэх замаар илүү сайн сайхан амьдралыг цогцлон байгуулахад хүмүүст туслах зорилго бүхий НҮБ-ын дэлхий нийтийн хөгжлийн сүлжээ юм.

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

Улаанбаатар хот, Эрх чөлөөний талбай
Засгийн газрын XI байр, 5 дугаар давхар

Утас: 262902, 262589

Факс: 262786

Цахим шуудан: info@mn-nhrc.org

Цахим хуудас: www.mn-nhrc.org